2009 оноос Зээлийн батлан даалтын сан нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын зориулалтаар арилжааны банкнаас авах зээлд баталгаа гаргаж эхэлжээ. Уг байгууллага нь ЖДҮ эрхлэгчдийн экспортын гэрээ, шинэ технологи, өсөх ирээдүйтэй бизнес төлөвлөгөө зэрэгт үндэслэн зээлийн баталгаа (зээл авах эрх) гаргаж өгдөг. Энэ нь барьцаа хөрөнгөгүй ААН үүдэд үйлдвэрлэлээ тасралтгүй явуулах боломж олгох бөгөөд, шинээр эхэлж буй бизнест эргэлтийн хөрөнгө болж өгдөг байна. Хүсэлт гаргасан ААН-ийн бодит үнэ цэн, санхүүгийн чадвар, технологийн түвшин, бизнесийн ирээдүй, хүний нөөцийн чадвар зэргийг үнэлж, зээлжих зэрэглэлийг тогтоосны үндсэн дээр зээлийн баталгаа гаргадаг. ААН нь зээлийн баталгаанд үндэслэн арилжааны банкнаас зээл авч үйлдвэрлэлээ хэвийн явуулах боломж бүрддэг байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар тус байгууллага 10.000 ААН-ийн 4 их наяд воны зээлд баталгаа гаргажээ³².

³¹ [중소벤처기업진흥공단 \(kosmes.or.kr\)](http://kosmes.or.kr)

³² [문서뷰어 \(kodit.co.kr\)](http://kodit.co.kr)

Экспортын даатгалын үйлчилгээ 1990-ээд оноос дорвитой нэмэгджээ. БНСУ дэлхийн худалдааны байгууллагад элсэж гадаад худалдаа тус улсын хувьд харьцангуй нээлттэй болохын өмнө буюу 1992 онд Засгийн газраас үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулж, худалдааны даатгалын үйлчилгээг өргөжүүлэх үүднээс төрийн өмчийн Худалдааны даатгалын корпорацийг байгуулжээ³³. Ийнхүү гадаад худалдаанаас үүдэн гарах үйлдвэрлэгчдийн өндөр эрсдэлийг төр үүрэх болов. Тухайлбал даатгалын үйлчилгээний алдагдал 1992-1994 онд 187%, 2003-2004 онд 325% хүрч байв.

Хүснэгт 1. БНСУ-ын худалдааны даатгалын мэдээлэл

years	export values (A)	insured amount (B)	premium received (C)	claims paid (D)	recoveries (E)	utilization ratio (B/A:%)	loss ratio (D/C:%)
1974-1976	182.5	1.5	0.01	0.01	0.00	0.8	41.4
1983-1985	1,053.9	42.5	0.28	0.06	0.01	4.0	22.1
1989-1991	2,115.2	49.6	0.14	1.55	0.02	2.3	1,082.9
1992-1994	2,705.8	118.2	0.77	1.45	0.11	4.4	187.9
2003-2004	4,481.2	970.4	2.12	6.90	1.75	21.7	325.2
2008-2009	8,065.0	2,444.1	5.94	7.14	2.57	30.3	122.2

Эх сурвалж: Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, *Journal of World Trade*, February 2006.

1968-1990 онуудад нийт экспортын 4 хүрэхгүй хувь нь даатгалд хамрагдаж байсан бол Худалдааны даатгалын корпораци байгуулагдсанаас хойш энэ тоо өсч 2009 он гэхэд 30 хувьд хүрчээ. Уг байгууллага өнөөгийн байдлаар нь экспортын даатгал, импортын даатгал, валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлээс сэргийлэх даатгал, хөрөнгө оруулалтын эрсдлийн даатгалаас гадна хамтран ажиллахаар зорьж буйг гадаад компанийн санхүүгийн чадварыг судлах зэрэг үйлчилгээг үйлдвэрлэгчдэд үзүүлж байна. Тус байгууллага 2022 онд 238 ихнаяд воны худалдаанд даатгалын үйлчилгээ үзүүлжээ³⁴.

Эдийн засгийн огцом өсөлтөөс үүдэн экспортод чиглэсэн үйлдвэрлэлд үзүүлж ирсэн татварын ялгавартай дэмжлэгээ 1990-ээд оноос огцом бууруулжээ. 1995 оноос тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон энэ чиглэлийн судалгаа хөгжүүлэлтийг татвараар дэмжиж эхлэв. 2005 оноос эдийн засгийн чөлөөт бүс дэх гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэгчдийг эхний 10 жилд орлого болон ашгийн татвараас чөлөөлөх болов³⁵. Өнөө цагт БНСУ-д үйлдвэрлэгчдийг аливаа нэг татвараас бүрэн чөлөөлөх явдал үгүй болсон боловч Татварын тусгай хуулийн /조세특례제한법/ дагуу

³³ [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](http://ksure.or.kr)

³⁴ [Annual Report 2022.pdf](#)

³⁵ Finance Forum, “Updating the Tax Regulations”, Korea Institute for Public Finance: Seoul, 2003.

үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлж байна. Уг хуулийн дийлэнх зүйл заалт нь ЖДҮ эрхлэгчдийг дэмжихэд чиглэдэг. Тухайн аж ахуйн нэгж ЖДҮ эрхлэгчийн ангилалд хамрагдах эсэхийг тодорхойлсны үндсэн дээр шалгуур хангасан компанид Татварын ерөнхий газраас³⁶ холбогдох хөнгөлөлтийг үзүүлдэг байна.

Татварын тусгай хуульд ЖДҮ эрхлэгчдийг орлогын болон хуулийн этгээдийн албан татвараас хөнгөлөх нөхцлүүдийг тусгаж өгчээ. Тухайлбал шинээр үүсгэн байгуулагдсан цагаас хойш 5 жилийн хугацаанд орлого олоогүй ААН-ийг орлого олж эхэлсэн цагаас эхлэн 4 жилийн турш орлогын татварыг 50 хувь хөнгөлдөг байна³⁷.

Уг хууль хувь хүн болон ААН-ийн технологийн судалгаа, хөгжүүлэлтийг 3 үндсэн хэлбэрээр татвараар дэмждэг. Эхний хэсэг болох энгийн технологийг дэмжих журмын дагуу шинээр зохиож патентжуулсан, мөн зохих журмын дагуу бусдаас дамжуулж авсан технологийг ашиглан үйлдвэрлэл эрхэлж олсон орлогын татварыг ЖДҮ эрхлэгчид 50 хүртэл, том үйлдвэрлэгчид 40 хүртэл, корпорацид 25 хүртэл хувиар тус тус хөнгөлдөг байна. Хоёрдахь буюу орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих журмын дагуу хиймэл оюун ухаан, эрүүл мэнд, эрчим хүч, байгаль орчин гэх мэт 14 салбарын 270 төрлийн технологийн үйлдвэрлэлд, гуравдахь буюу Засгийн газраас заасан стратегийн технологийг дэмжих журамд хагас дамжуулагч, батерей, вакцин, хавтгай дэлгэц зэрэг 7 салбарын 66 төрлийн технологийн үйлдвэрлэлд тус тус татварын хөнгөлөлт үзүүлж байна³⁸.

Орон нутгийн татварын тусгай хуулийн дагуу хүн амын нягтрал багатай орон нутагт бүртгүүлсэн ЖДҮ эрхлэгч нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш 4 жилийн дотор худалдан авсан бизнесийн зориулалттай хөрөнгийн худалдан авалтын татварыг 75 хувь, 3 жилийн дотор хөрөнгийн татварыг 50 хувь тус тус хөнгөлдөг байна.

Экспортын зориулалттай түүхий эдийн импортын татварыг буцаан олгох тухай хууль³⁹ нь өнөөгийн байдлаар хүчинтэй үйлчилж байна. Уг хуулинд физик, химийн урвалын үр дүнд бүтэц найрлага, хэв шинж нь өөрчлөгдөн экспортын бүтээгдэхүүнд орсон бүх төрлийн түүхий эд, экспортын тоног төхөөрөмжид орсон түүхий эд, тэдгээрийн сав баглаа боодол зэргийн импортын татварыг буцаан олгож байна.

3. Экспортыг дэмжих явцад төрийн үүрсэн эрсдэл

Засгийн газраас экспортыг дэмжих явдал нь төрөөс ихээхэн зардал мөнгө, идэвхи санаачилга, хүчин чармайлт, хариуцлага шаарддаг басхүү ихээхэн эрсдэл дагуулдаг үйл ажиллагаа юм. Ялангуяа өсөлтийн шатандаа яваа, бие дааж амжаагүй шинэ үйлдвэрлэгчдийг экспортлогч болгож дэлхийн зах зээлд гаргана гэдэг нь өндөр эрсдэлтэй, нэг удаагийн арга хэмжээгээр үр дүн нь гарахгүй, үе шат

³⁶ [국세청 \(nts.go.kr\)](http://nts.go.kr)

³⁷ [조세특례제한법 \(law.go.kr\)](http://law.go.kr)

³⁸ [조세특례제한법시행령 \(law.go.kr\)](http://law.go.kr)

³⁹ [수출용 원재료에 대한 관세 등 환급에 관한 특례법 | 국가법령정보센터 | 법령 > 본문 \(law.go.kr\)](http://law.go.kr)

дамжин хэрэгждэг, нарийн түвэгтэй ажил байдаг аж. БНСУ-ын экспортыг дэмжих зоримог шийдэмгий бодлого хөтөлбөрүүдийн ард ихээхэн өндөр эрсдэл нуугдаж байв.

Тухайлбал их хэмжээний татварын дэмжлэг нь төсвийн орлогыг бууруулна. Ингэснээр Засгийн газар зардлаа танах шаардлага гарна. 1960-аад онд хөнгөн үйлдвэрлэл эрхлэгчдийн татвараас ихээхэн хөнгөлөлт үзүүлж байв. Гадаад валютын хомсдолтой, санхүүгийн хувьд хүндхэн байсан 1960-аад онд энэ нь тийм амар шийдвэр байгаагүй нь тодорхой.

Хүнд болон химийн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд үйлдвэрлэгчдийн гадаадаас авах зээлд Засгийн газар баталгаа гаргаж өгдөг байсан. Зээлийн хэмжээ асар өндөр дүнтэйн дээр гадаад валютын зээл нь ханшийн өөрчлөлтөөс үүдэн алдагдал хүлээх магадлал өндөр байжээ. Засгийн газар үйлдвэрлэгчдийн санхүүгийн эрсдэлийг үүрснээрээ тэдэнд өндөр итгэл үзүүлж байж.

Төрийн өмчит Худалдааны даатгалын корпорацийн үйл ажиллагаа нь үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг төр хариуцаж байсны том жишээ юм. Хувийн хэвшлээс хэрэгжүүлэх боломжгүй өндөр эрсдэл бүхий уг салбарт төр манлайлан оролцож үйлдвэрлэгчдэд экспортын боломжийг олгосон байна.

Аж үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх явцад ижил төрлийн бүтээгдэхүүний импортыг тарифын болон тарифын бус аргаар хязгаарлаж байв. Энэ нь шинэхэн үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилготой боловч нөгөө талаар тэдний гадаад зах зээл дээр өрсөлдөх чадварыг бууруулдаг аж.

Экспортын үйлдвэрлэгчдийг тусгайлан өндөр зардлаар дэмжсэнээр дотоодын үйлдвэрлэгчид орхигдох, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар муудах зэрэг дотоодын нийгэм эдийн засгийн хөгжил хойш тавигддаг байна.

Төрийн зүгээс эдгээр олон төрлийн эрсдэл үүрч, золиос гарган, тууштай, идэвхи санаачлагатай ажилласны үр өгөөж нь өнөөдөр бий болсон БНСУ-ын эдийн засгийн өндөр хөгжил, технологийн дэвшил, иргэдийн сайн сайхан амьдрал юм.

Дүгнэлт

БНСУ нь 1960-аад оноос хойшхи аж үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүдээр дамжуулан санхүү, татварын хэд хэдэн төрлийн дэмжлэгийг туйлын үр ашигтай хэрэгжүүлж иржээ. Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх төрийн мэрэгшсэн институцын тогтолцоо хараахан бүрдээгүй байсан учир харьцангуй цөөн төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлж байв. Татварын хөнгөлөлтийг энэ үеэс хэрэгжүүлж эхэлжээ.

Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой зэрэгцэн Солонгосын Эксим банк, Зээлийн батлан даалтын сан зэрэг мэрэгшсэн байгууллагууд үүсгэн байгуулагдаж санхүүгийн дэмжлэг өргөн цар хүрээг хамрах болж үр өгөөж нэмэгджээ. Энэ үед хүнд үйлдвэрлэл эрхлэгчдийг дотоодын болон гадаадын таатай нөхцөл бүхий хөнгөлөлттэй зээл, зээлийн баталгаа, экспортын даатгал зэрэг олон төрлийн аргаар тун дорвитой дэмжжээ. Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих үед үйлдвэрлэгчдийн ашгийн татварт хөнгөлөлт үзүүлдэг байсан бол энэ үед тодорхой хугацаанд ашгийн татвараас бүрэн чөлөөлөх болсон, мөн экспортын зориулалттай түүхий эдийн импортын татварыг буцаан олгож эхэлсэн байна. Эдгээр өргөн далайцтай, эрчимтэй дэмжлэгийн дүнд тус

улсын аж үйлдвэрлэлийн бүтэц хөнгөн үйлдвэрлэлээс хүнд аж үйлдвэрлэлд шилжиж, экспортын хэмжээ огцом хурдтай өссөн.

1980-аад оны дундаас тус улс тооноос илүү чанарын өсөлтийг эрхэмлэх болж, санхүү татварын дэмжлэг нь хүнд аж үйлдвэрлэлээс илүүтэй оюуны бүтээмж бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэж эхлэв. Өнөөгийн Засгийн газрын санхүү, татварын дийлэнх дэмжлэг нь ЖДҮ эрхлэгчид, мөн технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжихэд чиглэгдэж байна. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх төрийн мэрэгшсэн агентлагууд асар их туршлага хуримтлуулж, салбартаа мэрэгшиж тус улсын экспортод гол үүрэг гүйцэтгэх болжээ. Зээлийн баталгаа, худалдааны даатгал зэрэг үйлчилгээгээр дамжуулан үйлдвэрлэгчдийн зарим төрлийн санхүүгийн эрсдэлийг төр хариуцаж байгааг онцлох хэрэгтэй. Татварын хөнгөлөлтийн механизм нь Засгийн газраас нэр заан тогтоосон орчин үеийн дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэжээ. Энэ хүрээнд ЖДҮ эрхлэгчдэд тусгайлан таатай, давуу нөхцөл олгож байна. Мөн экспортын үйлдвэрлэлд орсон түүхий эдийн импортын татварыг буцаан олгох журам хэвээр үйлчилж байна.

Эх сурвалж

1. Lee, Jaymin, “Dynamic Comparative Advantage and Korea’s Industrial Policy”, p. 64 in Park and Wilkinson (1995).
2. [경제개발 5개년계획\(한국\) \(naver.com\)](#)
3. KEIC, Annual Report and Monthly Export Insurance, various issues; K-sure, Annual Report 2009, 2010 (2010b)
4. [경제개발계획 \(naver.com\)](#)
5. [중화학공업 \(naver.com\)](#)
6. Д.Мягмар, “БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд”, х.50-51, Олон улс судлал сэтгүүл, №16, 2023 он.
7. Jaedo Choi, Andrei A. Levchenko, The long-term effects of industrial policy, NBER Working paper 29263, 2022.
8. [Home : Korea Eximbank](#)
9. [신용보증기금 \(kodit.co.kr\)](#)
10. Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, Journal of World Trade, February 2006.
11. Finance Forum, “Updating the Tax Regulations”, Korea Institute for Public Finance: Seoul, 2003.
12. [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](#)
13. [중소벤처기업진흥공단 \(kosmes.or.kr\)](#)
14. [문서뷰어 \(kodit.co.kr\)](#)
15. [Annual_Report_2022.pdf](#)
16. [국세청 \(nts.go.kr\)](#)
17. [조세특례제한법 \(law.go.kr\)](#)

Implementing South Korean industrial technologies in Mongolia

Солонгосын технологийг Монголын зах зээлд нэвтрүүлэх нь

S.Delgermaa(M.A)

(International University of Ulaanbaatar)

delgermaa.s@ulaanbaatar.edu.mn

ABSTRACT

Technology plays a crucial role in the development of any country. This is because the process of development encompasses inevitable changes in society, which are closely related to the proper utilization of resources. The higher level success of individuals, organizations, and the economy is said to define the result of development, and this ultimately becomes the main driving force behind development. Thus, this research examined how developing countries facilitate sustainable growth by effectively implementing technology and the impact of Yanmal LLC, a company successfully introducing Korean industrial technology, on the Mongolian society and economy.

Хураангуй:

Технологи нь аливаа улс орны хөгжлийн үндэс суурь болдог. Учир нь хөгжлийн явц нь нийгэмд зайлшгүй гарах өөрчлөлтүүдийг агуулж байдаг ба энэ нь нөөцийг зөв ашиглахтай холбоотой. Хөгжлийн үр дүнг хүмүүс, байгууллага болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны харьцангуй өндөр түвшний чадамжуудын амжилтаар тодорхойлдог бөгөөд энэ нь үйлдвэрлэх гол хүч болж байна. Ийнхүү судалгааны ажлаар хөгжиж буй улс орнууд эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангахын тулд технологийг хэрхэн нэвтрүүлэх болон БНСУ-н аж үйлдвэрийн технологийг амжилттай нэвтрүүлж буй Янмал ХХК-н Монгол улсын нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судалсан.

Түлхүүр үг: технологи, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлт, нэмүү өртөг, технологи дамжуулалт, ноу хау

I. Удиртгал

Улс орнуудын хөгжил нь эдийн засгийн бүтцийн шилжилттэй холбоотой ойлголт бөгөөд бүтцийн шилжилт нь эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний боловсруулалтыг нэмэгдүүлэх, нөөцүүдийг (хөдөлмөр, капитал зэрэг) эдийн засгийн өндөр бүтээмжтэй үйл ажиллагаануудад шилжүүлэх зэрэгтэй хамааралтай.

Хөгжлийн үйл явцыг хэрхэн хурдасгах вэ? гэдэг нь хөгжиж буй орнуудын бодлогын гол асуудал бөгөөд аж үйлдвэржилтийн бодлого үүнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, аж үйлдвэржилтийн

бодлого нь Засгийн газрын оролцоо (дэмжлэг, тусламж, зохицуулалт зэрэг)-оор дамжуулан тодорхой зорилгын хүрээнд үйлдвэрлэлийн хүчин зүйлс, технологи, бүтээгдэхүүн, аж үйлдвэрүүд, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлөх замаар хөгжлийг хурдасгадаг (Alessio, Ancil, & Monika, 2022).

Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны багтаамж ихтэй, өндөр технологийг бий болгох, хөгжингүй улс орнуудын технологийг дамжуулах замаар эдийн засгийн өсөлтийг тогтвортой хангаж улс орныхоо хөгжлийг хурдацгах боломж бүрдэнэ

Дэлхийн бусад улс орнуудын хувьд эдийн засгийн хөгжлөө хурдасгахын тулд амжилттай хэрэгжсэн аж үйлдвэрийн бодлогын өмнөх үеийн туршлагыг судалж, тэдгээрт үндэслэн үйлдвэржилтийн бодлогоо тодорхойлсон байдаг. Үүнд, 18-р зуун болон 19-р зууны эхэн үед Их Британи улсын аж үйлдвэржилтийн бодлогоос АНУ, Герман улс, 19-р зууны сүүл үед Герман улсын бодлого, институтээс Япон улс, 20-р зуунд Япон улсын аж үйлдвэржилтийн бодлогын туршлагаас БНСУ болон БНХАУ суралцжээ (Ha-Joon, Dr, & Ming, 2013).

Мөн хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнууд 1930-аад оны сүүлээр Японы эдийн засагч Канаме Акамацугийн боловсруулсан технологийн “Галуу цувааны онол” Америкийн эрдэмтэн Р.Верноны “Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол”-ыг үндэслэн технологийн амьдралын мөчлөг онол, Оросын эрдэмтэн В.И.Мухопад “Технологын амьдралын мөчлөгийн онол” зэргийг зохистой ашиглаж чадсанаар улс орны хөгжил илүү хурдасан аж үйлдвэржиж чадсан байна.

Монгол улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн баялгийн арвин их нөөцтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс билээ. Өнгөрсөн 30 гаруй жилд Монгол улсын эдийн засаг хурдацтай өсөж, нийгэм, эдийн засгийн олон үзүүлэлтүүд сайжирсан хэдий ч байгалийн баялгийн оновчтой бус ашиглалт, технологийн шинэчлэлт, татвар болон зохицуулалтын таатай бус орчин зэрэг асуудлууд эдийн засгийн хөгжлийг хойш татаж байгаад анхааран бусад улс орны аж үйлдвэржилт болон технологийн туршлагыг судалж, оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой өргөн байна.

Энэхүү судалгааны ажлаар хөгжлийн суурь болсон технологи дамжуулалтын онол арга зүйн үндэслэл, Монгол-БНСУ-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн төлөв байдал, Технологи дамжуулалтыг нэвтрүүлснээр манай улсын нийгэм, эдийн засгийн үр нөлөөлөл зэргийг тодруулахыг зорилоо.

I. Судалгааны онол арга зүйн үндэслэл:

...Технологи гэдэг нь түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг урьдаас төлөвлөсөн нөхцөл, шаардлагын дагуу боловсруулах арга, үйлдвэрлэлийн ажиллагааг хэрхэн явуулах мэдэгдэхүүнүүдийн нэгдэл мөн.

Оросын эрдэмтэн А.Д.Бондаренко “Технологи нь байгалийн түүхий эдийг боловсруулж, үйлдвэрлэлийн хэрэгсэл ба хэрэглээний зүйлийг бий болгох арга, үйл явц (процесс)-ыг судалдаг шинжлэх ухаан болно” гэж тодорхойлон *агуулгын хувьд* өргөн хүрээнд авч үзсэн.

Эрдэмтэн Ю.П.Долгушев “Технологи бол төрөл бүрийн зүйлсийг үйлдвэрлэх үйл явц, процессыг судлах шинжлэх ухаан мөн” гэснээр *аргыг* судлахыг голчлон авч үзсэн байна.

Харин Америкийн судлаач Дж.Мартино “...технологийн мөн чанар нь түүнийг хэрэгжүүлэх аргад, хэлбэр нь уг аргыг биежүүлэх хэрэгслэлд оршино” гэж тодорхойлон *технологийн диалетик холбоог* гүнзгийрүүлэн авч үзсэн.

Монголын эрдэмтэн профессор Г. Гомбо технологийн хөгжлийн мөн чанарыг тандан судлаад “Технологи нь бүтээхүйн ур ухаан, шинжлэхүйн ухаан мөн” гэж тодорхойлсон байдаг. Бүтээхүйн ур ухаан нь өнөөдөр хөгжлийг тодорхойлох “үйлдвэрлэх хүч” болж байна.

Ер нь шинжлэх ухааны мэдлэг, чадвар эзэмшсэн “хүн” технологийн хөгжлийн “хөдөлгөгч хүч” гэдгийг онцгойлон авч үзэх ёстой. Үүнтэй уялдуулан “технологи” гэдэг ухагдахуун нь агуулга, бүрэлдэхүүний талаас:



Зураг-1. Технологи, түүний агуулга/мөн чанар/ ба бүрэлдэхүүн


Технологи бол хөгжлийн үндэс суурь болдог. Учир нь хөгжлийн явц нь нийгэмд зайлшгүй гарах өөрчлөлтүүдийг агуулж байдаг ба энэ нь нөөцийг зөв ашиглахтай холбоотой. Хөгжлийн үр дүнг хүмүүс, байгууллага болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны харьцангуй өндөр түвшний чадамжуудын амжилтаар тодорхойлдог. Хөгжлийн суурь технологийг бий болгохдоо дараах 4 үндсэн иж бүрдлийг эх үүсвэрээ болгон авах шаардлагатай гэж үздэг. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн орчин үеийн хэрэгслүүд
2. Техникийн чадамж, хүмүүсийн ур чадвар
3. Мэдлэгийн ашиглалт, цар хүрээ
4. Зохион байгуулалт болон удирдлагын чадвар

Технологийг хэрхэн эдийн засгийн нөөцүүдтэй харилцан уялдуулж эдийн засгийн өсөлтийг бий болгон хөгжлийн суурь болохыг судлаачид авч үзсэн байна.

ТЕХНОЛОГИ БА ЭДИЙН ЗАСГИЙН СИСТЕМ

Эдийн засаг ба технологийн агуулга, бүрэлдэхүүн нь хоорондоо нягт уялдан шүтэлцэж, бие биенээ нөхөн бүрдүүлж, дэмжин хөгжүүлж байдаг зүй тогтолтой. Энэ утгаараа-технологи, түүний дэвшлийн мөн чанар нь юуны өмнө оюун ухаан соёлын ба тухайн нийгмийн үйлдвэрлэл эдийн засгийн хөгжилтэй шууд хамааралтай байна.



Зураг -2. Технологи ба эдийн засгийн систем

Америкийн эрдэмтэн Р.Верноны “Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол”-ыг үндэслээд, технологийн амьдралын мөчлөг хэрхэн өөрчлөгддөгийг тодорхойлсон.


Нэг дэх үе шат. Шинэ технологийг бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. Уг технологийг хэрэглэснээр шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэгч нь монополь өндөр ашиг олно. Шинэ бүтээгдэхүүн харьцангуй ховор учраас түүний үнэ нь өндөр байдаг. Ийм ашигтай технологийг өмчлөгч пүүсүүд аль болох гадагш нь худалддаггүй.

Хоёр дахь үе шат. Уг технологи аажмаар тархаж тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг хэд хэдэн пүүсийн “олигополь” бий болж, тэдгээрийн хооронд өрсөлдөөн үүснэ. Улмаар бүтээгдэхүүний үнэ буурч эхлэх бөгөөд зардлаа хэмнэхийн тулд пүүсүүд үйлдвэрлэлийн хэмжээгээ эрс нэмэх болно. Ийм нөхцөлд дан дотоод зах зээл нэмэгдсэн таваарыг шингээж чадахгүй учраас түүнийг гадаадын зах зээлд худалдах болно. Ихэвчлэн 2-р үе шатанд технологи гадаадад шилжих, юуны өмнө технологийн багтаамж ихтэй, хөгжсөн орнуудын зах зээлд нэвтэрнэ (Статистикийн мэдээгээр авч үзвэл юуны өмнө хөгжсөн орнууд руу шилжиж байгаа технологийн хугацаа нь дунджаар 3-8 жил байдаг).

Гурав дахь үе шат. Тухайн таваарын зах зээл хангагдаж, өрсөлдөгч пүүсүүд капиталын зардлаа бууруулах нөөцөө дуусгана. Иймд үйлдвэрлэлээ ажиллах хүч хямд байдаг орнууд руу шилжүүлж болно. Энэ үед уг технологи хөгжиж буй орнууд руу нэвтэрнэ (Хугацаа нь дунджаар 10-25 жил байдаг).

Технологийн таваарын өвөрмөц шинжийг дээрх байдлаас авч үзвэл таваарын ашигт чанарыг, юуны өмнө, ховор шинж тодорхойлдог бөгөөд ховор шинж нь хугацаанаас хамаардаг байна.

Сүүлийн үед бид гадаадаас технологи авах талаар нэлээд их бичдэг болсон болохоор “тэргүүний”, “орчин үеийн”, “цоо шинэ” технологи гэдэг ойлголтын ялгааг 3-р зургаас харах боломжтой.



Зураг-3. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг

I үе – Шинэ санаа технологийн инкубаторт бойжих үе

II үе – Зах зээлд нэвтэрч, өрсөлдөх чадвар өсөх үе

III үе – Зах зээлд танил болж, хэрэглээ тогтворжсон үе

IV үе – Хэрэглээ хуучирч, зах зээлээс хумигдах үе (Энэ үед тухайн технологийг буурай хөгжилтэй, хөгжиж буй орнуудад шилжүүлнэ).


Орчин үеийн тэргүүний гэгдэж байгаа орнуудыг нэгдүгээрт «Түрүү хөгжсөн», хоёрдугаарт «Хожуу үйлдвэржсэн» гэж томъёолж байна.


- Түрүү хөгжсөн Англи, АНУ, Герман зэрэг орнуудад «шинэ технологи»-ийг бий болгоход түлхүү анхаарал тавьж иржээ.
- Хожуу үйлдвэржсэн Япон, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг орнууд технологи өндөр хөгжсөн орны бэлэн технологийг дамжуулан, мэдлэгийг шилжүүлэн авч боловсронгуй болгож чадсанаараа амжилтанд хүрч хөгжингүй улс орнууд болж чадсан байна.

Азийн орнуудын эдийн засгийн эрчимтэй хөгжлийн нууцад олон хүчин зүйл нөлөөлсөн боловч дараах 3 үндсэн хүчин зүйл чухал ач холбогдолтой байсан гэж үзсэн. Үүнд:

1. Эдийн засгийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой тэргүүний технологийг гадаадаас импортлох замаар нэвтрүүлсэн явдал.
2. Төрийн зохицуулалт чухал ач холбогдолтой байсан явдал.
3. Тус бус нутгийн ард түмний нөр их хичээнгүй хөдөлмөрлөх чадвар төвшсөн байдал.

Азийн орнуудын Технологийн импорт





Зураг -4. Технологийн импорт

1970-аад оноос Тайван, Гонконг, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг орнууд нэхмэл металлурги, цахилгаан техникийн үйлдвэрлэлийн технологийг Японоос импортолж эхэлсэн. Харин тэд 1980-аад он гэхэд технологи экспортологч орнууд болсон байна. Эдгээр орнуудын ахуйн цахилгаан техник, нэхмэл нефть, химийн үйлдвэрлэлийн технологийг Малайз, Индонез, Филиппин, Хятад, Вьетнамд нэвтрүүлж эхэлсэн.

Ийнхүү тэргүүний технологийг амжилттай нэвтрүүлэхэд:

- Шинэ технологийг нэвтрүүлж чадахуйц боловсролтой ажиллах хүч байсан.
- Ижил төстэй соёл, газар нутгийн ойр дөт байдал
- Хөрөнгө оруулагчдыг татах чадвар зэрэг нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.

Манай улс дэлхий тэргүүний технологийг шилжүүлэн хэрэглэх материал техникийн суурь, ажиллах хүчний чадвар, боломж нөхцөл зарим салбарт бүрэлдэж байгааг хэдий ч тийм хангалттай биш байна. Иймд юуны өмнө хямд, чанартай дундаж түвшний өргөн хэрэглээний таваарын технологийг дамжуулан авч, дотоодын зах зээлээ хангах, импортыг орлуулах, экспортын чадавхийг өсгөх замаар эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэн хөгжих боломжтой юм.

Судалгааны дараагийн хэсэгт Монгол Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагааны ерөнхий дүр төрх болон Монгол улсад БНСУ-н технологийг хөрөнгө оруулалтын хэлбэрээр нэвтрүүлэн нутагшуулан ажиллаж буй “ЯНМАЛ” ХХК ний Монголын улсын зах зээлд хэрхэн амжилттай ажиллаж байгаа талаар судалсан.

II.-СОЛОНГОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА:


Монгол Улс 1990 онд БНСУ-тай дипломат харилцаа тогтоосон бөгөөд тус улсын Засгийн газраас 1993-2018 онд манай улсад 130 сая гаруй ам.долларын хөнгөлөлттэй зээл, 200 сая гаруй ам.долларын буцалтгүй тусламж олгожээ

БНСУ-д одоогоор манай улсын 51 мянган иргэн амьдарч байгаагаас 37.7 мянга нь хөдөлмөр эрхэлдэг. Манай улс үйлдвэрлэж буй барааныхаа 2 хувийг БНСУ-д экспортолдог бол гадаадаас импортолдог барааны 4 хувийг тус улсаас авчээ. Харин БНСУ-ын 1816 иргэн манай улсад ажиллаж байна. Манай улсын Засгийн газар БНСУ-тай хамтран ажиллаж, Монгол Улсаас тус улсад гэрээгээр хөдөлмөр эрхлэх иргэдийг аж үйлдвэрийн салбарт ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа. Тухайлбал, манай улсын 36467 иргэн 2004-2018 онд БНСУ-д E9 буюу хөдөлмөрийн визээр ажиллаж

байсан бол одоо 4444 иргэн аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах иргэдийн квотыг нэмснээр өнгөрсөн онд 2400 гаруй хүн БНСУ-ыг зорьжээ.


Монгол иргэд БНСУ-д ажиллах нь хөдөлмөр эрхэлж орлоготой болохоос гадна тус улсын аж үйлдвэрийн салбарын туршлага, арга барилыг суралцаж буйгаараа ач холбогдолтой.

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ (2023 эхний 9 сар)



Зураг-5 Худалдааны бараа эргэлт

Хоёр улсын гадаад худалдааны эргэлт 2021 онд 532 сая, 2022 онд 702 сая гаруй ам.долларт хүрсэн байсан. Харин 2023 онд эхний 9 сарын байлаар 426.3сая ам долларт хүрсэн байна. Гадаад худалааны тэнцлээс харахад экспортонд уул уурхайн бүтээгдэхүүн 31,23%ийг эзэлж байхад импортод нефтийн бүтээгдэхүүн болон суудлын болон том оврын автомашин, бульдозер,авто хусуур, тэгшлэгч зэрэг машин механизм 25%ийг эзэлж байна.




Зураг-6. Экспорт, импорт-2023

БНСУ нь хөрөнгө оруулалтаараа Монгол Улсад чухал байр суурь эзэлдэг бөгөөд Монгол Улсад 2023 оны байдлаар 57.14517 сая ам долларын шууд хөрөнгө оруулалтыг хийсэн нь манай

улсын нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 2%-ийг эзэлж байна. Өнгөрсөн онд БНСУ-аас худалдаа, нийтийн хоол, мэдээллийн технологийн салбарт 18 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь манай улсын гадаадын хөрөнгө оруулалтын 0.7 хувийг эзэлж байгаа юм.

БНСУ-аас Монгол Улсад оруулсан шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (www.1212.mn)

БНСУ хөрөнгө оруулалт нь 2012 онд 56 сая ам долларт хүрч 2013 оноос буурсан нь дэлхийн эдийн засгийн гол үзүүлэлт болох инфляцийн түвшин, нийт бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, бизнесийн орчны тогтворгүй байдал зэрэг голлох нөлөө үзүүлсэн боловч 2023 онд эргээд 57 сая ам долларт хүрсэн нь эдийн засгийн хамтын ажиллагааны олон ажлыг эрчимтэй явуулсаны үр дүн юм.



Зураг-7. Солонгосын шууд хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл :


26,2%-г уул уурхайн салбарт, 12,8% барилгын салбарт 5,2% нь үйлдвэрлэлд буюу нийт хөрөнгө оруулалтын 44,2% нь бодит үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн байна. Харин 17,2% бөөний болон жижиглэнгийн худалдаанд, 5,10% эрүүл мэндийн салбарт буй нийт хөрөнгө оруулалтын 28,3% үйлчилгээний салбарт хийгдсэн байна. Мөн хөрөнгө оруулалтын 11,8% үл хөрөнгийн салбарт хийгдсэн нь үйлдвэрлэл үйлчилгээний газар болон объект худалдан авах түрээслэх, тоног төхөөрөмж оруулж ирэх зэрэг бизнесийн үйл ажиллагаанд зарцуулагдсан байна. Сүүлийн жилүүдэд технологи дамжуулалтанд мэдлэгийн менежментийг нутагшуулах явдал

нэмэгдэж байгааг БНСУ-с МУ-д мэргэжил, ШУ техникийн үйлчилгээ зэрэг 3.9%ийн хөрөнгө оруулалтаас харж болно.

Ийнхүү Монгол Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагаа н Монгол улсын хөгжилд ихээхэн ач холбогдолтой бөгөөд эдийн засгийн өсөлтийг тогворжуулахад бодит хувь нэмэр болно.

III. БНСУ-Н АЖ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛ УЛСАД НУТАГШУУЛЖ БУЙ ТУРШЛАГА

Монгол улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн баялгийн арвин их нөөцтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс билээ. Өнгөрсөн 30 гаруй жилд Монгол улсын эдийн засаг хурдацтай өсөж, нийгэм, эдийн засгийн олон үзүүлэлтүүд сайжирсан . Монгол Улсад эдийн засгийн өсөлтийг 2023-2024 онд хадгалагдана гэж АХБ үзэж байна



Зураг-8. Монгол Улсын эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн сэргэлт энэ онд үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт ойрын хугацаанд хадгалагдахаар байгааг Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банкууд шинэ тайланд онцолжээ. Эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт, экспортын сэргэлт, дотоод эрэлт дэмжихээр байгаа хэдий ч, өндөр инфляц, түүний эсрэг мөнгөний хатуу бодлого, дотоод санхүүжилтийн нөхцөл чангарсан зэрэг нь эдийн засгийг ялимгүй буурахад нөлөөлөн гэж үзсэн байна.

Манай улсын Эдийн засаг хурдацтай өсөж нийгэм, эдийн засгийн олон үзүүлэлт сайжирахад Төрөөс явуулж буй “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого” нь ДНБ-ийн өсөлтийг хангахад үндэсний үйлдвэрлэгчид чухал байр суурь эзэлдэг. Тэдний нэг БНСУ-с Монгол Улсад анх удаа оймс үйлдвэрлэх технологийг оруулж ирсэн “ЯНМАЛ”ХХК-н нийгэм, эдийн засагт оруулж буй үр дүнгийн талаар авч үзье.

БНСУ-н аж үйлдвэрлэлийн технологийг Монгол улсад нэвтрүүлсэн “ЯНМАЛ” ХХК

Үүсгэн байгуулагч Д.Лхагважав, Ц.Энхжаргал нар 1997-2005 оны хооронд БНСУ-д ажиллаж, хуримтлуулсан туршлагадаа үндэслэн Монголын анхны оймс үйлдвэрлэгч ”Янмал”ХХК-ийг 2005 онд даавуун болон ноосон оймсыг үйлдвэрлэн импортыг орлох үндэсний брендийг бий болгосон.

Анх БНСУ-с хоёр сүлжих машин, дагалдах жижиг тоног төхөөрөмжийг 20 гаруй мянган ам.доллараар худалдаж 50.000 ам долларын хөрөнгө оруулалт хийж үйлдвэрээ нийт 5 ажилчинтай, түүхий эдийнхээ 90 хувийг БНСУ, 10 хувийг БНХАУ-аас авч ажлын гараагаа эхэлсэн байна.




Зураг-9. Янмал үйлдвэрлэлийн технологи

Янмал ХХК нь технологи иновацийн өөрчлөлт шинэчилэлтийг тасралгүй хийж үйл ажиллагаагаа жилээс жилд өргөжүүлэн ажиллаж байна.

- 2005 онд-Янмал ХХК
- 2008 онд Монгол Оймс ХХК
- 2011 онд Тод Оймс ХХК
- 2017 онд Анхны экспортын гэрээ
- 2019 онд Ноос бэлтгэл сүлжиж 100тн ус цэвэршүүлэх АГИ ЦАГАА үйлдвэр
- 2021 онд WWX ХХК лаборатори
- 2022 он Сүүний ферм


ХАА-н нэмүү өртгийн сүлжээг бий болгож каластр үйлдвэрүүдийг байгуулсан. Энэ нь нэмүү өртөг шинэгсэн бүтээгдэхүүн бий болох ба ДНБ-ний үйлдвэрлэлийн тасралгүй бүрэн дүүрэн явуулах үндсэн нөхцөл болж байна. Ноос угаах үйлдвэр, ноос самнах үйлдвэр, самнасан ноосоороо утас ээрэх үйлдвэр, будаг оруулах үйлдвэр, оймс үйлдвэрлэх үйлдвэр гэх 5 кластер үйлдвэрийг шат дараалалтай байгуулан ажиллаж байна.



Схем-1. Үйлдвэрлэлийн үе шат

“Янмал” ХХК нь малчдын гар дээрээс түүхий ноос авч, угаах, самнах, ээрэх, будах дамжлагын үйлдвэрүүддээ эцсийн бүтээгдэхүүн болгодог бөгөөд өдөрт үндсэн 6 төрлөөс салаалсан 1000 нэр төрлийн 20 мянган хос цэвэр давуун, ноосон оймс, эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтай оймсны зах зээлийн 60 орчим хувийг хангадаг томоохон үйлдвэрлэгч болсон байна.

Одоо бол анх үүссэн янмал брендийн ажлын байр болон үйлдвэрлэлийн үе шат бүр маш их ялгаатай болсон байна.



Зураг-10. Оёдлын үйлдвэр

Ноос угаах үйлдвэр: 2019 онд ашиглалтанд оруулсан. Тус үйлдвэр нь 1 га талбайтай ба өдөрт 7 тонн ноос угаах хүчин чадалтай эмээлтэд байрладаг.



Зураг-11. Ноос угаах үйлдвэр

Оймсны үйлдвэр: 2015 оноос Бэлхэд өөрсдийн 2500м² хэмжээтэй үйлдвэрийн байраа барьж өргөжин одоогоор өдөртөө 1000 нэр төрлийн 20 000- 30 000 хос оймс үйлвэрлэх хүчин чадалтай, 88 сүлжих машин, 15 битүүлж оёх машин, 1 индүүний бүтэн систем, Трико болон оёдолын 8 машинтайгаар 150 хүнийг ажлын байраар хангаж, 24 цаг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг-12. Оёдлын үйлдвэр

Ээрэх үйлдвэр: АХБ-ны санхүүжилтээр Ноос ээрэх, самнах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж, 2018 оны 10 сард ашиглалтанд оруулсан. Самнасан ноосоороо утас ээрэх үйлдвэр 2800м² хэмжээтэй. Ноос самнах Польш машин 2 шугам, Италийн ээрэх машин 2 ш, утас ороох 36 толгой бүхий машинууд, холигч систем 1 ш, чийгшүүлэгчийн бүтэн систем, лабораторийн тоног төхөөрөмжүүдтэй, 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэрийн 24 цагын хүчин чадал нь 600 кг утас гаргах чадвартай.



Зураг-13. Ээрэх үйлдвэр

Самнах үйлдвэр: Мөн АХБ-ны санхүүжилтээр 2017 оноос барилгын ажил эхэлж 2018 он 8 сард ашиглалтанд орсон. Ноос самнах үйлдвэр нь 2800м² хэмжээтэй ба нийт 56 самнах машин зэрэг ажилладаг. Хялгас ялгах 4 шугам, 2 холигчын системтэй, чийгшүүлэгч системтэй, 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Хоногт буюу 24 цагын хүчин чадал 460 кг самнасан ноос гаргах хүчин чадалтай

Үндэсний том үйлдвэр Янмал бренд маань оймсны түүхий эдээ өөрсдөө боловсруулдаг гэдгээрээ маш том давуу талтай.

Цэвэр Монгол хонины ноосон болон тэмээний ноос, сарлагын хөөвөр, Солонгос даавуун утсаар хэрэглэгчиддээ зориулан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2018 оноос өөрсдөө шинээр ГИЗА брэндийг нэвтрүүлсэн бөгөөд дотоод хувцасны брэндүүд, загварын оймсны TWN socks, Socks factory зэрэг брэндүүдтэй хамтран ажиллаж байна. Гадаад зах зээл рүү Орос, Казахстан, Герман, Франц, Япон, Солонгос, Польш, Чех, Канад зэрэг улсууд руу сүүлийн 5 жилд 4.149.968.969 төг экспорт хийсэн.



Зураг-14. Бэлэн бүтээгдэхүүн

2023 оны 1 сарын байдлаар нийт 15-н салбар худалдааны цэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн И-март, Миний дэлгүүр, CU, GS25, IZI онлайн дэлгүүр, MGL-shopping дэлгүүр, Wellmart дэлгүүр, Oresh дэлгүүр, Наран март зэрэг сүлжээ дэлгүүрүүдтэй хамтран ажиллаж байна. Мөн Янмал оймсыг борлуулж буюу хувиараа эрхэлэгчид гэрээ-95, гэрээт бус 1000 байна.

Янмал оймсны үйлдвэр нь БНСУ-н аж үйлдвэрийн технологийг нутагшуулснаар Монгол улсын эдийн засаг бодит хувь нэмэр оруулж чадсан байна. Үүнд.

- Нийт хүн амын оймсний хэрэгцээний 60 гаруй хувийг дангаараа хангаж байна.
- Жилд 369.696.615 төгрөгийн татвар төлсөн. /2023 оны байдлаар/
- Жилд 383.424.200 төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийг татан төвлөрүүлсэн
- Шинээр 220 ажлын байрыг бий болгосон.
- Хөнгөн үйлдвэрийн салбарын сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 2% үйлвэрлэж байна.

Манай улс жилдээ 30 мянган тонн ноос ашигладаг бөгөөд тус үйлдвэр нь ХАА нэмүү өригийн сүлжээг бий болгосноор ноос бэлтгэх, нийлүүлэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах асуудлыг цогцоор нь шийдэж чадсан байна.

Дүгнэлт:

Өнөөдөр дэлхийн улс орнуудын хөгжлийн үндэс суурь нь эдийн засгийн өсөлтийг хангахуйц шинэ техник технологи, инновацийг бий болгон эдийн засгийн нөөцөө зөв оновчтой ашиглан нийгмийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангах явдал юм.

Ийм үед хөгжиж буй орнуудын хувьд хөгжингүй улс орнуудын аж үйлдвэрийн бодлогын туршлагыг судлан хөгжлийн түлхүүр болсон технологийн асуудалд анхаарлаа хандуулж технологийн мөн чанар, технологийн бүрдэлдэхүүн, технологийн үе шат, технологийн тархац зэргийг нарийвчлан судлан нутагшуулах нь эдийн засгийн өсөлт, эдийн засгийн хөгжлийг хангах чухал ач холбогдолтой.

Монгол улс нь эдийн засгийн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийн өсөлт харьцангуй тогтвортой байгааг Дэлхийн банкны тайлан мэдээнд дурьдсан байсан. Гэвч бид тайвирч болохгүй дэлхий нийтийн хөгжилтэй хөл нийлэхийн тулд эдийн засгийн хөгжлийг байнгын тасралтгүй сайжруулалт хийж байх нь чухал билээ.

Монгол улс нь дэлхийн улс орнуудтай улс төр, нийгэм эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж олон талт арга хэмжээ авч байгаагийн нэг томоохон ажлын нэг бол 2023 онд Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол-БНСУ хооронд хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны багийн санал гаргасан бөгөөд уг саналд манай орны гол 4 үндсэн салбарт технологийн олон ажлуудыг хийх саналыг тусгасан нь байна. Үүнд:

- А. Үйлдвэрлэлийн салбар
- Б. Эрчим хүчний салбар
- В. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны салбар
- Г. Аялал жуулчлалын салбар

Судалгаанд дурьдсан дэлхийн улс орнуудын туршлага, бодлого амжилттай хэрэгжих нь тухайн улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, байгалийн баялгийн нөөц, хүмүүн капиталын чадавх зэрэгтэй салшгүй холбоотой асуудал юм.

Бид өөрсдийн давуу талаа ашиглан Аж үйлдвэр тэр дундаа боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ноу хау, технологийн импорт хийж нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон улс оныхоо эдийн засаг, нийгэмд бодит хувь нэмэр оруулж байгааг үндэсний үйлдвэрлэгч Янмал ХХК жишээнээс харж болно.

Ашигласан маериал:

1. Robert C.Megantz Technology management 2002
2. Shukla P,R “Development industrialization and technology”1992
3. David A, “ The Techology of transition” 1997
4. Д.Ган-Очир. (2020). Эдийн засгийн төлөвлөлт, аж үйлдвэрийн бодлого: Бусад орны туршлагаас суралцахуй.
5. (www.koreaexim.go.kr) Солонгосын Эксим банк.
6. www.mfa.gov.mn
7. www.1212.mn
8. yanmal.info@gmail.com

Economic Policy and Legacy of Mongolian and Korean Presidents

Ерөнхийлөгчийн өв ба эдийн засгийн бодлого: Монгол улс, БНСУ-ын харьцуулсан судалгаа

J.Battur(Ph.D)

(National University of Mongolia)

battur_j@num.edu.mn

ABSTRACT

This study examined and contrasted the features of the economic policies of the presidents of the Republic of Korea and Mongolia with their respective development initiatives and programmes.

Furthermore, some case studies were employed to explore how South Korea's development experience may be applied to Mongolia's own development.

Mongolia's economic problems can be overcome by taking a cue from South Korea. And for this, it should be noted that the President and Prime Minister play a crucial role in this process. The five-year plan of South Korea, as well as government policies and economic planning, could be utilized.

Түлхүүр үг: эдийн засгийн бодлого, төлөвлөлт, төлөвлөгөө, туршлага, бүтээн байгуулалт

Эхлэл

БНСУ-ын ерөнхийлөгч нарын намтрыг уншиж судлах явцад тухайн үеийн ерөнхийлөгч нарын дотооддоо болон гадаад руу чиглүүлэн явуулсан, хэрэгжүүлсэн бодлогуудын дотор эдийн засгаа хөгжүүлэх, аж үйлдвэрийн салбар дахь бүтээн байгуулалт, экспортоо дэмжих өргөжүүл бодлого асар том байр суурийг эзэлсээр ирсэн байна. Мөн энэхүү эдийн засгийн бодлогыг хэр үр дүнтэй амжилттай явуулснаар тус ерөнхийлөгчийн нэр хүнд, ард иргэдийн аж амьдрал, ажлын байр нэмэгдсэн эсэх нь төдийгүй тус улсын олон улсын нэр хүнд, соёл урлаг, эрүүл мэнд, боловсрол гэх мэт бусад салбаруудыг хөгжил ч шууд хамааралтай ирсэн нь тодорхой харагддаг. Монгол улсын хувьд ч мөн адил ерөнхийлөгч бүр эдийн засгийн талаар хувь нэмрээ тодорхой хэмжээнд оруулсаар иржээ.

Монгол улс бол 1920-иод оноос 1990 он хүртэл нийгмийн социалист коммунист тогтолцоонд байсан тул эдийн засгийн бодлого нь ч социализм байгуулах үзэл баримтлалтай байсан гэдгийг бид мэднэ. Харин 1990 оноос эхлэн ардчилал, зах зээлийн тогтоолцоонд шилжсэнээр Шилжилтийн үе эхлэсэн. Монгол улс БНСУ-ын хоорондын хамгийн том ялгаа энд байна. Өөрөөр хэлбэл БНСУ бол коммунист социалист нийгмийн замналыг замнаж байгаагүй харин 1948 онд байгуулагдсан цагаасаа эхлэн зах зээлийн эдийн засгийн буюу капиталист системийн хүрээнд хөгжиж ирсэнд нь оршино.

Гэхдээ аль алинд нь төлөвлөсөн төлөвлөгөөт эдийн засгийн төстэй шинжүүд байсныг дурдах хэрэгтэй.

Олон улсын ангиллаараа Өмнөд Солонгосын эдийн засаг нь “Холимог эдийн засагтай” гэсэн ангилалд ордог. Холимон эдийн засагтай орнуудын онцлогт дараах гурван шинж байдаг гэж үздэг.

Нэгд, чөлөөт зах зээл, төрийн хөндлөнгийн оролцоо холилдсон

Хоёрт, хувийн өмчийн болон төрийн өмчийн компаниуд зэрэгцэн оршдог.

Гуравт, Зах зээл болн төлөвлөлт зэрэгцэн оршдог.

Монгол улс мөн холимог маягийн эдийн засагтай ч Шилжилтийн эдийн засагтай ч гэж үздэг.

Арга зүй

БНСУ нь түүхийн харьцангуй богино хугацаанд өндөр өсөлттэй байж, хөгжингүй орон болж чадсаныг бид мэднэ. Тиймээс чухам ямар арга замаар ийм амжилтанд хүрэв, ямар ямар хүчин зүйлс нөлөөлөв, гэхчилэн олон асуулт урган гарч судлаачид энэ чиглэлээр багагүй судалгаа хийсээр ирсэн борино-ын эдийн засгийн хөгжилд үе үеийн төрийн тэргүүнүүдийн гүйцэтгэхээс үүргийг үүссэнээрээ онол арга зүйгээр авч үзжээ.

1. Хөгжлийн онол (Development Concept)
2. Шинэ Инститүүцийн онол (New Institutionalism)
3. Соёлын үнэ цэний дэг сургууль (Cultural school of Value)
4. Түүхэн замналын онол (Historical Trajectories Theory)
5. Олон улсын харилцааны онол (IR Theory)

Ийнхүү наанадаж таваас доошгүй онолд суурилан авч үздэг. Эхний үзэл баримтлал болох “Хөгжлийн онол”-д хэд хэдэн хүчин зүйлийг ихээхэн нухацтай авч үздэг. Үүнд:

Юуны түрүүнд, БНСУ-ын хөгжлийн нууцыг Пак Жөн Хый ерөнхийлөгчийн засаглалын үеэс (1961-1979) эхлэлтэй бөгөөд түүний манлайлал голлох хүчиг зүйл болсон гэж үздэг. Өөрөөр хэлбэл тэр үед БНСУ хөгжилд голлон анхаарсан төрийн тогтолцоог үр өгөөжтэй нийтийн бодлогуудтай⁴⁰ уялдуулсан нь хөгжлийн хурдаа авахад нөлөөлсөн гэж үздэг байна. Энэ онолоор төрийн хүчтэй, идэвхитэй оролцоо, боловсруулсан бодлогууд болон албан хаагчдын хүчин зүтгэл чармайлтыг улс орноо аж үйлдвэржүүлэхэд ихээхэн төвлөрүүлсэн нь БНСУ-ын хөгжилд онцгойлон хувь нэмэр болсон гэж үзэж чухалчилдаг. Түүнчлэн ард иргэдийн уйгагүй хөдөлмөрч зан чанар, хандлагууд, Күнзийн сургаальд суурилсан соёл, мэдээллийн сүлжээний ач холбогдлыг дурддаг.

Гэхдээ эдгээрээс дутахгүйгээр ерөнхийлөгчийн хүчирхэг манлайлал хийгээд тухайн үедээ ч, одоо ч ач холбогдлыг нь яаж ч бичсэн хэтрүүлсэнд орохгүй Пак ерөнхийлөгчийн дэмжин зүтгэсэн “Экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийн бодлого” нь хөгжлийн онолд чухал байр суурь эзэлдэг. Мөн үүнтэй зэрэгцээд тухайн үеийн улс төрийн харьцангуй тогтвортой байдлыг оруулдаг. Тухайн цаг үед улс төрийн нөхцөл байдал амаргүй байсан ч том утгаараа бизнесийн орчин, аж үйлдвэржилт,

⁴⁰ Public policies

түүний дотор экспортод чиглэсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг туйлаас дэмжиж ажилласан уг бодлого өндөр амжилтанд хүрэхэд нөлөөлсөн байна.

Харин Шинэ институтийн онолыг баримтлагчид үзэхдээ Солонгосын эдийн засгийн өсөлт нь тус улсын эдийн засгийн засаглалын өвөрмөц бүтэц, институтийн шинэчлэл, инновацтай холбож үздэг юм.

Дээр тодорхойлсон онцлогууд нь гүйлгээний зардлуудыг⁴¹ бууруулж, худалдаа, зах зээлийг нь өргөжүүлж үүний ачаар эдийн засагт илүү их боломж ч буй болж үр өгөөж ч бенефит олж авахад хүргэсэн гэж үздэг⁴². Үүн дээр заавал онцлон нэг байгууллагын дурдаж жишээ татдаг. Тэр нь Засгийн газрын шууд харъяанд бас Ерөнхийлөгчийн удирдаж байсан “Эдийн засгийн Төлөвлөлтийн Хороо” хэмээх байгууллаг юм. Энэ Хороо нь хүчирхэг төрийн байнгын институтуудийг байгуулсан, улмаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх механизм нь үр дүнтэй ажилладаг байсны жишээ болдог.

Гуравдах онол нь, Солонгосын хөгжлийн үндэс нь Күнзийн үзэл сургаалийн соёлын болон нийгмийн үнэ цэнээс үүдэлтэй гэж үздэг үзэл баримтлал юм. Өрнөдөд дэлгэрсэн ардчилал, хүний эрх, эрх чөлөөний үзэл санаанаас ялгаатай нь Күнзийн сургааль нь уламжлалаа дээдлэдэг, улс төрийн шаталсан дэглэмтэй орнуудад төр засаг нь иргэнээс илүү том агуулгыг тээхийн зэрэгцээ автортари үзэл⁴³ нь ардчилалаас илүү голлох шинжтэй байдаг. Соёлын хандлагыг голчилдог ийм үзэл хандлага нь Күнзийн уламжлал болон бие хүний зан төлөвийн үнэ цэнийг улс төр, эдийн засгийн институтуудээс илүүд үздэг. Энэ үзэл санааг баримтлан олон улсад алдаршсан хүн бол Сингапурын Ерөнхий сайд асан Ли Куан Юү/Lee Kenan Yew/ юм. Гэхдээ Өмнөд Солонгосын ерөнхийлөгч асан Ким Дэ Жүн энэ үзэл баримтлалыг шүүмжилсэн нь сонирхолтой.

Дараагийн нэг онол нь “Түүхэн Замнал”⁴⁴-ын гэх үзэл баримтлал юм. Энэ онол дараах үзэл санааг чухалчилдаг. Үүнд, Аливаа эдийн засгийн өсөлт дэвшлийг ямар нэг түүхэн хязгаарлагдмал түүхэн хаалттай үйл явдлаас хайх бус харин илүү өргөн хүрээнд түүхийн урт удаан хугацааны хөгжил дунд авч үзэх ёстой гэдэг. Энэ онолын талыг баримтлагсад Өмнөд Солонгосын эдийн засаг хөгжсөн, Солонгосын хөгжлийг түүчээлсэн төр засаг нь буюу бүр тодруулбал Солонгосын хөгжингүй улс нь Японы колончлолын засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтын үргэлжлэл, өргөжсөн хэлбэр, үгүйдээ л Японы хөгжлийн туршлагаас ихээхэн суралцсан, орчин үеийн Японоос ихээхэн нөлөө авсан гэж үздэг. Өөрөөр хэлбэл Солонгосын хөгжлийн эх сурвалж нь Японы бодлоготой холбоотой. Түүнчлэн Солонгосын дайны дараагаас АНУ-ын тусламж, зөвлөгөө зааварчилгаа голлох үүрэгтэй байсныг тэмдэглэдэг. Солонгосын макро эдийн засгийн тогтворжуулалт, үнэ чөлөөлөлт болон аж үйлдвэржүүлэлтийн экспортыг дэмжих стратеги шилжсэн зэрэг нь бүгд шахуу АНУ-ын зөвлөхүүд, мэргэжилтнүүдийн нөлөө заавар зөвлөгөөгөөр хийгдсэн

⁴¹ Энэ нь “Transaction cost” гэсэн үг. Энэ нь төлөвлөлт, шийдвэр, төлөвлөгөөнд гарсан өөрчлөлтүүд, маргаан, борлуулалтын дараах зардлуудыг нийтэд нь хэлдэг.

⁴² Норт Д. Институты, институциональные изменения и функционирование экономики.

М., 1997

⁴³ Улс төрийн төвлөрсөн эрх мэдэл

⁴⁴ Historical Trajectory

гэж үздэг.⁴⁵ Мөн энэ онолтой холбоотой нэг үзэл нь БНСУ Хүйтэн дайны цаг үе, коммунист болон капиталист тогтолцооны өрсөлдөөн, тэр үеийн олон улсын харилцааны дахин давтагдашгүй цаг үетэй холбодог, тухайн үеийнхээ олон улсын харилцааны систем, үйл явдлуудтай холбон авч үздэг онол юм. Эдгээр ажлууд дээр нэмэгдээд өөр үзлүүд бий. Тэдгээрт БНСУ-д Христийн шашны сургаалын дэлгэрэлтэй холбон үздэг судлагаанууд болон хүн капитал гэсэн ойлголт дээр тулгуурласан эрдэм шинжилгээний ажлуудыг ч дурдаж болно.

БНСУ-ын ерөнхийлөгчийн өвөөс суралцах нь

Юуны түрүүнд Монгол улсад нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай туршлага бол улс орныхоо эдийн засгийг судалгаа, тооцоонд тулгуурлан хамгийн зохистойгоор, тухайн үед гарч ирсэн боломжуудыг туйлын дээд хэмжээнд ашиглан, бас тухайн үеийнхээ онцлогт тулгуурлан байж болох хамгийн зөв төлөвлөлт хийж уг төлөвлөгөөг заасан тодорхой хугацаанд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүдийг нээдэг “Эдийн засгийн Төлөвлөлтийн Зөвлөл”-ийг байгуулах хэрэгцээ байна. Аливаа хувь хүн, байгууллага, компани хэрвээ үйл ажлаа төлөвлөхгүй урсгалаараа явах юм бол яваандаа эмх замбараагүй, үр дүнгүй байдалд хүрэх нь гарцаагүй. Үүнтэй адил улс орон ч гэсэн зөвхөн янз бүрийн зорилго дэвшүүлээд байх биш тодорхой зорилтууд дэвшүүлэхдээ түүнийгээ байж болох хэмжээнд төлөвлөгөө лүгээ холбож уяж, уг төлөвлөсөн бүтээн байгуулалтуудаа санхүү, хэрэгжүүлэлт, цаг хугацаа, хүний хүчин зүйлс, мэргэжлийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулалт, ирээдүйн үр ашиг, экспортонд гаргах боломжуудыг нэн сайн төлөвлөж, хэрэгжүүлбэл уг бүтээн байгуулалт бодитой ажил хэрэг болдог.

БНСУ-д байгуулсан энэхүү “Эдийн засгийн Төлөвлөлтийн Зөвлөл” нь ийм зорилгоор байгуулагдаж үүргээ ч амжилттай хэрэгжүүлсэн Агентлаг юм. Анх 1961 онд тухайн үеийн ядуурлаас гарах, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зорилгоор байгуулагдсан. Анх үүсгэн байгуулагдахдаа 3 үндсэн зорилготой байв. Үүнд:

1. Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;
2. Засгийн газрын жил бүрийн төсвийг хянах;
3. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах.

Тус агентлаг нь Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлого боловсруулах үйл явцад голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ Зөвлөл нь нь Ерөнхий Төлөвлөлтийн хороо, Төсвийн хороо, Материал нөөцийн хороо болон Статистикийн хороо гэсэн 4 хороо, 19 хэлтэс, 228 ажилтантай байв.⁴⁶

1963 оноос Эдийн Засгийн Төлөвлөлтийн сайдын албыг буй болгосон бөгөөд Шадар сайдын статустай байжээ. Түүнчлэн эдийн засгийн бодлого, хэрэгжилтийг янз бүрийн түвшинд зохицуулах үүрэгтэй байв. Дээр нь дотоод болон гадаадын эдийн засгийн нөхцөл бодолд дүн шинжилгээ хийнэ.

⁴⁵ Haggard S. Pathway from the Periphery: The Politics of Growth in the Newly Industrialization Countries. – London:

Cornell University Press, 1990.

⁴⁶<https://www.kdi.re.kr/>

Дэргэд нь KDI буюу Солонгосын хөгжлийн Хүрээлэн хэмээх судалгааны томоохон байгууллага байсан нь хүний нөөц, тооцоо судлагааны арвин нөөц болж байв.

Уг хүрээлэн нь судалгаа тооцоо хийхээс гадна Засгийн газартай эдийн засгийн бодлогыг боловсруулж үүгээрээ БНСУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжилд шууд тус нэмэр болж байв. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажлыг энэ байгууллага бас хариуцдаг байв. Сар тутмын эдийн засгийн нөхцөл байдал төлвийг ч боловсруулж гаргаж байжээ.

Амжилтанд хүрсэн шалтгаанууд

1. Юуны ерөнхийлөгчийн хараа, шийдвэр, тавьсан зорилтыг нийт зөвлөл болон холбогдох ажилтнуудад хурдан шуурхай хүргэдэг тогтолцоо.
2. Бодлогын зорилтыг нэн тодорхой дэвшүүлж тодорхой арга замуудыг заавал хавсаргана.
3. Уг Зөвлөл нь чадварлаг хүний нөөцөөс гадна, санхүүгийн, мэдээллийн гэх мэт олон нөөц боломжуудаар дэмжигдэж байв.
4. Ерөнхийлөгч уг Зөвлөлийг удирдаж байсан тул удирдлага нь тогтвортой, хариуцлагатай ажиллахыг бүх ажилтнаас шаарддаг байв.
5. Хөгжлийн стратегийг боловсруулсны дараа нийт иргэд, компаниудад сурталчилах, таниулах ажлыг зохион байгуулна.
6. KDI байсан нь мэдлэг, оюуны нөөцөөр байнга сэлбэгдэх боломж нээгдсэн.⁴⁷

5 жилийн төлөвлөгөө

Хуучин БНМАУ гэж байх үед манай улс 5,5 жилээр нийгэм эдийн засгийн төлөвлөгөө хөгжүүлж байв. Өмнө өгүүлсэн БНСУ-ын эдийн засгийн төлөвлөгөөт зорилт уг 5 жилүүдийн төлөвлөгөөг боловсруулж баталсан байдлаар товч харуулбал дараах мэт:

1-р 5 жил 1962-1966 он

Гол зорилт: цахилгаан эрчим хүч, бордооны үйлдвэрлэл, газрын тос боловсруулах, цемент нийлэг мяндас.

2-р 5 жил 1967-1971 он.

Төмөрлөг, машин, хими, аж үйлдвэрийн модернизаци

3-р 5 жил 1972-1976

Төмөрлөг болон гангийн үйлдвэрлэл, машин, усан онгоц, нефть хими, электроник

4-р 5 жил 1977-1981 он

Ган төмөрлөг, машин, усан онгоц, нефть хими, электроник төмөрлөг бус металл

5-р 5 жил 1982-1986 он

Суурь машин, электроник өндөр технологийн үйлдвэрлэл

⁴⁷ https://www.kdi.re.kr/eng/research/reportView?pub_no=13671

6-р 5 жил 1987-1991 он

Өндөр технологи, судалгаа хөгжүүлж, ажиллах хүчнээ дахин сургах

7-р 5 жил 1992-1996 он

Микроэлектроник, Био инженерчлэл, Агаарын болон сансарын хөлгийн үйлдвэрлэл, Fine chemicals (эмийн бол уураг стойд гэх мэт).⁴⁸

Тэргүүн туршлагаас суралцах нь

Монгол улсын хувьд гадаадын түүний дотор өндөр хөгжсөн орнуудын туршлагаас суралцахыг чухалчилсаар ирсэн. Хуучин ЗХУ-ын үед Зөвлөлтийн тэргүүн туршлагаас суралцахыг улс орны хэмжээнд өрнүүлж иржээ. Өнөөдөр ч энэ санаа хуучраагүй бөгөөд энэ тохиолдолд БНСУ-ын туршлагаас суралцах бүрэн боломжтой юм. Гадаадын бодлогын тэргүүн туршлагаас суралцахыг “Benchmarking” гэдэг. Энэ нь тухайн салбараа хөгжүүлсэн арга зам, ялангуяа хэмжээс метрикеүүдэд тулгуурлан чиглэл, аргазүйгээ тогтоодог бөгөөд бидний хэлж заншсанаар туршлага судлах үйл ажиллагаа юм. Монгол улс хөгжиж буй орны хувьд БНСУ-ын хөгжлийн замналаас суралцах хэрэгтэй бөгөөд ингэснээр цаг хугацаа, хөрөнгө санхүү, алдаанаас сэргийлж зөв замаар зөв арга замаар хөгжинө гэсэн үг юм.

Доор БНСУ-ын хөгжлийн туршлагаас жишээ болгож хэд хэдэн кэйсийг авсан бөгөөд мөн Монголын онцлогоос жишээ авав.

Кэйс 1

Агуулга : Автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай захирамж

БНСУ-ын хувьд эдийн засгаа макро түвшинд төлөвлөхөөс гадна эдийн засгийн салбаруудаа нэгбүрчлэн авч үзээд тухайн салбарыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, бодлого, чиглэлээ тогтдог байжээ. Энд өгүүлж буй жишээ бол автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ БНСУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газар, бодлого боловсруулагчид хэрхэн хамтран ажиллаж байсны жишээг харуулах баримт юм.

Автомашины үйлдвэрлэл бол тоног төхөөрөмж, ган төмөрлөг, химийн үйлдвэрлэл зэрэг бусад салбарт ихээхэн нөлөө бүхий хүнд үйлдвэрлэл бөгөөд бидний зорилгод ажил болох хүнд болон химийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх салбар юм.

Автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлсэнээр цаашид хүнд болон химийн аж үйлдвэржилтэд шаардлагатай тээврийн хэрэгслийг бүрэн хангаад зогсохгүй холбогдох үйлдвэрлэлүүд хөгжлийг түргэтгэж, цаашилбал 1980-аад онд эдийн засаг эрчимтэй хөгжих үндсэн нөхцөлийг бүрдүүлж байгаа хэрэг юм.

Автомашины үйлдвэрлэл нь үйлдвэрийн байгууламжид асар их хэмжээний хөрөнгө оруулалт, мэргэжлийн нарийн технологийг шаарддаг тул хязгаарлагдмал хөрөнгөө үр ашигтай хувиарлаж, үйлдвэрийн байгууламжийг давхардуулахгүй байх ёстой. Түүнчлэн холбогдох салбаруудыг татан оролцуулж хуучирсан технологиос татгалзан, аль болох орчин үеийн эдийн

⁴⁸Young-lob Chung, “South Korea in the Fast Lane: Economic Development and Capital Formation”, Oxford University Press. 2007.

засгийн үр ашигтай тогтолцоог нэвтрүүлэх, олон улсад өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл болгон хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Манай улс өнгөрсөжн арван жилийн хугацаанд автомашины үйлдвэрлэлийн салбарт нутагшуулалт, технологи талаас ихээхэн амжилтад хүрсэн боловч шийдэх ёстой асуудлууд цөөнгүй байгаа тул уг салбарын онцлог ач холбогдлыг харгалзан дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчлан ажиллана уу.

1. Автомашины үйлдвэрлэлийг 1975 оны эцэс гэхэд бүрэн нутагшуулахад зорилт тавьд, үүнд шаардалагатай хөгжлийн бодит төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.

2. Автомашины төрөл, загварыг эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлж аль болох цөөн нэр төрлийн болгох. Автомашины улмаас жил ирэх тусам нэмэгдэж буй шатахуун тосны хэрэглээнд хэмнэлт гаргах, үр ашиг багатай автомашины ашиглалтыг хязгаарлах, системтэйгээр хөгжүүлэх тогтолцоог бий болгож, загвар төрөлд ойр ойрхон өөрчлөлт гарахгүй байхуйц үр ашиг бүхий автомашиныг үйлдвэрлэх.

3. Автомашины үйлдвэрлэлийг сэлбэгийн үйлдвэрлэл болон угсрах үйлдвэрлэл гэж ангилан хөгжүүлнэ. Угсрах үйлдвэргийн хувьд цаашид гадны хөрөнгө оруулалтаар хамтрах эсвэл шинээр байгуулах явдлыг зогсоож, одоо байгаа үйлдвэрийг голлонх хөгжүүлэх, үйлдвэрлэлд зохистой шинэчлэл хийх арга замыг хайх.

4. Сэлбэгийн үйлдвэрлэлийг угсрах үйлдвэртэй уялдуулан байгуулах, тухайн угсрах үйлдвэрийн хэрэгцээт сэлбэгийг олон улсын стандартад нийцүүлэн дагнан үйлдвэрлэж чадахуйц гадаадын компанитай хамтрах, хамтран хөрөнгө оруулалт хийх, гадаадын экспортын түвшний сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх. Үйлдвэрийн газрыг сонгохдоо аль болох Чанвоны аж үйлдвэрийн парк дотор байгуулахыг зорих.

Ерөнхийлөгчийн захирамжид үндэслэн боловсруулсан :

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга.

Хэнд : Ерөнхий сайд, Эдийн засаг, Төлөвлөлтийн хорооны сайд, Сангийн сайд, Худалдаа Үйлдвэрлэлийн сайд

Хуулбар хүргүүлэх газар: Эдийн засгийн 1-р нарийн бичгийн газар⁴⁹

Дээрх захирамжаас Пак Ерөнхийлөгчийн автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги, хэрэгжүүлэх арга зам нь маш тодорхой байсныг харж болно. 3-р хэсэгт гэхэд автомашины үйлдвэрлэлийн сэлбэгийг болон угсрах гэж ангилан хөгжүүлэхийг заасан байна. Хүснэгт VI -2-ыг харвал ерөнхийлөгчийн санааг бүр сайн ойлгох боломжтой. Угсрах үйлдвэр болон сэлбэгийн үйлдвэрийг параллель харьцаатайгаар төрөлжүүлж, цаашид угсрах үйлдвэр шинээр байгуулалгүй, одоо байгааг нь дэмжин хөгжүүлэхийг тушаасан байна. 4-р хэсэгт автомашины үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ сэлбэгийн үйлдвэрлэлд түлхүү анхаарал хандуулах, тэр дундаа олон улсын стандартад

⁴⁹ О Вончөл, Пак Жөнхый: Солонгосын сэргэн мандалт, Орч. Ж. Баттөр, Л. Долгормаа, Б. Ганцэцэг, НЭПКО Пабблишинг, 2013, 468-р тал.

нийцүүлэн, экспортод гаргахыг зорих Сэлбэгийн үйлдвэрийг замбараагүй байгуулалгүй, аль болох Чанвонь аж үйлдвэрийн паркад төвлөрүүлэх, төрөөс үүнийг дэмжих ёстойг зааварласан байна.

Тухайн үед автомашин үйлдвэрлэдэг Хёндэ, Дэу, Киа, Асиа гэх дөрвөн аж ахуйн нэгж байсан юм. Fiat компаниар гүйцэтгүүлж байсан армийн зориулалтай автомашины үйлдвэрлэлийг Асиа автомашин ХК -нд шилжүүлж улмаар уг компаний удирдлагыг нь Киа автомашин ХК-ий харьяанд өгснөөр дөрвөн үйлдвэрлэгч байсныг гурав болгон өөрчлөлт хийсэн билээ.

Энэхүү бодлогын үр дүнд дотоодын автомашины үйлдвэрлэл 1976 оноос огцом өсч, экспортод гаргах болов. Хүснэгт VI-3-т автомашины үйлдвэрлэл хэрхэн өссөнийг тодорхой харуулсан байна.

1977 онд 85,210 ширхэг автомашин (72%), 1978 онд 158,958 ширхэг автомашин (86,5%, 1979 онд 28,6% -иар өсч 204,447 ширхэг автомашин үйлдвэрлэв. Гурван жилийн хугацаанд дунджаар 62,4% иар өссөн байна. Нэг үгээр дотоодын автомашины үйлдвэрлэл алтан үетэйгээ золгож, энэ эрчээрээ авбал 2-3 жилийн дараа гэхэд ерөнхийлөгчийн тунхагласан 500 мянган автомашин үйлдвэрлэх зорилт биелэхэд ойрхон болчихсон байв. Гэтэл яг энэ үед ерөнхийлөгч таалал төгссөн билээ. 1976.10.26.⁵⁰

Кэйс 2

Инчоны олон улсын нисэх онгоцны буудал

БНСУ-ын 6 дахь Ерөнхийлөгч Но Тэү нь 1988-1993 оны хооронд уг албыг хашсан. Тэрбээр тус улсын орчин үеийн түүхэнд ардчилсан сонгуулиар сонгогдсон анхны ерөнхийлөгч билээ. Но Тэү ерөнхийлөгч хожим нь Авлига, улсын хөрөнгө завшсан хэргээр шоронд сууж байсан ч албан дээр байх үедээ улс орныхоо ирээдүйн хөгжил цэцэглэлтэнд нэн тус нэмэр болсон, урт хугацааны турш үр өгөөжээ өгөх, томоохон бүтээн байгуулалтыг эхлүүлж, хөдөлгөсөн. Үүнд: Үндэсний хэмжээний бодит бүтээн байгуулалтыг эхлүүлсэн жишээнд Инчоний олон улсын нисэх онгоцны буудал болон Солонгос даяарх өндөр хурдны галт тэрэгний тогтолцоо болно. Мөн хөдөө орон нутгийн өрийг цуцалсан, 2 сая гаруй орон сууц бариулсан, “Олон нийтийн газрын өмчлөл” хэмээх журмыг бий болгосон зэргийг дурдах ёстой. Энэ жишээнд юуны түрүүнд Инчоны олон улсын нисэх онгоцны буудлын бүтээн байгуулалт орно.

БНСУ 1988 онд Сөүлийн зуны Олимпын зохион байгуулсан. Хэдийгээр энэ Олимп ихээхэн амжилттай болж тавьсан зорилгодоо хүрсэн ч Солонгосын удирдагч нарт нэг том дутагдал харагдсан нь тухайн үеийн Кимпо Олон улсын нисэх онгоцны буудлын хүлээн авах хүчин чадал яваандаа доголдох нь тодорхой болсон явдал байв. Тиймээс олон улсын нисэх онгоцны шинэ буудал барихаар шийдсэн бөгөөд хамгийн гол нь БНСУ-ын хувьд том байгууламж барих газар, онгоцны нислэгийн төвлөрөл, замын түгжрэл, аюулгүй байдал, цаашид улам шинэчлэх, өргөтгөх, нийслэлээ хэт холгүй байдал, ложистик хөгжүүлэх боломж, дагуул хот барих боломж, ачаа тээврийн төв болох ирээдүй зэргээр хангагдсан байх ёстой байв.

Ингээд 2-3 газар барихад төвлөсөн ч хэд хол, эсвэл өргөтгөх боломж тааруу гэх мэт хүндрэлүүдээс болоод зогсоож, харин Инчоньд байгуулахаар тогтсон. Гэхдээ Ёнжён, Еньюү гэсэн

⁵⁰ О Вончөл, Пак Жөнхый: Солонгосын сэргэн мандалт, Орч. Ж. Баттөр, Л. Долгормаа, Б. Ганцэцэг, НЭПКО Паблицинг, 2013, 469-р тал.

хоёр арлын хооронд орших газрыг хатааж, шороогоор дүүргээд бэхжүүлж энэ онгоцны буудлыг барихаар тогтсон. Бүтээн байгуулалтын хугацаа нь 8 жил байсан бөгөөд 1997 онд Азийн болон Солонгосын эдийн засгийн хямралаас болж хойшлогдоод 2001 оны 3 сарын 21-нд албан ёсоор нээлтээ хийсэн байна. Уг буудал нь “Сөүл хотоос 48 км зайтай. Зүүн хойд Азидаа хамгийн том, дэлхийн хамгийн том хамгийн их зорчигч дамжин эсвэл онгоцны буудал болсон.

Ро Тэү ерөнхийлөгчийн улс төрийн шийдвэр гаргаж эхлүүлсэн дараагийн бүтээн байгуулалт бол КТХ (Korea Train Express) буюу Солонгосын хурдны галт тэрэгний байгууламж юм. Солонгос даяар сүлжсэн энэхүү хурдан галт тэрэгний сүлжээ нь нийгмийн хөгжилд ихээхэн хувь нэмрээ оруулж байна.

Кэйс 3

“Дэлхийн Солонгос” хөтөлбөр

Түүний мөрийн хөтөлбөрт БНСУ-ын нэр хүндийг дэлхийн тавцанд өргөж, гадаад бодлогын жин нөлөөг нэмэгдүүлэх “Дэлхийн Солонгос” (Global Korea) хэмээх стратеги төлөвлөгөө тусгагдсан байв. “Дэлхийн Солонгос” стратегийн баримт бичиг нь БНСУ-ын Засгийн газрын гадаад бодлого, гадаад харилцааг төдийгүй аюулгүй байдлын асуудлуудыг хамарсан ихээхэн нарийвчилсан 20 орчим зорилт болон 100 зорилгыг багтаасан төлөвлөгөө байв.⁵¹ БНСУ нь эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгож чадсан бүс нутгийн “Дунд зэргийн гүрний” (middle power) хувьд дээрх стратеги төлөвлөгөө нь дэлхий дахинаа нэр хүнд, нөлөөллөө нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой бодлого байсан юм.

Ерөнхийлөгч И Мён Баг 2009 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 64-р чуулганд хандаж хэлсэн үгэндээ “Бид “Дэлхийн Солонгос” болж, дэлхийн бусад улс орнуудтай ашиг сонирхлоо нэгтгэж, хүн төрөлхтний хөгжил цэцэглэлт, сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулахаар хичээж байна” хэмээн цохон тэмдэглэсэн . Олон улсын хамтын нийгэмлэгт танилцуулсан энэхүү бодлогоо хэрэгжүүлэхдээ БНСУ зөвхөн идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих төдийгүй, ардчилал, чөлөөт зах зээлийг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж, дэлхий дахинд тулгарч буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд үр дүнтэй бодлогын хувилбар санал болгон, илүү “Манлайлагч”-ийн үүрэгтэйгээр оролцох амбицтай буйгаа тайлбарлав. Дээрх зорилгоо биелүүлэхийн тулд хэд хэдэн зорилт дэвшүүлсэн байдаг. Үүнд:

1. Хоёр Солонгосын харилцаанд: Хойд Солонгостой харилцахдаа харилцан ашигтай, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх;
2. Хамтын ажиллагааны Дипломат сүлжээ: АНУ-БНСУ-ын Холбоотны харилцааг улам бэхжүүлж, бүс нутгийн болон дэлхийн нийтийн хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулах;
3. Иж бүрэн гадаад бодлого: Эрчим хүчний дипломат ажиллагаануудад оролцох, “Чөлөөт худалдааны хэлэлцээр”-ийн сүлжээг өргөжүүлэх, олон улсын худалдаанд БНСУ-ын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх;

⁵¹ Global Korea: The National Security Strategy of the Republic of Korea. (Seoul: Cheong Wad ae, 2009), http://englsih.president.go.kr/governmnet/globalkorea/globalkore_eng.pdf>

4. Батлан хамгаалах салбарын шинэчлэл: Ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалахын тулд, аюулгүй байдлын дэвшилтэд арга тактикийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилт тавьсан.⁵²

БНСУ нэгэнт хүчирхэг эдийн засагтай, дэлхийн эдийн засгийн гол тоглогчдын нэг болсон тул “Дэлхийн Солонгос” бодлогын хүрээнд хөгжиж буй орнуудад зээл, тусламж олгох, хөгжлийн туршлагаа хуваалцах “ёс суртахууны” үүрэг хүлээсэн улс болсон хэмээн өөрсдийгөө тодорхойлсон. Энэ хүрээнд 2011 онд ЭЗХАХБ-ын (OECD) Хөгжлийн Тусламжийн Хорооны дээд хэмжээний уулзалтыг Бусан хотноо зохион байгуулж, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг нэмэгдүүлэх амлалт өгсөн байдаг.

“Дэлхийн Солонгос” бодлого нь “Хамтын ажиллагааны Дипломат сүлжээ”-г өргөжүүлэх зорилтын хүрээнд хоёр том амжилтад хүрсэн. Үүнд:

Нэгд, Эдийн засгийн дипломат ажиллагаа: 2008 оны Дэлхийн санхүүгийн хямралыг даван туулахад “20-ийн Бүлэг”-ийн гишүүний хувьд манлайлал үзүүлсэн, БНСУ-ЕХ, БНСУ-АНУ Чөлөөт Худалдааны Хэлэлцээрүүдийг байгуулсан. ЕХ-той тааламжтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахын тулд АНУ-тай тогтоосон сайн харилцаагаа хөшүүрэг болгон ашиглаж чадсан байдаг.

Хоёрт, Эрчим хүчний дипломат ажиллагаа: Ногоон хөгжлийн бодлогыг дэвшүүлсэн нь олон улсын анхаарлын төвд орсон бөгөөд АНЭУ-д атомын цахилгаан станц барих тендерт ялалт байгуулж, БНСУ-д зураг төслийг нь зохиосон дөрвөн АЦС-ыг барихаар болсон бөгөөд АНЭУ-тай байгуулсан хэлэлцээрийг АЦС-ын экспортын салбарт өөрийн жин нөлөөг нэмэгдүүлэхэд ашигласан юм.

Бизнесийн салбараас улс төрд орж ирсэн Ерөнхийлөгч И Мён Баг Дэлхийн санхүүгийн хямралын үед санаачилгыг гартаа авч, 20-ийн Бүлгийн уулзалтыг БНСУ-д зохион байгуулж, дэлхийн санхүүгийн институцуудад шинэчлэл хийх шаардлагатай байгааг сануулж, хэрэгжүүлэхэд гар бие оролцсон билээ.⁵³ Түүнчлэн 2011 он гэхэд ЕХ-ны 27 улс, АСЕАН-ы 10 улс болон АНУ-тай Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулж чадсан нь БНСУ-ын бараа бүтээгдэхүүнийг дэлхийн эдийн засгийн 61%-д татваргүй нэвтрэх үүд хаалгыг нээж өгсөн юм.

Бүс нутгийн хэмжээний хүчирхэг тоглогч БНСУ нь И Мён Баг Ерөнхийлөгчийн үед олон улсын түвшинд эзлэх жин нөлөөгөө нэмэгдүүлэх амбицтай гадаад бодлого баримтлах болж, АНУ-тай тогтоосон холбоотны харилцаагаа ашиглаж өрнө, дорнын томоохон тоглогчидтой Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулж, стратегийн чухал ач холбогдолтой эрчим хүчний салбарт танигдаж, давуу байдал олж авч чадсан билээ. Товчхондоо, “Глобал Солонгос” бодлого нь БНСУ-ыг дэлхий дахинд нээлттэй улс бөгөөд дэлхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд голлох нөлөөтэй тоглогчийн нэг болсон хэмээх утгыг илэрхийлэх болов.

Кэйс 4

⁵² Address by H.E. Mr. Lee Myung-bak, President of the Republic of Korea, at the 64th Session of the General Assembly of the United Nations. New York. Retrieved from (UNGA,2009.) https://gadebate.un.org/sites/default/files/gastatements/64/64_kr_en_24.pdf

⁵³ Snyder, S. A. (2018). South Korea at the Crossroads: Autonomy and Alliance in an Era of Rival Powers. Columbia University Press.

“Ногоон Өсөлт” (Green Growth) Стратеги

НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилтод оруулж буй БНСУ-ын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхээр тулд И Мён Баг ерөнхийлөгчийн засаг захиргааас дэвшүүлсэн “Ногоон Өсөлтийн Стратеги”-д зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай юм. Ерөнхийлөгч И Мён Баг бизнесийн төлөөллүүдтэй хамтран ажиллах замаар нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг бууруулж уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах “Ногоон Өсөлтийн Стратеги”-ийг боловсруулсан. Энэ хүрээнд:

Нэгд, Дэлхийн Ногоон Хөгжлийн Институтийг үүсгэн байгуулав. Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт (GGGI) олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахад Ерөнхийлөгч И-гийн засаг захиргаа чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү институт нь Ногоон өсөлтийн стратегийг үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой байсан билээ.

Хоёрт, НҮБ-ын Ногоон Уур амьсгалын Санг үүсгэн байгуулалцсан. Ерөнхийлөгч И-гийн засаг захиргааны үед БНСУ нь НҮБ-ын Ногоон Уур амьсгал Сангийн хүлээн авагч улс болсон бөгөөд НҮБ-ын Ногоон Уур амьсгал сан нь хөгжиж буй орнуудад өрнөж буй уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох хүчин чармайлтыг дэмжих зорилготой санхүүгийн механизм юм.

НҮБ-ын “Тогтвортой Хөгжлийн Зорилт-2030” дэлхий нийтийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг батлагдахаас өмнө БНСУ эдгээр санаачилгыг дэвшүүлж, идэвх зүтгэл гаргах болсон нь И Мён Баг Ерөнхийлөгчийн хувийн туршлага, итгэл үнэмшилтэй холбоотой болохыг онцлох нь зүйтэй. Тэрээр аж үйлдвэр өндөр хөгжсөн орнууд хүлэмжийн хийн ялгаруулалтад хамгийн өндөр хувь эзэлж байгааг онцолж, эдгээр орнууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд манлайллын үүрэгтэй оролцох ёстойг онцолсон. Бизнесийн салбараас улс төрд орж ирсэн хүний хувьд Ерөнхийлөгч И, төрийн бодлого, стратегиар хангаж өгсөн тохиолдолд бизнесийн салбарынхан уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үр дүнтэй шийдлийг боловсруулж чадна гэх хатуу итгэл үнэмшил түүнд байсан юм. Түүний таамаг ёсоор төрийн оролцоо, дэмжлэгтэйгээр бизнесийн байгууллагууд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг арилгах инновацлаг шийдлийг олноор танилцуулсан жишээ БНСУ-д олон бий. “Глобал Солонгос” бодлогод тусгагдсан “Эрчим хүчний Дипломат ажиллагаа” зорилтын хүрээнд БНСУ арилжааны зорилготой Цөмийн цахилгаан станц барих дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн технологийг бий болгож чадсан.⁵⁴ 2009 онд АНЭУ-ын зарласан Цөмийн цахилгаан станц барих, засвар үйлчилгээг гүйцэтгэх 40 тэрбум ам.долларын тендерт БНСУ-ын Эрчим хүчний Корпораци ялалт байгуулж, төслөө ажилттай хэрэгжүүлж чадсан. Өдгөө БНСУ 24 цөмийн эрчим хүчний реактораар дотоодын эрчим хүчний хэрэглээнийхээ 27,4 хувийг хангаж байна.⁵⁵

Олон улсын нөхцөл байдал ширүүн өрсөлдөөн дунд өрнөж буй өнөө цаг үед БНСУ эрчим хүчний салбарт гол тоглогчийн үүрэг гүйцэтгэж байгаа нь Ерөнхийлөгч И-гийн засаг захиргааны үед дэвшүүлсэн “эрчим хүчний дипломат ажиллагаа” зарим талаараа холбогдохыг онцлох нь зүйтэй.

⁵⁴ “World Nuclear News”, 2023.

⁵⁵ “South Korean Nuclear Policy”, 2023

Тийнхүү БНСУ-ын Ерөнхийлөгч И Мён Багийн засаглалын үед бүс нутгийн хэмжээний гүрэн болж хүчирхэгжсэн улсаа дэлхий дахинд таниулан сурталчлах зорилготой “Глобал Кореа” бодлого болон “Ногоон Өсөлтийн Стратеги” зэрэг санаачилгатай алхмууд нь улсынхаа нэр хүндийг өсгөх үүргээ биелүүлснээс гадна дэлхий нийтэд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнтэй механизмыг бий болгоход давхар чухал үүрэг гүйцэтгэсэн байна. “Ногоон Өсөлтийн Стратеги” баталсан нь НҮБ-ын бодлогын баримт бичиг батлагдахаас өмнө уур амьсгалын асуудалд анхаарал хандуулж, үндэсний хэмжээний бодлогоо тодорхойлсон анхдагч улсуудын тоонд БНСУ-ыг зүй ёсоор оруулж байна.

Дэлхийн эрчим хүчний салбар шатах ашигт малтмалаас (fossil fuel) цэвэр эрчим хүчний технологид асар хурдтай шилжилт хийх шаардлагатайг ухамсарлаж, стратегийн чухал ач холбогдолтой салбарт анхаарал хандуулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг уялдуулах стратегийг боловсруулж чадсанаар БНСУ өдгөө цэвэр эрчим хүчний эх үүсвэрт шилжих шилжилтэд оройлон оролцож байна. НҮБ-ын Ногоон Уур Амьсгалын Санг Инчеон хотын Сонгдо дүүрэгт байгуулж, 2013 онд 100 сая ам.долларын хандив өгч, 2020-2023 онд 200 сая ам.долларын хандив өгсөн бол, 2023 онд нэмэлтээр 300 сая ам.долларын хандив өгөх болсноо Шинэ Дели хотод болсон 20-ийн Бүлгийн дээд хэмжээний уулзалтын үеэр БНСУ-ын Ерөнхийлөгч Юн Сог Ёл мэдэгдэв.⁵⁶ Ерөнхийлөгч И Мён Багийн манлайлал дор үүсгэн байгуулагдсан НҮБ-ын Ногоон Уур Амьсгалыг Сангийн хөрөнгө өдгөө 11.9 тэрбум ам долларт хүрээд байна. Тус санд хуримтлагдсан хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий байгаа буурай хөгжилтэй болон, аж үйлдвэржиж байгаа улсуудад гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулна.

Монголын байдал төлөв

Монголын эдийн засгийн өөрчлөлтийн талаар гадаад дотоодын цөөнгүй судалгаа бий. Тухайлбал Т.Намжил “Хэдийгээр нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлтүүд өрнөсөн ч зах зээлийн үр өгөөжтэй механизмд хараахан бүрэлдээгүй байгаа бөгөөд эдийн засаг хямралд оршсоор байна. Нийгмийн санаа зовоосон олон асуудлууд байна. Хүн ам цөөнгүй хэсэг ядуурлын хавханд байна” гэж үзсэн.⁵⁷ Түүнчлэн Монголын шилжилтийн эдийн засгийн үеийн шинэ либераль үзэлд суурилсан “Цочир эмчилгээ” бодлогын талаар Ш.Энхбаяр нэлээд нарийвчилсан судлажээ. Түүний дүгнэлтээр:

1. Монголын эдийн засгийн реформ, шилжилтэнд сайтар боловсруулсан хөтөлбөр байгаагүй бөгөөд бодлогын арга хэмжээнүүдийг байнга урьдчилан тайлбарлаж байгаагүй олон нийтээр хэлэлцүүлээгүй.
2. Үүнээс болоод нийгмийн доод түвшиндээ хүртэл олон нийтийн ойлголцол болон дэмжлэгээ алдсаар ирсэн.
3. Шинээр гарч ирсэн бодлого боловсруулагчид өмнөх үеийнхнийхээ үнэ цэнэ, дэмжлэгийг хүлээн зөвшөөрч чаддаггүй.

⁵⁶ Yonhap News, 2023.

⁵⁷ Монголын эдийн засгийн түүхэн гурван цаг үед 2000/а/ 1-р боть

4. Мөн өмнөх 70 гаруй жилийн туршид бүтээн байгуулсан, хөгжүүлсэн зүйлсээ бараг бүгдийг нь байнга үл тоомсорлосоор ирсэн.

5. Ийм үйлдлүүд нь бодлого боловсруулагчдын зах зээлийн эдийн засгийн механизмууд үйл ажиллагааны талаарх туршлагагүй байдал, мэдлэгийн дутагшилтай холбоотой.

6. Үүнээс улбаалан бодлого боловсруулагчид Монголын эдийн засаг хэрхэн ажиллаж ирсэн талаарх гүнзгий сайн мэдлэггүй гадаадын зөвлөхүүдийн дэвшүүлсэн санааг дагахаас өөр сонголтгүй байлаа” гэж дүгнэсэн.⁵⁸

Үүний зэрэгцээ Монголын эдийн засагт гарсан эерэг талуудыг дурдсан. Үүнд :

1. Эдийн засгийн суурь нь төрөлжсөн,,
2. Дэлхийн эдийн засгийн интеграцид орсон,
3. Хамгийн чухал нь олон нийтийн чөлөөт зах зээлийн эдийн засгийн талаархи ойлгомжтой болсон нь тэмдэглэжээ.⁵⁹

Гэхдээ хамгийн чухал бас нэг дүгнэлт нь хэрвээ эдийн засгийн хөгжлийн тохирсон стратеггүй л яваад байх юм бол нийгэм эдийн засгийн илүү гүнзгий асуудлууд нийгмийн түншүүдтэй байдал руу чиглэх болно гэсэн.

Монголын эдийн засаг, ялангуяа Шилжилтийн эдийн засгийн бодлогын талаар Өрнөдийн орнуудаас судласан эрдэмтэн бол Эрик С. Райнерт хэмээх эдийн засагч юм. Түүний бичсэн “Баян орнууд яаж баяжиж бас ядуу орнуул яагаад ядуу чигээрээ үлдсэн бэ” хэмээх бүтээлд Монголын эдийн засгийн реформ хийхдээ гаргасан алдааг дурдаж, өмнөх үед бүтээсэн аж үйлдвэрийн цогцолборууд, буй болгосон бүтцээ нурааж, давуу талуудаа үгүйсгэснийг цохон тэмдэглэсэн.⁶⁰

Кэйс 1

Мянганы зам

Энэхүү төсөл нь Монгол улсын бүх аймаг, хотын төвийг нийслэл Улаанбаатартай холбох, нийт 7 мянга гаруй км үргэлжилсэн хатуу хучилттай авто зам бүхий томоохон төсөл байсан юм. Уг төслийн ерөнхийлөгч Н. Энхбаяр байсан агаад тухайн үедээ “Мянгуужингийн зам” гэхчилэн нэлээд шүүмжлэлд өртөж байлаа.

Кэйс 2

Алсын хараа 2050

Уг баримт бичиг нь Монгол улсын ирээдүйн 30 жилийн төсөөлөл, хүрэх зорилт юм. 1990 онд дэлхий дахинд коммунист тогтолцоо нуран унаж, Монгол улс ч манж Чин гүрний ноёрхол дор 200

⁵⁸ Enkhbayar Shagdar, “Neo-liberal “Shock therapy” policy during the Mongolian Economic Transition”. Erine Discussion paper № 0703e April 2007. Niigata Japan p.13-14

⁵⁹Ibid. p.14

⁶⁰ Эрик С. Райнерт, “Как богатые страны стали богатыми, и почему бедные страны остаются бедными”. 5-е изд.Пер. с англ. под науч. ред. В. С. Автономова. Издательство “ВШЭ”.

гаруй жил, ЗХУ-ын нөлөөн дор 70 жил оршин тогтносны эцэст бүрэн утгаараа бие даасан, хараат бус улс болсон. Энэ үеэс манай улс Ардчилсан тогтолцоонд шилжсэн. Ингээд 2020 онд Ардчиллын замаар замнан хөгжсөний 30 жил болж байна гэсэн үг. 2020 оноос цаашхи 30 жилээ тэгвэл хэрхэн харж, хэрхэн төлөвлөж байна вэ гэсэн асуулт урган гарна. Алсын хараа-2050 нь энэхүү асуултанд хариу өгсөн урт хугацааны хөгжилийн баримт бичиг юм.

Өнгөрсөн 20-р зуунд Монгол улс хөгжилийн бодлогын цөөнгүй баримт бичиг боловсруулж байсан туршлагатай улс. Тухайлбал бүр 1911 онд үндэсний тусгаар тогтнолоо тунхагласны дараахнаас анхын хөгжлийн баримт бичиг гаргаж байсан бол, 1924 онд тухайн үеийн Санхүү эдийн засгийн газраас нэлээд боловсронгуй хөгжилийн үзэл баримтлал боловсруулж байжээ. 1924 оноос эхлээд Монгол улс коммунист, социалист улс болсон. Коммунист орнуудын нэг онцлог нь таван жилийн төлөвлөгөө боловсруулан баталж, түүнийгээ биелүүлэхээр зүтгэдэг байдал юм.

Монгол улс ч найман удаагийн 5 жилийн төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж байсан түүхэн туршлагатай улс. Таван жилийн төлөвлөгөө батлана гэдэг нь улс орны салбар, нэгж бүрийг уг төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэнэ гэсэн үг. Тиймээс урд өмнөх туршлага, зах зээлийн эдийн засгийн үеийн туршлагыг хослуулсан баримт бичиг юм.

Сайшаал ба шүүмжлэл

Уг баримт бичгийг батлах үед мэдээж олон хүн дэмжиж байсан. Ямар ч байсан хаа хүрэхээ мэдэхгүй явж байснаас ядаж очих газраа мэдэж явах нь дээр. Гэхдээ ялгаагүй олон эрдэмтэд судлаачид шүүмжилсэн. Тухайлбал: Монгол улс маш хурдтай өснө гэдэгт эргэлзэж байгаагаа илэрхийлж байв. Учир нь уг баримт бичигт ДНБ-ийг 6.1 дахин өсгөж аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтах зорилт тавьсан.

-Монгол улс маш эрс тэс уур амьсгалтай, далайд гарцгүй, дотоодын тээврийн зардал өндөр тул аргагүй нөхцөл байдлаа хүлээн зөвшөөрөх ёстой,

-Үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг нэн тэргүүнд тавиагүй.

-хөгжлийн урьдач нөхцөл, суурь хүчин зүйлийг уламжлалт ёс зан заншил, нүүдлийн соёл иргэншил, түүх дээр тулгуурласан "Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар" гэсэн нь, хүлээн зөвшөөрөхөд хэцүү, шуудхан хэлэхэд онол-арга зүйн хувьд алдаатай юм.⁶¹

“Алсын хараа 2050” нь сүүлийн 100 гаруй жилийн үйл явцад танин мэдэхүйн шинжтэй үнэлгээ өгсөн, ирэх 30 жилд дэвшүүлж болох зорилтуудыг тусгасан зөвлөмжийн чанартай баримт бичиг гэж үзвэл зохилтой.⁶²

I үе шат (2021-2030):

2.Гуравдагч хөршид хүрсэн эдийн засаг бий болсон байна.

3.Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.

⁶¹Ж. Гөлгөө: “Алсын Хараа 2050”-ыг шинжихүй. “Үндэсний шуудан” сонин. 2020 оны 4 сарын 9-ний дугаар.

⁶² Мөн тэнд

II үе шат (2031-2040): Хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийн түвшнийг хангах үе.

1. Дэлхийн түвшинд нэр хүнд бүхий өрсөлдөх чадвартай Зүүн хойд Азийн хөрөнгө оруулалтын гол төв болсон байна.

III үе шат (2041-2050): Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар, худалдааг нэмэгдүүлэх үе.

1. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч болсон байна.

Бүгд найрамдах Солонгос Улстай худалдааны хамтын ажиллагааныхүрээг өргөтгөж технологийн хамтын ажиллагааны хэлбэрт шилжүүлнэ.⁶³

Кэйс 3

Хүнсний хувьсгал

2022 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүнсний хувьсгал” хэмээх хөтөлбөрийг 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт эхлүүлсэн. Үүнийг мөн “Хүнсний хувьсгал” Үндэсний хөдөлгөөн гэж нэрлэдэг.⁶⁴

Дүгнэлт

Монгол Солонгосын ерөнхийлөгч нарын эдийн засгийн бодлогыг нэгэн өгүүлэлд бичих боломжгүй. Тиймээс аргагүй болон кэйс судлагаанд тулгуурлаж энэ илтгэлийг бэлдсэн болно.

Хоёр орны эдийн засгийн бодлогод хэд хэдэн чанарын ялгаа байна. Энэ нь юуны түрүүнд БНСУ бол Ерөнхийлөгчийн засаглалтай бол Монгол улсын хувьд Үндсэн хуулийн 3-р бүлгийн 20-р зүйлд зааснаар “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэжээ. Эндээс харахад төрийн дээд эрх мэдлийг Улсын их хурал барьж байна. Үүгээрээ Монгол улсыг парламентийн засаглалтай ч гэж бичдэг. Нэгэнт УИХ төрийн дээд эрх мэдлийг барина гэхээр Ерөнхий сайдын эрх мэдэл ямар байх нь ойлгомжтой юм. Ерөнхийдөө сайд бол сайд нараараа дамжуулаад бүхий салбарыг түүний дотор эдийн засгаа ерөнхийдөө удирддаг. Тиймээс эдийн засгийн бүтээн байгуулалтын хувьд Ерөнхий сайд илүү эрх мэдэлтэй гэж үзэж байна.

БНСУ-ын Ерөнхийлөгч нар эдийн засгийн алдаа оноо, амжилт ололт дутагдал бэрхшээлтэй нэр нь илүү шууд холбогддог бол Монгол улсын хувьд гол хариуцагч эзэн нь Ерөнхий сайд байгаа юм.

Тиймээс хэрэв эдийн засгийн бүтээн байгуулалтыг илүү амжилттай хэрэгжүүлнэ гэвэл Ерөнхий сайдын тууштай чиглүүлгээс гадна Ерөнхийлөгчийн анхаарал санаачлага бас шаардлагатай байх гэсэн логик дүгнэлт урган гарч байна. Үүнээс улбаалан эдийн засгийн томоохон бүтээн

⁶³ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2020 оны 7-р сарын 1. Дугаар 25/1127/ 1245-1420-р талаас тодруулан үзнэ үү.

http://www.ncs.cd.gov.mn/wp-content/uploads/2020/07/2020_25.pdf

⁶⁴ <http://jijigdund.mn/r/427>

байгуулалт хийхэд ерөнхийлөгчийн дэмжлэг туйлаас чухал байж болох юм. Монголд өмнө нь амжилттай хэрэгжсэн томоохон бүтээн байгуулалтууд нь Ерөнхий сайдын зүтгэлээс гадна, Ерөнхийлөгчийн дэмжлэг чухал үүрэгтэй байжээ.

Нөгөөтэйгүүр Монгол улсын эдийн засгийн бүтээн байгуулалтын амжилттай хэрэгжихэд “Эдийн засгийн төлөвлөлтийн Зөвлөл” туйлын чухал байгаа нь харагдаж байна. БНСУ-ын хувьд энэ зөвлөл нь үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан байна.

Цаашид Монгол улсын хувьд аливаа томоохон эдийн засгийн бүтээн байгуулалтыг хийхдээ Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэсэн энэ хоёр институт харилцан дэмжиж, хамтран ажиллах нь уг бүтээн байгуулалтыг амжилттай хэрэгжүүлэх нэгэн чухал хүчин зүйл болохыг Өмнөд Солонгосын жишээнээс харж болно.

БНСУ-ын таван жилийн төлөвлөгөө нь Монгол улсад авч ашиглах хэрэгтэй туршлага гэж үзэж байна. БНСУ-ын амжилттай хэрэгжүүлсэн туршлагаудаас суралцах нь Монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулна гэж үзлээ.

Ашигласан материал

А. Монгол хэлээр

1. Ж. Гөлгөө: “Алсын Хараа 2050”-ыг шинжихүй. “Үндэсний шуудан” сонин. 2020 оны 4 сарын 9-ний дугаар.
2. Монгол улсын Үндсэн хууль. <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1992.html>
3. О Вончөл, Пак Жөнхый: Солонгосын сэргэн мандалт, Орч. Ж. Баттөр, Л. Долгормаа, Б. Ганцэцэг, НЭПКО Пабблишинг, 2013,
4. Т. Намжим, Монголын эдийн засгийн түүхэн гурван цаг үед 2000/а/ 1-р боть.
5. “Төрийн мэдээлэл”сэтгүүл.2020 оны 7-р сарын 1. Дугаар 25/1127/ 1245-1420-р талаас тодруулан үзнэ үү.
6. http://www.ncs.cd.gov.mn/wp-content/uploads/2020/07/2020_25.pdf
7. <http://jijigdund.mn/r/427>

Б. Гадаад хэлээр

8. Address by H.E. Mr. Lee Myung-bak, President of the Republic of Korea, at the 64th Session of the General Assembly of the United Nations. New York. Retrieved from (UNGA,2009.) https://gadebate.un.org/sites/default/files/gastatements/64/64_kr_en_24.pdf
9. Enkhbayar Shagdar, “Neo-liberal “Shock therapy” policy during the Mongolian Economic Transition”. Erine Discussion paper № 0703e April 2007. Niigata Japan pp.13-14.
10. Эрик С. Райнерт, “Как богатые страны стали богатыми, и почему бедные страны остаются бедными”. 5-е изд. Пер. с англ. под науч. ред. В. С. Автономова. Издательство “ВШЭ”. 2017.
11. Global Korea: The National Security Strategy of the Republic of Korea. (Seoul: Cheong Wad ae, 2009), http://englsih.president.go.kr/governmnet/globalkorea/globalkore_eng.pdf

12. Норт Д. Институты, институциональные изменения и функционирование экономики. М., 1997.
13. Haggard S. Pathway from the Periphery: The Politics of Growth in the Newly Industrialization Countries. – London: Cornell University Press, 1990.
14. https://www.kdi.re.kr/eng/research/reportView?pub_no=13671
15. Snyder, S. A. South Korea at the Crossroads: Autonomy and Alliance in an Era of Rival Powers. Columbia University Press. 2018
16. “South Korean Nuclear Policy”, 2023
17. Young-Iob Chung, “South Korea in the Fast Lane: Economic Development and Capital Formation”, Oxford University Press. 2007.
18. “World Nuclear News”, 2023.

The Korean Digital Economic Development Trends and Mongolian Opportunities

БНСУ-ын дижитал эдийн засгийн хөгжлийн чиг хандлага ба Монголын боломж

D.Ulambayar(Sc.D)

(University of the Humanities)

ulambayar@humanities.mn

ABSTRACT

At the end of the 20th century and the beginning of the 21st century, there was a lot of talk and writing about the irreversible globalization based on interdependence, but now I am writing about the irreversible digitization in all fields of the world and its impact on humanity. Digitalization has brought enormous savings to the economy and turned our stereotypes of space-time upside down.

In South Korea, the digital process has become an irreversible process, covering all socio-economic sectors. Today's South Korea is a country with great material and spiritual potential to make unprecedented progress in science and technology in the new millennium. It is emphasized again that South Korea ranks highest in the world in terms of information and communication technology, high-tech infrastructure, high-speed internet per capita, and integration and innovation between key economic structures.

One of the important directions of cooperation in the field of strategic partnership between Mongolia and the Republic of Korea is the digital sector, and cooperation in this direction will be deepened.

Keywords: digitization, cyber space, internet, digital revolution, e-society, online trade, soft infrastructure, etc.,

I. Дижитал хувьсгал, дижитал эдийн засаг

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний хамгийн том нээлт нь өөрсдийн амьдрах оронзай, цаг хугацаагаа цоо шинээр, гэхдээ хязгааргүй “тэлсэн” явдал юм. *Cyber space* хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ шинэ оронзай хүн төрөлхтний амьдралд язгуур өөрчлөлт гаргаж, цаашид ч олон суурь өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой болов. Дижитал үйл явц эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдалыг үлэмж бууруулж байна. Нөгөө талд дижитал технологийн хурдацтай хөгжлийн үр дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам эмзэг болж, кибер орон зай дахь сөрөг үйлдлээс санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл

учирч болзошгүй байдал үүсээд буй. Кибер аюулгүй байдлыг хангах нь мэдээллийн аюулгүй байдлаас огт өөр, шинэ ойлголт болно.

Дубайн World Government Summit дээр хүний тархи болон түүний дижитал хувилбар хоёрын хооронд мэдээлэл солилцох хурдны тухай, тэдгээрийн нэгдлийн тухай, хүний оюун ухааныг нүүлгэн шилжүүлэх өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнөх болов. *Хүн ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн ч түүний бүх мэдээлэл, дижитал хуулбар амьдралаа цааш нь үргэлжлүүлэх боломжийг олгох гэнэ.*

Дижитал оюун ухааны хөгжилд cognitive neuroscience нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч квант компьютерын хөгжил түүнийг орвонгоор нь өөрчлөхөөр байна.

Blockchain технологи хөгжлийн шинэ боломжийг нээсэн хэдий ч квант компьютерын хөгжил түүний схемийг бусниулж, итгэхэд нэн бэрх квант орны цоо шинэ нөхцөл байдлыг буй болгохоор байна. *Blockchain* сайтын мэдээлснээр биткойны 90 хувийг нэгэнт олборлож, нээлттэй зах зээлд арилжаалагдаж байгаа бөгөөд урьдчилсан тооцооллоор үлдсэн сүүлчийн 10 хувийг өндөр хүчин чадалтай супер компьютер ашигласан ч 2140 оны 2 дугаар сар хүртэл олборлож, зах зээлд нийлүүлэхээр байгаа ажээ. Өөрөөр хэлбэл 100 илүү жил шаардагдаж байна. Тэгвэл квант компьютер энэ асуудлыг хоромхон зуур шийдвэрлэж чадах ажээ. *Квант компьютерын үйлдэл нь бурханд хамгийн ойрхон дөхөж очих шийдэл болно гэж мэргэжилтнүүд нь тэмдэглэх болжээ.*

Ухаалаг төхөөрөмжүүд (smart objects) өндөр хурдны интернет сүлжээний суурь бүтэц (infrastructure), ложистикоор интеграцчлагдаж, объектуудыг алсаас мэдрэх, удирдах, хянах боломжтой (Internet of Things-IoT) болж, 6G хэрэглээнд нэвтэрч эхлэв.

Metaverse бидний паралелль ертөнц буюу хоёрдахь амьдрал болохоор байна. Амьдралын нэн чухал зүйлс бүгд дижитал хэлбэр рүү шилжиж, тийнхүү дижитал амьдрал бидний бодит амьдралаас илүү үнэ цэнэтэй орчин болох ажгуу.

OpenAI-ийн эхлүүлсэн ChatGPT нь дижитал оюун ухааны салбарт хурдацтай, урьд өмнө байгаагүй их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж эхэлсэн нь цоо шинэ нөхцөл байдлыг буй болгож байна.

Дижитал технологи урьдаас төсөөлж байгаагүй зүйлсийг бие даан хийж эхлэх л юм бол бид амьдралын цоо шинэ хэлбэртэй нүүр тулсан гэж ойлгох хэрэгтэй болж байна.

Дижитал эдийн засаг гэдэг нь бизнесийн цоо шинэ модель бөгөөд дижитал технологийг ашиглан cyber орчинд цоо шинэ нэмэгдсэн өртөг буй болгох явдал бөгөөд цоо шинэ хэрэглээг санал болгодог.

Эдүгээ үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болон хувирав.

Гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасч, даяаршил, дижитал үйл явц үндэсний аюулгүй байдлын шийдвэрлэхүйц хүчин зүйл болов. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмийг баримталж байгаа нь бүхэлдээ дижитал технологит суурилж байна.

Бүр 1989 онд Солонгос гаралтай Японы судлаач Т.В.Канын бичсэн «Солонгос дараагийн Япон мөн үү?: Америкийн дараагийн өрсөлдөгчийн бүтэц, стратеги, тактикийг ойлгох нь»⁶⁵ нэртэй бүтээл Нью-Йорк хотноо хэвлэгдэн гарсан нь нилээд дуулиан тарьсан билээ.

⁶⁵ T.W.Kang. Is Korea the next Japan?: Understanding the Structure, Strategy, and Tactics of America's Next Competitor. Free Press. The University of California. N.Y.: 1989

Азийн «шинээр аж үйлдвэржсэн» БНСУ нийтлэг шинж бүхий хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжиж иржээ. Энэ нь нэгд: 1960-аад онд импортыг орлох үйлдвэрлэлийг бүх талаар хөхиүлэн дэмжих, хоёрт, 1970-аад онд үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөн хүнд үйлдвэр, экспортын чиг баримтласан үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, гуравт, 1980-90-аад оноос оюуны багтаамжтай өндөр технологи, цахим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэж иржээ. Дөрөвт, XXI зууны хоёрдахь арван жилээс дижитал технологийн салбарт дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэх бодлого явуулж байна гэж үзэж болохоор байна.

II. БНСУ-ын дижитал үйл явц

Өнөөгийн БНСУ нь шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай орон юм. БНСУ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь буюу дээд бүтэц (infrastructure), нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацчлалаар дэлхийд хамгийн өндөрт орж байна. 2021 оны «*The Economist*» сэтгүүлийн судалгаагаар Өмнөд Солонгос мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадавхиар дэлхийд 3 дугаарт, e-бизнесээр 10 дугаарт, e-засаглалаар 6 дугаарт орж байсан нь хуучирсан тоо болов. 2024 оны 3 дугаар сарын “*Forbs*” судалгаагаар дэлхийд өндөр хурдны интернет хэрэглэгчид 5.3 тэрбум, e-бизнесийн нийт үнийн дүн 5.8 их наяд ам. доллараар хэмжигдэж, 2.5 тэрбум хүн ажил, амьдралаа явуулж буй ажээ.⁶⁶

2021 оны 7 дугаар сард Женев дэх НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал байгууллагын 68 дахь чуулган зохион байгуулагдаж, БНСУ-ыг хөгжингүй орон болсныг зарлаж, статусыг нь шинэчилж санал нэгтгэйгээр тус улсыг хөгжингүй орны гишүүнчлэлд оруулсан байна.⁶⁷ Өмнөд Солонгос нь олон жилийн турш НҮБ-ын донор гол орнуудын нэгээр явж иржээ. Тус агентлаг 1964 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш анх удаа хөгжиж буй орны бүлгээс аль нэг улсын статусыг хөгжингүй болгон өөрчилсөн нь энэ удаагийн чуулган байв.

2017 онд БНСУ-ын ерөнхийлөгчийн дэргэд Аж үйлдвэрийн IV хувьсгалын хороог байгуулжээ. Энэ хороо 2017 оны 11 дугаар сард БНСУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор «*e-Korea: Towards Digitization*» сэдэвт олон улсын томоохон арга хэмжээ анх удаагаа болж өнгөрөв. Энэ үеэр шинээр эмхлэн байгуулагдсан Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа-холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн сайд Юү овогтын (Yu Yeong-min) тэмдэглэснээр: “Дэлхий ертөнц дижитал хувьсгалын үр дүнд үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүч, хуваарилалт болон кибер ертөнцийн үйл явцыг хувирган өөрчлөөд зогсохгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын чанар, хэв маягийг ч үндсээр нь өөрчилж байна” гэжээ. Гадаад худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайд Пэйк овогт (Paik Ungyu) хэлэхдээ: «Солонгосын эдийн засаг, үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчилж буй гол хүчин зүйл, динамик нь **e-revolution** болж байна” гэжээ. Тэрбээр цааш нь хэлэхдээ: “Бидний ирээдүйг чиглэсэн шинэ үйлдвэрлэл бол ИТ (information technology), NT (nano-technology), BT(bio-technology), NPM (new and precision materials буюу метал, шингэн, хий, хатуу нягт бодисыг шинэ технологийн инновацчлалын

⁶⁶ 35 E-Commerce Statistics of 2024. March 28, 2024

<https://www.forbes.com/advisor/business/ecommerce-statistics/>

⁶⁷ UN agency upgrades Korea's status to developed economy

July 5, 2021 <https://www.korea.net/NewsFocus/policies/view?articleId=200509>

туслалцаатайгаар хослуулж цоо шинэ үеийн материал гаргаж авах), ET (environment and new energy technology), Optical sectors (гэрлийн энерги, долгионы хурд, уртын онцлогийг ашигласан технологийг машин, механизм, үйлдвэрийн эд ангиуд, системийн үйлдвэрлэл, лазерийн үйлдвэрлэл, роботчлол, хараазүйн судлал), Aerospace technology юм. Тиймээс ирэх жилүүдэд R&D (Research and Development) чиглэлд үлэмж хөрөнгө оруулалт хийнэ” гэсэн байна. Rockwell International группын тэргүүн бөгөөд CEO солонгос гаралтай америк Davis Dong тэмдэглэн хэлэхдээ: “*e-manufacturing* гэдэг нь мэдээллийн технологид суурилсан е-бизнесийн моделиар жолоодон тухайлбал, үлэмж том цахилгаан станцын үйлдвэрлэлийг ч энэхүү хувьсгалын үр дүнд кибер орчинд буй болгосон цагт, үлэмж том үйлдвэрлэлийн бодит бүтээмжийг дараагийн түвшинд буй болгох болно”⁶⁸ гэсэн байна. Энэ бол *internet economics* буюу *digital economy* ажээ.

“Korea Telecom”-ын мэдээлснээр өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн суурь бүтэц (infrastructure) цогц бүрдсэн нь Солонгосчуудын амьдралын чанарыг үндсээр нь өөрчилж байгаа ажээ. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд интеграцлагдсан 50 мянган төрийн институци *e-government*-ийг нэгэнт буй болгож, энэ нь солонгосчуудад хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон 13 мянга гаруй дунд, их, дээд сургууль өндөр зэрэглэлийн чанартай *e-education* тогтолцоог буй болгожээ. 3.5 сая жижиг, дунд үйлдвэрлэгчид дижиталчлагдсан системд холбогдон *e-commerce*-г суурилсан *B-to-B*-гийн (*Business-2-Business*) гарцтай болсон байна. Мэдээллийн технологид үндэслэсэн бизнесийн хувьсгал ажлын байрны зах зээлийг эрс өргөжүүлж, нэмэгдсэн өртөг илүү өндөр шингээсэн бизнесийг буй болгов. Өндөр хурдны сүлжээнд суурилсан *on-line* эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Энэ бүгдийн үр дүнд Шинэ мянганы эрин үеийн эхнээс Солонгос нь *e-Society*-г байгуулж байгаа ажээ.⁶⁹

Өмнөд хөрш БНХАУ 2017 оны 7 дугаар сард «Дараа үеийн хиймэл оюун ухааны хөгжлийн төлөвлөгөө-2030»⁷⁰, хойд хөрш ОХУ 2019 оны 10 дугаар сард «Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх Үндэсний стратеги-2030»⁷¹ баримт бичгийг тус тус батлан гаргажээ.

Өнөөдөр дэлхийн улс орнууд хиймэл оюун ухаанаас үүдэлтэй асар том өөрчлөлттэй тулгарч байна. БНСУ-ын Засгийн газар 2019 оны 12 дугаар сарын 17-нд хиймэл оюун ухааны үндэсний стратегийг баталсан.⁷² БНСУ “Мэдээллийн технологиос цааш хиймэл оюун ухаантай дэлхийн удирдагчийн зүгт” (Toward AI World Leader beyond IT) гэсэн алсын хараагаар дижитал технологийг эрс эрчимжүүлэхийг зорьж байна. 2030 он гэхэд өрсөлдөх чадвар, хиймэл оюун ухааны эдийн засгийн асар их үр нөлөөг бий болгож, хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулна гэж үзэж байгаа ажээ. Хиймэл оюун ухааны

⁶⁸ *e-World: Towards Digitization*. Ang Byong-yub speech. “The Korea Times” 2017.11.09

⁶⁹ “[Korea Communication Market Data](#)”. Netmanias. 30 May 2021. [Archived](#) from the original on 15 August 2022. R

⁷⁰ China’s *Next Generation Artificial Intelligence Development Issued Plan* by State Council. China’s Strengths Creates Innovation Miracle.

<https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/full-translation-chinas-new-generation-artificial-intelligence-development-plan-2017/>

⁷¹ Russian “*National Strategy for the Development of Artificial Intelligence for the period until 2030*”. Moscow 11 October, 2019 <https://tass.com/economy/1082644>

⁷² National Strategy for Artificial Intelligence <https://www.msit.go.kr/bbs/view.do?sCode=eng&nttSeqNo=9&bbsSeqNo=46&mId=10&mPic=9>

гурван чиглэлээр 9 стратегийн хүрээнд Засгийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх 100 үйл ажиллагааны зорилт түүний дотор экосистем, хиймэл оюун ухааны хэрэглээ, хүн төвтэй хиймэл оюун ухаанаас бүрдэж байна.⁷³

АНУ, ЕХ, БНСУ, Хятадын тэргүүлэх их сургуулиуд “Хиймэл оюун ухааны бакалавр, магистрын түвшний боловсролын мэргэжлийн хөтөлбөрийг нэгэнт хэрэгжүүлж эхлээд байна.

Дижитал технологийн салбарт зах зээлийн судалгаа хийж, дүн шинжилгээ гаргах, мэргэжлийн өндөр зэрэглэлийн зөвлөгөө үзүүлдэг Global Brands magazine зэрэг олон улсын нэр хүндтэй сэтгүүлийн 2023 оны чансааны үнэлгээгээр дэлхийн хөдөлгөөнт холбооны топ 10 компаний тэргүүнд Samsung Electronics, *хоёрт*, Apple Inc, *гурв*, Хятадын Xiaomi, *дөрөвт*, Хятадын Oppo, *тавд*, Хятадын Vivo Communication Technology, *зургаад*, Хятадын Huawei, *долоод*, Хятадын Realme, *наймд*, АНУ-ын Google, *ес*, АНУ-ын Motorola Mobile, *аравт*, Хятадын OnePlus Technology компаниуд орж байна.⁷⁴ Өмнөд Солонгосын LG зэрэг бусад үндэстэн дамнасан корпорациуд мөн дээгүүрт ордог.

Дэлхийн хөдөлгөөнт холбооны зах зээл дээр Samsung Electronics-ийу андронд үйлдлийн системтэй Galaxy S загварын гар утас багтай байр сууриа нэгэнт эзлэв. Samsung групп «хатуу диск уншигч» (DHN) үйлдвэрлэгч АНУ-ын Seagate technology хэмээх дэлхийн хамгийн том компанийн өндөр технологийн үйлдвэрлэл, Rolls-Royce Airbus A380 онгоцны Trent 900 загварын хөдөлгүүр, Boeing 787 Dreamliner-ийн төсөлд гол үүрэг гүйцэтгэж байгаа ажээ. Өмнөд Солонгосын *biopharmaceuticals*-ын салбарын хөгжил дэлхийд тэргүүлэх байранд гарч ирэв.

2024 оны 1 дүгээр сард Samsung Electronics хамгийн сүүлийн үеийн шинэ бренд “Galaxy S24 Ultra”, “S24 Plus” ухаалаг гар утсаа танилцуулав. Samsung Electronics нь Galaxy хамгийн сүүлийн үеийн загваруудад хиймэл оюун ухааны системийг суулгажээ. Тухайлбал, утсаар ярих үед шууд орчуулах функцтэйгээс гадна камерын үзүүлэлтүүдийг үлэмж сайжруулсан байна.⁷⁵

Мэдээж гол асуудал нь *cyber* ертөнцөд дижитал технологийн аюулгүй байдлыг найдвартай хангах тухай юм. Тиймээс 2002 онд «Кибер орон зайг террорист халдлагаас хамгаалах тухай хууль»-ийг хууль тогтоох дээд байгууллага Үндэсний Ассамблейгаас батлан гаргасан байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжил уламжлалт эдийн засгийн бүтцийг өөрчилж дижитал эдийн засгийг шинээр буй болгож байна. Тиймээс хүн төрөлхтөн дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицоос гадна дижитал ертөнцөд дасан зохих шаардлагатай болов.

ДНБ-тэй холбоотой шинэ судалгаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНСУ тэргүүлж байгаа юм. R&D-д хэн хөрөнгө оруулалт хийж байна, тэнд *digital revolution* явагдаж байна. 2022 онд БНСУ-ын хувийн хэвшил болон Засгийн газрын судалгаа, хөгжилд (R&D) оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ ₩112.64 их наяд (85.46 тэрбум ам.доллар) болсон нь өмнөх оныхоос ₩10.51 их наяд буюу 10.3 хувиар өссөн үзүүлэлт болсон байна.⁷⁶

⁷³ *Ibid*,

⁷⁴ Top 10 Mobile Brands in the World 2023. <https://www.globalbrandsmagazine.com/top-10-mobile-brands-in-the-world-2023/>


⁷⁵ Samsung PH sees record pre-orders with Galaxy S24 Series. 1/01/2024 <https://news.samsung.com/ph/samsung-ph-sees-record-pre-orders-with-galaxy-s24-series>

⁷⁶ “Private sector accounts for 80% of Korean R&D investment in 2022” 2023.12.11 https://www.investkorea.org/ik-en/bbs/i-465/detail.do?ntt_sn=492385#:~:text=

Монгол Улс шинжлэх ухаан, технологийн хөгжилд ДНБ-ийн 0.12 хувийг зарцуулж байгаа нь гайхмаар доогуур үзүүлэлт болно.⁷⁷ Монгол Улс 2019 оны Дижитал өрсөлдөгч чадавхийн үнэлгээгээр 63 орноос 62-т,⁷⁸ 2019 оны Мэдээлэл харилцаа, холбооны технологийн хөгжлийн индексээр 176 орноос 91-д,⁷⁹ Монгол Улсын ДНБ-д Мэдээллийн технологийн жин 2,1 хувийг эзэлж байна.⁸⁰

2022 оны 4 дүгээр сард ДНБ-тэй холбоотой шинэ судалгаа, төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээгээр БНСУ дэлхийд тэргүүлжээ. Энэ тухай тус улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа-холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн яам 2021 оны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн мэдээлсэн байна. Тус яамны мэдээллээр, ДНБ-тэй холбоотой шинжлэх ухаан-судалгааны болон туршилт-загвар бүтээх ажлын эрчимтэй байдлын үзүүлэлт БНСУ-д 4.55 хувьтай гарчээ. Тус улсын дараагаар Израиль 4.54 хувьтайгаар орсон байна. 2000 онд Өмнөд Солонгосын энэ үзүүлэлт 2.18 хувьтай, харин Израиль улсынх 3.94 хувьтай байжээ. OECD-ын талаарх дундаж үзүүлэлт 2.37 хувьтай байсан нь 2016 оныхоос бага зэрэг өссөн үзүүлэлт байжээ. Энэ нь БНСУ, АНУ, Японтой холбоотой хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Жагсаалтын гуравдугаарт, Швейцарь улс орж, тус улсын дараагаар Швед, Япон, Австри, Дани, Герман, АНУ болон Франц улс бичигдэж байв.⁸¹

График 1. 2022 онд дэлхий даяар судалгаа, хөгжилд хамгийн их мөнгө зарцуулсан компаниудын зэрэглэл (тэрбум ам. доллар)



Source: © Statista 2024

⁷⁷ ДНБ-ий 1 хувийг эрдэм судлалын ажилд зарцуулах хэрэгтэй. 2019.09.27 <https://president.mn/11094/>

⁷⁸ The Global Competitiveness Report 2019. Klaus Schwab. World Economic Forum http://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf

⁷⁹ WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Countries. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>

⁸⁰ Ibid,

⁸¹ Ranking of the companies with the highest spending on research and development worldwide in 2022 (in billion U.S. dollars) <https://www.statista.com/statistics/265645/ranking-of-the-20-companies-with-the-highest-spending-on-research-and-development/>

2019 оны 6 дугаар сард Харилцаа холбооны зургаадугаар үеийн 6G сүлжээний үндсэн технологийг хөгжүүлэх судалгааны төвийг нээсэн тухайгаа “Samsung” компани мэдэгдэв.⁸² “Samsung Research” судалгаа, боловсруулалтын байгууллага нь гар утасны сүүлийн үеийн технологи, харилцаа холбооны дараагийн үеийн сүлжээг хөгжүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулах юм. “5G” сүлжээ эхний зах зээлүүддээ нэвтэрч, дэлхийн олон орны гар утасны сүлжээнд “4G LTE” сүлжээг ашиглаж буй энэ үед “6G” сүлжээг хөгжүүлэх нь “Samsung” компанийн урт хугацааны бизнес төлөвлөгөөний нэгээхэн хэсэг ажээ. “Samsung” компани өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхээр дэлхийн анхны “5G” сүлжээг дэмждэг “Galaxy S10 5G” ухаалаг гар утсыг худалдаанд гаргасан юм. Дашрамд дурдахад, БНСУ-ын цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэгч “LG” компани Солонгосын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэнтэй хамтран “6G” технологийг хөгжүүлэх лабораторийг Тэжон хотод 2019 нэгдүгээр сард нээсэн билээ.

2024 оны 2 дугаар сард 10 гүрэн 6G сүлжээг хөгжүүлэх үндсэн зарчмуудын талаар тохиролцож, тусгай тунхаглал баталсныг Испанийн Барселон хотноо зохиогдсон “Mobile World Congress” үзэсгэлэн нээгдсэнтэй холбогдуулан зарлажээ. Тусгай Тунхаглалд Австрали, Их Британи, Япон, Канад, БНСУ, Франц, Швед, Чех болон АНУ нэгдсэн байна.⁸³

Хагас дамжуулагч буюу чипний үйлдвэрлэл бол БНСУ-ын дижитал технологийн дэлхийд тэргүүлэх салбар билээ. Өмнөд Солонгосын хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн түүх 1965 оноос эхэлжээ.⁸⁴ 1983 онд БНСУ нь АНУ, Японы дараа 64K DRAM хөгжүүлсэн дэлхийн гурав дахь орон болсон бол 1992 онд БНСУ DRAM зах зээлд тэргүүлжээ. Харин 2013 онд дэлхийн анхны 3D V-NAND флаш санах ойг худалдаанд гаргажээ. Тийнхүү БНСУ-д 1980-аад оноос хойш хагас дамжуулагчийг компьютер болон бусад төхөөрөмжид их хэмжээгээр ашигласнаар хагас дамжуулагчийн үйлдвэрлэл эдүгээ эрчимтэй үргэлжлэн хөгжиж байна. Өмнөд Солонгос 2022 онд дэлхийн хагас дамжуулагчийн зах зээлийн 17.7 хувийг эзэмшиж, 2013 оноос хойш 10 дахь жилдээ дараалан дэлхийд хоёрт бичигдсэн хэвээр байна.⁸⁵

Тус улс дэлхийн санах ойн хагас дамжуулагчийн зах зээлийн 60.5 хувийг эзэлж, DRAM-ын (Dynamic Random Access Memory) зах зээлийн 70.5 хувийг, NAND-ын (not and) зах зээлийн 52.6 хувийг эзэлж байна. БНСУ өрсөлдөх чадвараа хадгалахын тулд судалгаа, боловсруулалт, хөрөнгө оруулалтад тасралтгүй анхаарч байгаа юм. Өөр нэг дурдахад, Өмнөд Солонгос нь хэт нарийн боловсруулалтын (ultra-fine processing) технологид суурилсан цутгамал үйлдвэрийн зах зээлд (foundry market) эзлэх хувийг өргөжүүлэхээр ажиллаж байна. Тус улс дэлхийн цутгамал үйлдвэрийн зах зээлийн 17.3 хувийг эзэлдэг.⁸⁶

Бүдүүвч 1. БНСУ-ын чипний үйлдвэрлэл 2022

⁸² Samsung opens research center to begin initial work on 6G. May 4, 2019 <https://www.techspot.com/news/80382-samsung-opens-research-center-begin-initial-work-6g.html>

⁸³ Korea joins 10-nation statement on endorsing 6G principles. 2024-02-27 https://www.koreatimes.co.kr/www/tech/2024/04/129_369590.html

⁸⁴ “The rise of Korea's semiconductor industry”. *KBS WORLD*. July 10, 2017.

⁸⁵ “South Korea invests big in becoming a global chip leader”. *DW News*. January 24, 2024.

⁸⁶ “South Korea's Semiconductor Output Rises by Most in 14 Years”. *Bloomberg*. March 29, 2024.






График 2. Semiconductor Market Shares of Major Producers (2001~2022)




Бүдүүвч 2. БНСУ-ын дижитал хөгжлийн чиглэл



График 3. Амьдралын дижитал өндөр чанартай, өрсөлдөх чадвартай



Бүдүүвч 3. Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын эрэмбэ, Глобал инновацийн индекс



Ranked: The Most Innovative Countries in 2023

https://www.visualcapitalist.com/most-innovative-countries-in-2023/#google_vignette November 14, 2023

Дижитал үйл явц эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, орон зай-цаг хугацааны тухай бидний *stereotype*-ийг үндсээр нь өөрчилж байгаа билээ. Дижитал эдийн засгийн хамгийн эхний үе шат нь халбага үйлдвэрлэж байгаад сэрээ, эсвэл савх үйлдвэрлэхээр бол зүгээр л программыг нь өөрчлөөд **“enter”** товчлуурыг дарахад л хангалттай. Энэ бол программчлалын хүч юм.

Дижитал эдийн засгийн хөгжлийн дараагийн үе шатанд интернетэд холбогдсон кибер орон зайд *big data*, ухаалаг төхөөрөмжүүдийн холболтоор үнэ цэнэтэй цоо шинэ өртөг буй болгох үйл явц юм. Энэ бол бизнесийн цоо шинэ моделийг угсарч буй хэрэг даруй мөн. Тиймээс энэ бол цахим эдийн засаг биш, мөн тоон технологи ч биш юм. Дижитал эдийн засаг гэдэг нь нэгд, интернет сүлжээн дээр

суурилна, *хоёрт*, программ хангамж дээр суурилсан эдийн засаг юм, *гуравт*, аппликашн, платформ дээр суурилж байна. *Дөрөвт*, кибер хязгааргүй орон зайд ажиллах эдгээр болно.

Тиймээс дижитал эдийн засгийг хөгжлүүлэхийн тулд технологийн суурь байгууламж буюу soft & hard дээд бүтэц, ложистик, инновацийг дэмжсэн бодлого, мэдлэг болон мэдээлжсэн нийгмийн нөхцөл бүрдсэн байх явдал болно.

Дижитал эдийн засаг нь төр засгийн дэмжих бодлого, нийгэм, мэдлэгийн хүлээж авах бэлэн байдал, зөөлөн болон хатуу суурь байгууламж (soft & hard infrastructure), үйлчилгээний суурь буюу дээд бүтцээс бүрддэг.

Уур амьсгалийн өөрчлөлтөд “тэсвэртэй эдийн засаг”-ийг (climate-resilient economy) цогцлоох тухай өргөн хүрээнд хэлэлцэгдэж байна. Түүнчлэн ногоон эдийн засгийн цөм болсон сэргээгдэх эрчим хүчний хөгжил тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтэй холбоотойгоор гол мөрний ус татарснаар усан цахилгаан станц, салхин станцуудад асуудал үүсч байгаа ажээ.

БНСУ дижитал технологид суурилсан халуун цөмийн гинжин урвалын реакторыг бүтээж, наран дээрх эрчим хүчийг гарган авах мөч хаяанд иржээ. Үүнийг “artificial sun” гэж нэрлэж байна.⁸⁷ Ус төрөгчийн бөмбөгийн дэлбэрэлт нь нарны өдөр тутмын ердийн амьдрал билээ. Энэ бол эрчим хүчний шавхагдашгүй эх сурвалж мөн. Халуун цөмийн реактор нь бүрэн төгс аюулгүй бөгөөд учир нь, түүн дотор дэлбэрэх зүйл огт байхгүй гэдэг нь хамгийн гол онцлог ажээ. Дулааны болон атомын цахилгаан станцуудаас ялгаатай нь халуун цөмийн гинжин урвалын реактор нь хүлэмжийн хийгээр агаар мандлыг бохирдуулахгүй, цацраг идэвхт хорт хог хаягдал ялгаруулахгүй ажээ.⁸⁸ Энэхүү мега төсөл бол цоо шинэ үеийн технологит суурилсан дэлхийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах тухай асуудал болж байна. БНСУ-ын эрдэмтэд цөмийн нэгдлийн туршилт явуулж нарны цөмөөс долоо дахин их буюу 100 сая хэмийн температурыг үүсгэн дэлхий дээд амжилтыг тогтоов.⁸⁹ Энэхүү туршилт нь ирээдүйн энергийн эх үүсвэрт хүрэх чанарын цоо шинэ алхам болно гэж эрдэмтэд онцолжээ. “Өндөр температур болон өндөр нягтралшилтай плазма нь ирээдүйн цөмийн нэгдлийн дээд амжилтуудыг дахин тогтооход гол үүрэгтэй” гэж туршилтыг амжилттайгаар явуулсан “Fusion Energy” хүрээлэнгийн (KFE) дэргэдэх “KSTAR” судалгааны төвийн захирал Си-Бу Юн (Si-Woo Yoon) мэдэгджээ.

“KFE”-ийн “хиймэл нар” гэгддэг хайлуулах судалгааны төхөөрөмж “KSTAR” нь 2023 оны арванхоёрдугаар сараас 2024 оны хоёрдугаар сарын хооронд хийсэн туршилтын явцад плазмыг 100 сая градусын температурт 48 секундийн турш барьж чадсан байна. Энэхүү амжилт нь 2021 онд тогтоосон 30 секундийн өмнөх рекордыг ахиулсан юм.

Цөмийн нэгдэл нь нар болон бусад оддын гэрэлтүүлэх урвалыг давтаж, хоёр атомыг нийлүүлснээр хязгааргүй их эрчим хүч ялгаруулах явдал бөгөөд ба нэг элементийн хоёр атомыг нэгтгэж гурав дахь, илүү хүнд элементийн атомыг үүсгэдэг явц ажээ. Реакторын түүхий эд нь uranium 235 биш, харин байгальд элбэг байдаг устөрөгчийн изотопууд болох дейтерий (deuterium) ба тритий (tritium) (хэдэн грамм) ажээ. Тиймээс цацраг идэвхит бодис ялгаруулна гэсэн ойлголт байхгүй юм. Цэвэр эрчим

⁸⁷ ITER: *World's largest nuclear fusion project begins assembly*. 28 July 2020

<https://www.bbc.com/news/science-environment-53573294>

⁸⁸ ITER: *Ceremony marks start of the assembly phase*. 28 July 2020, Brussels Energy

https://ec.europa.eu/info/news/iter-ceremony-marks-start-assembly-phase-2020-jul-28_en

⁸⁹ ‘Artificial sun’ sets record for time at 100 million degrees in latest advance for nuclear fusion

<https://edition.cnn.com/2024/04/01/climate/nuclear-fusion-record-korea-climate-intl/index.html>

хүчний шийдлийн “ариун дагшин” гэгддэг энэхүү цөмийн нэгдэх явц нь нүүрстөрөгчийг огт ялгаруулахгүйгээр эрчим хүчний шавхагдашгүй эх үүсвэрийг бий болгоход оршино.

Дижитал худалдаа, санхүүгийн технологийг (FinTech) эдүгээ олон нийт өргөн хүрээнд ашигладаг өдөр тутмын энгийн зүйл болов. Финтек гэдэг нь дижитал технологид суурилсан санхүүгийн үйл ажиллагаа буюу блокчейн технологийн санхүүгийн салбар дахь access гэж томъёолж болно. Өнөөдөр online худалдаа, санхүүгийн үйл ажиллагааны загварыг дижитал технологийн хөгжүүлэлтийг ашиглан өөрчилж буй шинэ салбар юм.⁹⁰ *Нөгөө талд хөгжлийн чухал тренд нь банк, санхүүгийн байгууллага, үүрэн телефоны компаниуд хоорондын интеграци гэж нэрлэж болно.* Өнөөдөр дэлхий нийтийн хэмжээнд гүйлгээнд буй мөнгөний 90 хувь нь цахим хэлбэрт, 10 хувь нь бэлнээр хийгдэж байгаа бол АНУ-д 30 долларын 29 нь цахим хэлбэрт 1 доллар нь бэлнээр хэрэглэгдэж байгаа ажээ.

Их өгөгдөл буюу *big data* нь шинэ стратеги, багцыг бий болгох, хэрэглэгчийн зарцуулалтын зуршилд дүн шинжилгээ хийх, залилангийн илрүүлэлтийг сайжруулах, маркетингийн стратегийг бий болгохын тулд үйлчлүүлэгчийн хөрөнгө оруулалт болон зах зээлийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах боломжтой болгож байгаа ажээ.⁹¹

III. Монгол Улс дахь дижитал хөгжлийн эрхзүйн орчин

Хууль эрхзүйн орчин: Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлын үеэр мэдээллээр Монгол Улсын хүн ам цөөн ч 2022 оны 7 дугаар сарын байдлаар гар утас хэрэглэгчийн тоо 4.3 саяд хүрчээ. Үүний 3.4 сая ухаалаг гар утас хэрэглэгч байгаагаас 64 хувь нь 4G өндөр хурдны интернэт хэрэглэдэг байна. Нийт ухаалагч гар утас хэрэглэгчдийн 93 орчим хувь нь санхүүгийн байгууллагад данстай бөгөөд 22 орчим хувь нь уг дансаа гар утсаараа дамжуулан удирддаг байна. Ухаалагч гар утас хэрэглэгчдийн дийлэнх хувь буюу 2.5 сая хэрэглэгч нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцдог. Нийт 96 их, дээд сургуульд 160 орчим мянган оюутан суралцаж байгаагийн 2.3 хувь нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын чиглэлээр суралцдаг. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар ДНБ-ий 2.3 хувийг бүрдүүлдэг. Монгол Улсад нийт 3,500 орчим харилцаа холбоо, мэдээллийг технологийн компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 33 хувь нь санхүүгийн, 30 хувь нь боловсролын, 14 хувь нь бусад салбарын чиглэлээр ажилладаг байна.⁹² Улаанбаатар хотын орчинд 5G сүлжээнд шилжих бэлтгэлийг Univision эхлүүллээ.

2022 оны II улирлын байдлаар интернет хэрэглэгч 4.1 сая болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувь, кабелийн телевиз хэрэглэгч 975.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар тус тус өссөн байна.⁹³ Дээрх тоон үзүүлэлтээс харахад Монгол Улсад финтек хөгжих боломж хэдийн бүрдсэн гэж дүгнэж болохоор байна

УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улсад цахим шилжилт хийх хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэв. УИХ-ын 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Инновац, цахим бодлогын байнгын хороо дангаараа болон Хууль зүй, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон

⁹⁰ Schüffel, Patrick (2016). Taming the Beast: A Scientific Definition of Fintech. Journal of Innovation Management. pp. 32–54

⁹¹ Xu, Lei; Gao, Runpeng; Xie, Yu; Du, Peng (January 2019). [“To Be or Not to Be? Big Data Business Investment Decision-Making in the Supply Chain”](#). Sustainability. 11 (8): 2298. doi:10.3390/su11082298.

⁹² УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улс, БНСУ-ын мэдээллийн технологийн салбарын байгууллага, мэргэжилтэн, судлаачдын хамтарсан “Цахим шилжилтэд анхаарах асуудал” сэдэвт анхдугаар уулзалт, хэлэлцүүлэг. 2022.07.19 <http://www.parliament.mn/n/1y4yn>

⁹³ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. 2022.08.17

Эдийн засгийн байнгын хороотой хамтран хэлэлцэж УИХ-ын нэгдсэн чуулган *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай анхдагч хууль зэрэг таван хуулийг* баталснаар Монгол Улс дэлхий дахинаа өрнөж буй аж үйлдвэрийн IV хувьсгалд суурилсан дижитал үйл явцтай хөл нийлүүлэн алхаж, цахим шилжилт хийх хууль, эрхзүйн орчин бүрдэж байгаа юм.⁹⁴

Дэлхий дахинд өргөн тархаж буй блокчэйн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ Монгол Улсад ч өргөн дэлгэрч ялангуяа 2021-2022 онд виртуал хөрөнгийн арилжааны платформын тоо ихээр нэмэгдэж, койн, токен гаргах нь олширч, олон нийтээс хөрөнгө татахын зэрэгцээ иргэд, олон нийт эдгээрт хөрөнгө оруулах сонирхол нь өсөн нэмэгдсээр байгаа юм.

Энэ хууль батлагдсанаар төвлөрсөн бус тархмал систем (блокчэйн), дэвшилтэт технологи дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, виртуал хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг, цахим шилжилтийг дэмжсэн, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох харилцааг зохицуулсан эрхзүйн орчинтой улс орон албан ёсоор болсноор гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, цаашид эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэж байна.

Дижитал эдийн засгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон финтех хэмээх хүртээмжтэй санхүүгийн цоо шинэ үйлчилгээ, дижитал худалдаа Монгол Улсад ч хөгжлийн шинэ тренд болов.

IV. Төгсгөл

XX зууны сүүлч, XXI зууны эхнээс харилцан хамааралд суурилсан *globalization* эргэлт буцалтгүй болж байгаа тухай ихээхэн ярьж бичиж байсан, харин эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд бүх салбарт *digitization* эргэлт буцалтгүй болж буй тухай, түүний хүн төрлөхтөнд үзүүлж буй нөлөөллийн тухай ярьж бичиж байна. Дижиталчлал эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, орон зай-цаг хугацааны тухай бидний *stereotype*-ийг орвонгоор нь өөрчлөв.

БНСУ-д дижитал үйл явц нийгэм-эдийн засгийн бүх салбарыг хамарч, эргэлт буцалтгүй үйл явц болов. Өнөөгийн Өмнөд Солонгос нь шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай орон юм. БНСУ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь буюу дээд бүтэц (infrastructure), нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацчлалаар дэлхийд хамгийн өндөрт орж байгааг дахин онцолж байна.

БНСУ дижитал худалдааны сүлжээгээ өргөжүүлэхийн тулд Дижитал эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт нэгдэхийг зөвшөөрчээ. БНСУ тийнхүү үүсгэн байгуулагч орнууд болох Чили, Шинэ Зеланд, Сингапуртай нэгдэн 4 гишүүнтэй эвсэл байгуулав.⁹⁵ ЭЗХАХБ буюу OECD-нау Сайд нарын зөвлөлийн хурлын үеэр Парист анхны гишүүдтэй БНСУ хэлэлцээ хийжээ. Энэ нь дижитал худалдааны асуудалд шинэ хандлага, хамтын ажиллагааг буй болгосон дэлхийн анхны үндэстэн дамнасан дижитал гэрээ юм. Хэлэлцээрийн дагуу БНСУ дижитал худалдаанд суурилсан экспортыг

⁹⁴ “ИЦББХ: Монгол Улсад цахим шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүллээ”

<http://parliament.mn/n/ic3yn>

⁹⁵ [#SouthKorea #Digital Economy Partnership Agreement #digital trade network](#). Jun 9, 2023

[#SouthKorea #digital content #Arirang News](#)

нэмэгдүүлж, дижитал контент, үйлчилгээг гадаадад өргөжүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдэв. Засгийн газар гишүүнчлэлээ 2023 оны эцэст дуусгасан юм.

2023 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо Монгол Улс, АНУ, БНСУ-ын гурван талт хамтын ажиллагааны шинэ форматаг үндэс суурь тавигдав. Анх удаа зохион байгуулагдсан уулзалтад ГХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын захирал Г.Бямбасүрэн, БНСУ-ын талыг тус улсын Гадаад хэргийн яамны Зүүн хойд Азийн газрын захирал Чой Ён-жун, АНУ-ын талыг Төрийн департаментын Туслах Төрийн нарийн бичгийн даргын орлогч Марк Ламберт нар тэргүүлэн оролцсон байна. Анхдугаар уулзалтаар талууд бүс нутаг болон олон улсын аюулгүй байдлын харилцан сонирхсон өргөн хүрээний асуудлаар санал солилцож, тээвэр ложистикийн сүлжээ, эрчим хүч, эрдэс баялаг, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон байна. Талууд гурван талт уулзалтын механизмыг цаашид тогтмол зохион байгуулахаар тохиролцож, Хамтарсан хэвлэлийн Мэдээ гаргав.⁹⁶ Хэвлэлийн мэдээнд “...Эрчим хүчний аюулгүй байдал, ашигт малтмалын нөөц, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, тээвэр, нийлүүлэлтийн сүлжээ, хүнсний аюулгүй байдал, оюуны өмчийн эрх, түүнчлэн худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх хүсэлтэй байгаагаа талууд онцлон тэмдэглэв. Гурван тал энэ зорилгоор янз бүрийн түвшинд, тэр дундаа дэлхийн эрдэс баялгийн нийлүүлэлтийн сүлжээнд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг зэрэг асуудлаар өндөр түвшний яриа хэлэлцээг үргэлжлүүлэхээр шийдэв.

Монгол Улсын Засгийн газар цэвэр эрчим хүчний шилжилтийн дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, АНУ, БНСУ-ын Засгийн газрыг 2023 онд Улаанбаатар хотноо удахгүй болох эрдэс баялаг болон холбогдох асуудлаар тусад нь гурван талт уулзалт зохион байгуулахыг урьсан нь амжилттай болов.⁹⁷

Дээрх Хамтарсан мэдэгдлийн дагуу АНУ, Монгол, БНСУ гурван талын чухал ач холбогдолтой ашигт малтмалын асуудлаарх анхны яриа хэлэлцээ 2023 оны 6 дугаар сард Улаанбаатарт болов. УУХҮ-ийн сайд Ж.Ганбаатар гурван талт яриа хэлэлцээн оролцож буй АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Хосе В.Фернандес, БНСУ-ын Гадаад харилцааны хоёрдугаар дэд сайд Ий До-хун нарыг хүлээн авч уулзах үеэр Монгол Улсын хэмжээнд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, хязгаарласан талбай нийт нутаг дэвсгэрийн 75 хувийг эзэлж байна, цаашид Монгол Улс өөрийн ашигт малтмалын хэтийн төлөвийг судалж, дэлхийн хэмжээнд нийлүүлэлт дутмаг ашигт малтмалыг олборлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зорьж байгаа тухай мэдээлсэн юм. Уулзалтаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт татах, ашигт малтмалын салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгын хүрээнд чухал ашигт малтмалыг онцлон хэлэлцэв. Чухал ашигт малтмалыг олборлох чиглэлээр АНУ, БНСУ-тай хамтран ажиллаж байна. Мөн “Монгол Улс дэлхийн чухал ашигт малтмалын нөхцөл байдал” сэдвээр илтгэл тавьж Монгол Улсын талаас эрчим хүчний чиглэлээр Засгийн газар хоорондын байнгын хамтын ажиллагааны салбар комисс байгуулах, газрын тос, байгалийн хийн хайгуулын чиглэлээр хамтран ажиллах талаар ярилцаж, салбарын мэргэжлийн боловсон хүчнийг богино хугацаанд чадавхжуулах зорилгоор холбогдох мэргэжилтэнг Монгол Улсад ажиллуулах хүсэлтэй байгааг уламжилсан юм.⁹⁸

⁹⁶ Монгол Улс, БНСУ, АНУ-ын гурван талт анхдугаар уулзалт болов. 2023.05.31 <https://mfa.gov.mn/73961>

⁹⁷ Joint Press Release on the Launch of the Mongolia-Republic of Korea-United States Trilateral Meeting. May 30, 2023 MFA, Ulaanbaatar, Mongolia <https://mn.usembassy.gov/pr-060523/>

⁹⁸ Inaugural U.S.-Mongolia-ROK Critical Minerals Dialogue Held in Ulaanbaatar. Media Note. June 27, 2023 <https://mn.usembassy.gov/pr-062723-2/>

2023 оны 11 дүгээр сард Монгол Улс, БНСУ ховор металл, бусад чухал ашигт малтмал нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах хамтарсан хороог байгуулав. Хоёр тал БНСУ-аас Монгол Улсад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд ховор металлын салбарт түншлэх хамтарсан төв байгуулах төслийг эхлүүлсэн байна. “Энэхүү төсөл нь Монгол Улсын хувьд ховор металлуудаа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгон хувиргах, Солонгосын талд дотоодын нийлүүлэлтийн сүлжээгээ бэхжүүлэх боломжийг бүрдүүлнэ гэдэгт найдаж байна” гэж Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний бодлогын асуудал эрхэлсэн дэд сайд Ий Хо-хён (Lee Ho-hyeon) Улаанбаатарт болсон ёслолын үеэр мэдэгджээ.⁹⁹ Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны 2 дугаар сард БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Ховор металл нийлүүлэх сүлжээнд Хамтран ажиллах тухай Харилцан Ойлголцлын Санамж бичгийг хоёр тал байгуулсан ба хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад ховор металлын судалгааны төвийг байгуулсан нь хоёр улсын стратегийн түншлэлийн чухал хэсэг гэж үзэж байна.¹⁰⁰

Солонгос иргэд Монголд, монгол иргэд БНСУ-д өөр өөрийн орны төлбөрийн апп ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой болов. Олон улсын финтек “Send.MN ББСБ” ХХК, төлбөр тооцооны QRau үйлчилгээ эрхлэгч “ККТТ” ХХК болон БНСУ-ын “GLN” гэсэн гурван компани хамтран солонгос иргэд Монголд, монгол иргэд БНСУ-д өөр өөрийн орны төлбөрийн аппликэйшнээр төлбөр тооцоо хийх үйлчилгээг нээж, өнөөдөр гурван талт хамтын ажиллагааг баталгаажуулж гарын үсэг зурлаа. Монгол улсад жилд дунджаар 100 гаруй мянган солонгос иргэд аялал жуулчлалын зорилгоор ирж, нэг тэрбум гаруй долларын орлого оруулдаг. Сурч хөдөлмөрлөх, эмчлүүлэх болон аялал жуулчлалын зорилгоор жилд 120 мянган монголчууд БНСУ руу аялж байгаа юм.¹⁰¹

Монгол Улсад дижитал технологийн хатуу болон зөөлөн дээд бүтэц, ложистикийг улам сайжруулах, 5G технологид шилжих үйл явц хэдийн эхлэв. Монгол Улсын Засгийн газрын e-mongolia portal үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлд үлэмж амжилт гаргалаа. Үүнд: Лавлагаа, тодорхойлолт, Бичиг баримт захиалга, Нийтлэг хэрэглээ, Газар, Үл хөдлөх эд хөрөнгө, Эрүүл мэнд, Зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт акт, Бүртгэл, шилжилт хөдөлгөөн, Аюулгүй байдал, батлан хамгаалах, Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, Нийслэл, аймаг, Яам тамгын газар гэсэн иж бүрэн чиглэлийг хамарч байгаа нь дэлхийд дээгүүр үзүүлэлт болов.

Монгол Улсад дижитал технологи үлчилгээний салбараас үйлдвэрлэлийн (industry) салбар руу шилжиж байна. Энэ нь 4G-гээс 5G, 6G рүү шилжинэ. Жишээн нь уул уурхай, тээвэр, ложистик, жолоочгүй машин, ухаалаг хот зэрэгт шилжинэ. Тэгэхлээр суурь бүтэц буюу дээд бүтцийг бүрдүүлэх явдал маш чухал болж байна.

Эцэст нь, Төр засаг хувийн хэвшлийн энтрепренёр чадавхийг үнэлэх, инноваци, дижитал технологийн хөгжлийг тууштай дэмжих явдал чухал билээ. Тиймээс энэ чиглэлд Монгол Улс, БНСУ-ын стратегийн түншлэлийн салбар дахь дижитал салбарын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх явдал болно.

⁹⁹ Korea, Mongolia launch cooperation committee for rare metals supply. 2023-11-20

https://www.koreatimes.co.kr/www/nation/2023/11/113_363533.html

¹⁰⁰ “South Korea-Mongolia launch rare metals cooperation amid geopolitical risks” November 21, 2023

<https://koreapro.org/2023/11/south-korea-mongolia-launch-rare-metals-cooperation-amid-geopolitical-risks/>

¹⁰¹ Солонгос, Монголд төлбөр тооцоог хэмнэлттэй, хурдан хийх боломж бүрдлээ. 2024-04-01

<https://news.mn/r/2711639/>

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УБ., 2020.05.13
3. Шинэ сэргэлтийн бодлого. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай Монгол Улсын хууль. УБ., 2021.12.17
5. Кибер аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль. УБ., 2021.12.17
6. Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль. УБ., 2021.12.17
7. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай Монгол Улсын хууль. УБ., 2021.12.17
8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай Монгол Улсын хууль. УБ., 2021.12.17
9. Д.Уламбаяр. «Дижитал эдийн засгийн парадигм: хөгжлийн шинэ чиг хандлага»- “*Pax Mongolica*” Vol.1 2016 №1 pp. 43-56
10. Д.Уламбаяр. “Азийн эдийн засгийн хөгжлийн загварын татах хүч”- Олон улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс: Судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2021, 502-519 дэх тал
11. Д.Уламбаяр. “Санхүүгийн салбарын дижитал шилжилт”- Дижитал эдийн засаг. ШУА, ОУСХ, УБ., 2023, 166-192 дахь тал
12. Д.Уламбаяр. “Цахим худалдааны салбарын хөгжлийн чиг хандлага”- Дижитал эдийн засаг. ШУА, ОУСХ, УБ., 2023, 193-223 дахь тал
13. Д.Уламбаяр. “Монгол Улсын дижитал шилжилтийн чиг хандлага”-Дижитал эдийн засаг. ШУА, ОУСХ, УБ., 2023, 224-252 дахь тал
14. Цахим алт 2.0: Биткойн, криптовалюта, блокчейн ба Монгол. Шинэчилсэн хэвлэл. УБ., 2021
15. T.W.Kang. Is Korea the next Japan?: Understanding the Structure, Strategy, and Tactics of America’s Next Competitor. Free Press. The University of California. N.Y.: 1989
16. *e-World: Towards Digitization*. Ang Byong-yub speech. “The Korea Times” 2017.11.09
17. White Paper. StorePay Coin. SPC. Блокчейнд суурилсан финтекийн шийдэл. УБ., 2021
18. Монголбанк. <https://www.mongolbank.mn/documents/>
19. The Global Competitiveness Report 2019. Klaus Schwab. World Economic Forum http://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf
20. WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Countries. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>
21. China’s Next Generation Artificial Intelligence Development Issued Plan by State Council. China’s Strengths Creates Innovation Miracle. <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/full-translation-chinas-new-generation-artificial-intelligence-development-plan-2017/>
22. Russian “National Strategy for the Development of Artificial Intelligence for the period until 2030”. Moscow 11 October, 2019 <https://tass.com/economy/1082644>
23. The Future of Jobs Report 2020 October 2020 http://www3.weforum.org/docs/WEF_Future_of_Jobs_2020.pdf
24. Annex B: APEC Framework on Human Resources Development in the Digital Era. https://www.apec.org/Meeting-Papers/Leaders-Declarations/2017/2017_aelm/Annex-B
25. WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Countries. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>

Changes of Korea's policy for foreign workers in manufacturing sector

БНСУ-ын аж үйлдвэрийн салбар дахь гадаадын ажиллах хүчний бодлогын өөрчлөлт

G.Munkhnasan(Ph.D)
(Hankuk University of Foreign Studies)
munnsa@hanmail.net

ABSTRACT

The purpose of this paper is to study policies and changes regarding foreign workers in Korea's manufacturing sector. As Korea's total population declines, labor demand is expected to increase in the future, especially in the manufacturing sector. Accordingly, several changes will appear in policies related to foreign workers, and foreign employment policies are also expected to improve. First, the main goals of the Korean government's foreign manpower policy can be summarized as reducing the number of illegal immigrants and reducing non-professional manpower. In addition, in order to meet labor market demands in the industrial and agricultural sectors, a system has been established to employ foreigners with a high level of Korean language skills, the ability to adapt to Korean culture and social life, and professional skills in Korea for a long period of time and to enable them to acquire Korean nationality in the future. Korean support short- and long-term flexible policies to supply manufacturing manpower, and support is provided to overseas Koreans, foreign students, marriage immigrants, and foreign workers with specific manufacturing skills.

1.Өмнөх үг

БНСУ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD: Organisation for Economic Co-operation and Development)-ын орнуудын дунд төрөлт хамгийн бага байгаа хүн амын бүтэц нь “хөгширч” буй улс юм. БНСУ-ын хүн амын төрөлт маш бага байгаагаас шалтгаалан дэлхийд эхний 10-т багтдаг үйлдвэрлэгч-экспортлогч орны аж үйлдвэрийн салбарын ирээдүйн ажиллах хүчний хомсдлын бэрхшээл нь улам бүр тулгамдсан асуудал болон гарч ирээд байна. Тиймээс сүүлийн жилүүдэд гадаадын ажиллах хүчнийг ажиллуулах тухай БНСУ-ын Засгийн газрын бодлогод богино хугацаанд ихээхэн өөрчлөлт орж байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь БНСУ-ын үйлдвэрлэлийн салбар дахь гадаадаас ажиллах хүч авах талаарх бодлого, түүний өөрчлөлтийг судлахад оршиж байна.

Өмнөх судалгааны тухайд БНСУ-ын хувьд гадаадаас ажиллах хүч авахтай холбоотой судалгаа маш олон байдаг. Сүүлийн жилүүдэд гадаадын ажиллах хүчний бодлогыг илүү боловсронгуй болгож, гадаадын иргэдийг зөвхөн мэргэжлийн бус салбарт ажиллуулах зорилгоор оруулж ирэх бус өндөр боловсролтой цагаач иргэд, гадаадын оюутнуудыг цаашид БНСУ-д оршин суух, амьдрах нөхцөлөөр хангах, өөрийн улсын иргэн болгоход ихээхэн анхаарч байна. Тухайлбал

Чуи Бён Гю, И Жунь Ён¹⁰² (최병규, 이준영) нар судалгаандаа (2023) Гадаадын ажиллах хүчний талаарх бодлогыг өндөр хөгжилтэй орны статустай нийцсэн загварт шилжүүлэх, цагаач ажилчдыг урт хугацаанд оршин суух загварыг санал болгожээ. И Гю Юун (이규웅) ба бусад¹⁰³ судлаачдын (2020) судалгаандаа гадаад ажилчдыг татахад нээлттэй байдал чухал бөгөөд ажлын визийг цагаачлалын байнгын визтэй холбоотой болгохыг санал болгосон байна.

Монгол улсад энэ талаарх судалгаа ховор байгаа бөгөөд Л.Долгормаа (2009)¹⁰⁴ БНСУ-ын гадаадын цагаач иргэдийн бодлогын талаар судалж монгол улсын хөдөлмөрийн бодлоготой уялдуулах тухай өгүүлэл бичиж байжээ. Харин А.Солонго (2011)¹⁰⁵, Ц.Болормаа (2019), Б.Мөнхжаргал (2022) нар судалгаандаа БНСУ-д ажил эрхлэхээр шилжиж буй монгол ажиллагсадын нөхцөл байдлыг судалж БНСУ-ын бодлогыг холбон тайлбарласан байна.

Энэхүү өгүүлэлдээ баримт бичгийн судалгааны арга болон тоон мэдээллийг боловсруулах аргыг ашиглаж чанарын болон тоон судалгааг хийсэн юм. БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах бодлоготой холбоотойгоор БНСУ-ын Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэр хүний нөөцийн газар, Хууль эрх зүйн яамны мэдээлэл, баримт бичгүүд, мэргэжлийн судлаачдын хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, БНСУ дахь гадаадын ажиллах хүчинтэй холбоотой статистикуудыг ашигласан.

Энэхүү өгүүлэл нь 5 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд өмнөх үгийн дараах хоёрдугаар хэсэгт БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах бодлого, тогтолцоог судлан үзлээ. Гуравдугаар хэсэгт гадаадаас ажиллах хүч авах бодлогод сүүлийн жилүүдэд гарч байгаа өөрчлөлтүүдийг судлан үзэж, дөрөвдүгээр хэсэгт БНСУ дахь монгол ажиллах хүчний талаар судаллаа. Сүүлийн тавдугаар бүлэгт дүгнэлтээ тусгасан болно.

2. БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах бодлого, тогтолцоо

БНСУ нь 1980-аад оноос эхлэн дотоодын үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний хомсдолын асуудлаа шийдвэрлэхийн тулд гадаад ажилчдыг хүлээн авч эхэлсэн бөгөөд 1991 онд үйлдвэрлэлийн дадлагажигчийн тогтолцоог бий болгож, гадаад ажилчдын шилжилт хөдөлгөөн эрчимтэй болсон. Үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүчин хомсдох болсон шалтгаан нь үйлдвэрлэлийн салбар дахь ажлын нөхцөл нь 3Д (3D:Difficult, Dirty, Dangerous) буюу хүнд, бохир, аюултай орчин байдаг учраас солонгосчууд өөрсдөө үйлдвэрт ажиллахаас зайлсхийдэг болсон юм. Мөн БНСУ-д нэг хүнд ногдох ДНБ нь 2024 онд 34,653 ам доллар байгаа бөгөөд дэлхийн нийт улс орнуудаас 32-р жагсаж байна. Амьжиргааны түвшин нь сайжирч, өрхийн орлого нэмэгдсэн нь солонгосын иргэд ялангуяа залуучууд үйлдвэрлэлийн салбарт мэргэжлийн бус хүнд ажил хийх сонирхолгүй болоход бас нөлөөлж байна.

Мөн сүүлийн жилүүдэд БНСУ-д төрөлт эрс багасч, хүн ам нь “хөгширч” ажиллах хүчний дутагдал ороод байна. БНСУ нь сүүлийн 16 жилийн хугацаанд төрөлтийг бууруулах арга хэмжээнд

¹⁰² 최병규, 이준영. 2023. 한국의 외국인 고용제도 문제와 개선방안. 『한국이민정책학보』 제 6 권 제 1 호(2023.6): 153-173

¹⁰³ 이규웅, 최홍엽, 주수인. 2020. 외국인력 정책 과제-개방과 규제. 한국 노동연구원.

¹⁰⁴ Л.Долгормаа. 2009. БНСУ-ын гадаадаас авах ажиллах хүчний талаарх бодлого ба түүний чиг хандлага. Олон улсын харилцаа сэтгүүл. 2009/No2

¹⁰⁵ А.Солонго. 2011. Гадаадад ажил эрхлэхийн төлөөх шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн тулгамдсан асуудал. Монголын хүн ам зүй сэтгүүл. Дугаар (367) 20.

280 их наяд вон зарцуулсан ч хүн ам нь нэмэгдэхгүй¹⁰⁶ байгаа бөгөөд 2024 оны 3 сарын байдлаар улс даяар 157 бага сургуульд элсэн суралцагч байхгүй байсан байна¹⁰⁷. Ялангуяа хөдөөгийн бүс нутгийн ажлын байрууд нь ажиллах хүчнээр дутагдаж, газар тариалан, загас агнуур, үйлдвэрүүд зогсох аюул нүүрлэж байна.

Одоогийн байдлаар БНСУ-д гадаадын ажиллах хүч авч ажиллуулдаг 5 төрлийн бодлого хэрэгжиж байна.

1) Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо (Ерөнхий)

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо нь “Гадаадын ажилчин ажиллуулах тухай хууль”-ийн дагуу дотоодын ажиллах хүчнээр хангагдаж чадахгүй байгаа жижиг, дунд үйлдвэрүүд мэргэжлийн бус ажилд гадаадын ажилчдыг хууль ёсны дагуу ажиллуулах боломжийг олгодог тогтолцоо юм. Энэхүү тогтолцоог 2003 онд “Гадаадын ажилчин ажиллуулах тухай хууль”-ийн дагуу баталж, 2004 оны 8 дугаар сараас мөрдөж эхэлсэн бөгөөд одоо ч мөрдөгдөж байна. Энэ тогтолцооны дагуу мэргэжлийн бус ажил эрхлэлт (Е-9), эсвэл ажил эрхлэхээр зорчих (Н-2) визээр гадаадын иргэдийг ажиллуулдаг.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн удирдлага, хамгаалалттай холбоотой гол асуудлыг шийдвэрлэхийн тулд Ерөнхий сайдын дэргэд “Гадаадын ажиллах хүчний бодлогын хороо” байгуулан ажилладаг. Энэ хороо нь жил бүр үйлдвэрлэлийн салбар тус бүрийн хүний нөөцийн хангамжийн байдалтай уялдуулан, ажиллуулах үйлдвэрлэлийн төрөл, хүний тоог нийтэд нь буюу улирал тус бүр, үйлдвэрийн төрөл тус бүрээр квот тогтоож, холбогдох асуудлыг хянан шийдвэрлэдэг. Одоогийн байдлаар нийт 16 улсаас ажиллах хүч авч байна¹⁰⁸. Үйлдвэрийн салбараас гадна зарим онцлог салбарыг дурдвал Барилгын салбарт Тайланд, Вьетнам, Камбож, Мьянмар, Шри-Ланка, Хятад улс, Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт Балба, Вьетнам, Тайланд, Камбож, Мьянмар, Хятад улс, Загас агнуурын салбарт Индонез, Вьетнам, Зүүн Тимор, Шри Ланка, Хятад улс, үйлчилгээний салбарт Монгол, Узбекистан, Хятад улсыг оруулахаар тогтсон байна¹⁰⁹.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу мэргэжлийн бус ажил эрхлэхээр (Е-9) орж ирсэн гадаадын ажиллагсдыг харвал 2014-2019 онд тогтмол хэмжээгээр орж ирж байсан байна. 2020 онд ковид-19-өөс шалтгаалан гадаадын ажиллагсдын тоо орж ирэх тоо буурсан боловч 2021 оноос эхлэн эрчтэй нэмэгдэж байна. Тухайлбал 2022 онд өмнөх оноос 8 дахин нэмэгдсэн бол, 2023 онд 100 мянга гаран гадаадын иргэд орж иржээ. Энэ нь сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүчин маш их дутагдалтай, гадаадын ажиллах хүчний хэрэгцээ нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Е-9 визээр орж ирсэн гадаадын иргэд тоо, салбараар

¹⁰⁶ 최병규, 이준영. 2023. 한국의 외국인 고용제도 문제와 개선방안. 『한국이민정책학보』 제 6 권 제 1 호(2023.6)

¹⁰⁷ 초등학교 157곳, 1학년 입학생 없다·저출생 쇼크' 점점 현실로. 2024.02.26. 서울경제.

<https://www.sedaily.com/NewsView/2D51E3FF7C>

¹⁰⁸ 2004 онд Индонез, Вьетнам, Тайланд, Филиппин, Шри Ланка, Монгол гэсэн 6 улс байсан бөгөөд 2006 онд Узбекистан, Пакистан, Хятад, Камбож, 2007 онд Бангладеш, Балба, Мьянмар, Киргизстан, Зүүн Тимор, 2015 онд Лаос нэмэгдэн нийт 16 улс байдаг.

¹⁰⁹ 조영희 외. 2022. 인구구조 변화에 대응한 새로운 외국인력 유입체계 연구. 법무부 출입국·외국인정책본부, 이민정책연구원.

Салбар	НИЙТ	Үйлдвэр	Барилгын үйлдвэрлэл	ХАА үйлдвэрлэл	Үйлчилгээний салбар	Загасны үйлдвэрлэл
2014	51,556	40,874	2,299	6,047	91	2,245
2015	51,019	40,223	2,228	5,949	71	2,548
2016	59,822	47,425	2,593	7,018	68	2,718
2017	50,837	39,415	1,846	6,855	100	2,621
2018	53,855	43,695	1,405	5,820	90	2,845
2019	51,365	40,208	1,651	5,887	99	3,520
2020	6,688	4,806	207	1,388	1	286
2021	10,501	7,455	595	1,841	18	592
2022	88,012	68,350	1,657	11,664	125	6,216
2023	100,148	79,108	2,323	11,979	265	6,473

Эх сурвалж: БНСУ-ын статистикийн порталыг ашиглан зохиогч боловсруулав.
https://kosis.kr/statHtml/statHtml.do?orgId=118&tblId=DT_11827_N001

2023 оны эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбар дахь гадаадын ажиллах хүчнийг салбараар нь харвал хамгийн их нь үйлдвэрт 79% байна. Үүний дараа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт 12%, загасны үйлдвэрлэлийн салбарт 6.5%, барилгын үйлдвэрлэлийн салбарт 2.3% нь ажил эрхэлж байна.

2) Хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоо

2002 онд нэвтрүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн энэ тогтолцоо нь Хятад болон хуучин ЗХУ-д хамаарч байсан улсууд болон бусад гадаад улсад амьдардаг гадаад иргэншилтэй солонгос үндэстнүүдэд 3 жил хууль ёсны дагуу ажиллах боломжийг олгодог тогтолцоо юм. Энэ тогтолцоо нь зөвхөн гадаад улсын иргэншилтэй солонгос үндэстнүүдэд хамаарах бөгөөд бусад гадаадын иргэдэд үйлчилдэггүй. Хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоо нь гадаадын ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгодог ерөнхий тогтолцоотой харьцуулахад хүсэлт гаргах, хилээр нэвтрүүлэх, цагаачлах, ажилд авах зэрэг үйл явцыг нь ихээхэн хөнгөвчилдөг онцлогтой. Гадаадын иргэншилтэй солонгос үндэстнүүд нь ихэвчлэн үндсэн хэл солонгос хэл байдаг бөгөөд ёс заншил, соёлын хувьд адилхан байдаг учраас ажиллах хүчнээр авахад ихээхэн давуу талтай байдаг байна.

2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар БНСУ-д амьдарч байгаа гадаадын иргэншилтэй солонгосчуудын тоо 848,724 болж, нийт гадаадын оршин суугчдын 33,8%-ийг (нийт гадаадын иргэд) эзэлж байна. Хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гадаад иргэншилтэй солонгосчуудыг улсын харьяалаар нь харвал хятад иргэншилтэй 77.3% (6561420), америк иргэншилтэй 5.8% (48837), Узбекистан иргэншилтэй 5.1% (43320)-ийг эзэлж байна¹¹⁰. Гадаад иргэншил солонгосчууд 4 хэлбэрээр оршин суудаг бөгөөд гадаад иргэншилтэй солонгос иргэн (F-4), ажил эрхлэхээр зорчих (H-2), байнгын оршин суух (F-5), дагалдан (F-1) гэсэн виз авдаг.

3) Улирлын чанартай ажил хийх тогтолцоо

¹¹⁰ 2023.1231 기준 법무부 출입국외국인정책통계월보 <https://www.ekwo.com/news/articleView.html?idxno=11501>

Улирлын чанартай ажил хийх тогтолцоо нь нэг жилээс дээш хугацаагаар тогтмол хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй байдаг хөдөө аж ахуй, загасны аж ахуйн салбарын улирлын шинж чанарыг харгалзан 2015 оноос эхлэн нэвтрүүлсэн тогтолцоо юм. Энэхүү тогтолцоо нь 2 хэлбэртэй байдаг бөгөөд 3 сарын богино хугацааны хөдөлмөр эрхлэх (С-4 виз) болон 5 сарын урт хугацааны хөдөлмөр эрхлэх (Е-8 виз) зөвшөөрөл олгодог. 2019 оноос эхлэн БНСУ-д оршин сууж байгаа тодорхой шаардлага хангасан¹¹¹, улирлын чанартай ажилд оролцох хүсэлтэй гадаадын иргэдийг энэ тогтолцоонд бас хамруулж байна.

Энэ тогтолцооны үр дүнг харвал 2015-2021 онд нийт улирлын чанартай ажилчдын тоо 8391 байсан нь хөдөө орон нутгийн ажиллах хүчний хомсдолыг шийдвэрлэхэд огт хангалтгүй байсан байна¹¹². Өөрөөр хэлбэл улирлын чанартай ажил хийх тогтолцоо нь ажиллах хүчний эрэлтийг цаг тухайд нь хангах асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм. Тиймээс Хууль зүйн яамнаас 2021 оны нэгдүгээр сараас эхлэн зарим нэг хөнгөвчлөх арга хэмжээг авч нэг фермд 12 хүртэл хүнийг үргэлжлүүлэн ажиллуулах, заавал нэг сараас дээш хугацаагаар биш долоо хоногоос дээш ажиллуулж болох зэргээр өөрчилсөн юм.

Одоогийн байдлаар улирлын чанартай ажилчдыг зөвшөөрч байгаа газар тариалангийн үйлдвэрлэлийн салбар нь ① байгууламжийн цэцэрлэгжүүлэлт ба тусгай тариалалт ② мөөг ③ жимсний мод ④ хүн орхоодой ба ерөнхий хүнсний ногоо ⑤ суулгац тариалалт ⑥ бусад цэцэрлэгжүүлэлт ⑦ бусад хүнсний үр тариа ⑧ тариалангийн талбай зэрэг юм. Загасны үйлдвэрлэлийн хувьд ① далайн ургамал боловсруулах, үйлдвэрлэх, тариалах ② загас хясаа боловсруулах, үйлдвэрлэх гэсэн салбарууд ордог.

Хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүч илгээх улс орнуудад ямар нэгэн хязгаарлалт байхгүй ч дийлэнх нь Филиппин, Вьетнам зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудаас улирлын чанартай ажил хийх ажилчдыг авч байна. 2022 оны долдугаар сарын эцсийн байдлаар улирлын чанартай 6152 ажилчин ажиллаж байсан бөгөөд сүүлийн хагаст 5452 ажилчин шинээр орж байжээ. Хууль зүйн яамнаас орон нутаг дахь улирлын чанартай ажилд 2022 онд 19,718, 2023 онд 40,647 гадаад ажилчин авч болохыг зөвшөөрсөн¹¹³ байна. Энэ нь БНСУ-ын хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчин ихээхэн хомсдож гадаадын ажиллах хүчний хэрэгцээ огцом өсч байгааг харуулж байна.

4) Загас агнуурын үйлдвэрлэлд гадаадын ажилчин авах тогтолцоо

Загас агнуурын үйлдвэрлэлд гадаадын ажилчин авах тогтолцоо нь 1996 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд нилээд өөрчлөлт, сорилуудтай тулгарч иржээ. Загас агнуурын салбар нь бусад салбартай харьцуулахад амьдрах нөхцөл таагүй, ажлын байрны орчин муу, орлогын түвшин бага байдгаас гадаадын ажилчдын хэрэгцээ өндөртэй салбар юм. Учир нь загас агнуур эрхэлдэг тосгодын хүн ам нь 2013-2020 онд 54.7% буурсан, загас агнуурын ажлын орчин нь 4D буюу (4D: Difficult, Dirty, Dangerous, Distant) хүнд, бохир, аюултай, алс хол гэсэн маш хүнд нөхцөл байдаг. 2021 оны байдлаар далайн эргийн загас агнуурын хөлөг онгоцны нийт ажилчдын 65.9% (8916) нь гадаадын ажилчид байжээ¹¹⁴.

¹¹¹ Тодорхой нөхцлийг хангасан F-1, C-3-1, H-2, D-2, D-4, D-1, D-10, G-1 визтэй гадаад улсын иргэдэд хамаарна.

¹¹² 조영희 외. 2022. 인구구조 변화에 대응한 새로운 외국인력 유입체계 연구. 법무부 출입국·외국인정책본부, 이민정책연구원.

¹¹³ 법무부. 보도자료. 2023.12.28. 계절근로자이탈률전년대비16로감소

¹¹⁴ 조영희 외. 2022. 인구구조 변화에 대응한 새로운 외국인력 유입체계 연구. 법무부 출입국·외국인정책본부, 이민정책연구원.

2022 оны эцсийн байдлаар БНСУ-ын загас агнуурын үйлдвэрлэлд ажиллаж буй нийт далайчдын тоо 60,148, үүнээс гадаадын иргэн 28281 хүн буюу 47%-ийг эзэлж байна. Гадаадын ажиллагсдын тоо өмнөх оноос 850 хүнээр нэмэгдсэн байна.

Загас агнуурын үйлдвэрлэлд ажиллах (E-8 виз) нь 5 сарын хугацаатай байсан бөгөөд 2023 оноос улирлын чанартай хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн 5 сарын хугацааг 8 сар болгон сунгасан байна¹¹⁵. Улирлын чанартай ажил хийж буй гадаадын ажилчдын оргон зайлж, хууль бусаар амьдрах байдал 2023 оны 11 сарын байдлаар 1,6% болон 6 дахин буурсан нь олон соёлт гэр бүлийн гишүүн эмэгтэйчүүдийн гэр бүлийн гишүүдийг гадаадаас урьж ажиллуулсантай холбоотой гэж үзэж байна.

5) Мэргэшсэн ажиллах хүчнийг авах тогтолцоо

БНСУ-ийн засгийн газар нь үндэсний өрсөлдөх чадвараа бэхжүүлэхийн тулд тусгай болон нарийн мэргэжлийн мэдлэг, технологи эзэмшсэн ур чадвар бүхий гадаадын ажиллах хүчийг шаардлагатай гэж үзсэн салбарууддаа оруулан ирж, эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг нь зөвшөөрч байна. Үүний тулд тусгай үйл ажиллагаа эрхлэх E-7 төрлийн визийг мэргэжлийн боловсон хүчин, хагас мэргэжлийн боловсон хүчин, ерөнхий ур чадвартай ажиллах хүч, чадварлаг ажиллах хүч гэж ангилж олгож байна.

Тухайлбал, 2017 оноос эхлэн үндсэн үйлдвэрүүд, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуйн мэргэшсэн ажилчдын чадавхыг оноогоор тооцох ажиллах зөвшөөрөл олгож байна. Ялангуяа ажиллах хүчний хомсдолд орсон цутгамал, хэв, гагнуур зэрэг мэргэжлүүд үндсэн том үйлдвэрүүд болон жижиг дунд үйлдвэрүүдийг чадварлаг боловсон хүчнийг хангах зорилготой юм. Энэ тогтолцоонд ХАА, хүнд, хөнгөн үйлдвэрлэл, барилгын салбар хамрах бөгөөд жилд дунджаар 2000 хүний квоттой байдаг.

Мэргэшсэн ажиллах хүчнийг авах энэ тогтолцоо (E-7-4) нь БНСУ-д 5-аас дээш жил ажилласан мэргэжлийн бус ажил (E-9), ажил эрхлэхээр зорчих (H-2), загас агнуурын аж ахуйд ажиллах (E-10) статустай иргэдийг хамруулж жилийн орлого, ур чадварын түвшин, боловсролын түвшин, нас, солонгос хэлний мэдлэг, ажилласан хугацаа гэх мэтийг тооцоолон оноо өгөх замаар дүгнэдэг тогтолцоо юм. Анхны оршин суух хугацаа нь 3 жил бөгөөд шаардлага хангасан тохиолдолд оршин суух хугацааг сунгах боломжтой тул байнгын оршин суух боломжтой гэж үзэж болно.

3. Гадаадаас ажиллах хүч авах бодлогод гарч буй өөрчлөлтүүд

Цагаачлалын болон гадаад иргэдийн статистикаас харвал 2023 оны 12 сарын эцсийн байдлаар БНСУ-д оршин сууж буй гадаадын иргэдийн тоо 2,5 саяыг давсан бөгөөд сүүлийн 10 орчим жилийн хугацаанд гадаадын оршин суугчдын тоо 112 хувиар өссөн байна. Гадаадын оршин суугчдын тоо нэмэгдэхийн хэрээр ур чадвар муутай цагаачдын тоо нэмэгдсээр байна гэж Засгийн газар нь үзэж байна. БНСУ-ын нийгэмд ур чадвар муутай цагаач ажилчдын тоо хурдацтай нэмэгдсэнээр цагаач ажилчидтай холбоотой нийгмийн асуудал зөвхөн цөөнхийн асуудлаар зогсохгүй нийгмийн ноцтой асуудал болон гарч ирж байна.

БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах шаардлага жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд цагаач иргэдийг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг өргөтгөх бодлогод өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүдийг харвал гадаад оюутнууд, гадаад иргэншилтэй солонгос үндэстнүүдэд тулгуурласан бодлогод ихээхэн анхаарал тавьж байна. Энэ нь гадаад иргэдийн солонгос хэл, соёлын

¹¹⁵ 법무부. 보도자료. 2023.12.28. 계절근로자이탈률전년대비16로감소

мэдлэг дээр тулгуурлан солонгосын нийгэмд дасан зохицох боломжтой, мэргэжлийн мэдлэг ур чадвартай ажиллагсдыг татан авахад чиглэж байна гэж дүгнэж болно.

Бүс нутгийг тэнцвэртэй байлгах Two Track цагаачлалын бодлого. Энэ бодлогыг БНСУ-ын Хууль зүйн яам, Орон нутгийн засаг захиргаанаас хамтран хэрэгжүүлж байна. Энэ бодлого нь төрөлт буурч өндөр наслалт нэмэгдэх, хотод төвлөрөх зэргээс шалтгаалж хөдөө орон нутгийн хүн ам багасч хөгжил нь саарч байгаагийн эсрэг авч байгаа арга хэмжээ юм. Энэ бодлого нь хоёр хэлбэрээр хэрэгжиж байгаа бөгөөд нэгдүгээрт орон нутагт шаардлагатай байгаа шилдэг боловсон хүчнийг суурьшуулах бодлого, хоёрдугаарт гадаадын иргэншилтэй солонгос үндэстнүүдийг гэр бүлийнх нь хамт хөдөө орон нутагт суурьшуулах бодлого юм¹¹⁶. Бодлогын хэрэгжилт нь орон нутгийн засаг захиргаанаас санал болгосон гадаадын иргэдэд оршин суух эрхээ байнга оршин суух (F-2) эрх болгон өөрчлөх боломжийг олгох бөгөөд гадаадаас суралцаж байгаа оюутнууд, гадаад иргэншилтэй солонгосчууд хамрагдах боломжтой юм.

Улирлын чанартай ажил хийх тогтолцоонд гарсан өөрчлөлт. БНСУ-ын Засгийн газар 2023 оноос эхлэн хөдөө орон нутгийн ажиллах хүчний хомсдолыг шийдвэрлэхийн тулд гадаадаас ажиллах хүч авах тогтолцоог илүү нээлттэй байдлаар сайжруулахаар төлөвлөөд байна. Загас агнуурын үйлдвэрлэлд зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийг өргөтгөж далайн ургамлын аж ахуйг оруулах, хясаа түүх, цэвэрлэх, боловсруулах, савлах салбаруудад улирлын чанартай ажилчдыг оруулахаар шийдвэрлэсэн. Гэрээгээр оруулсан ажилчдын насны шалгуурыг 30-аас 55 нас байсныг 25-50 нас болгон өөрчилжээ. Улирлын чанартай ажилчдыг зөвшөөрөлгүй оргон явахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байсан буцаан олголтыг барьцаалах, хөрөнгө барьцаалах тогтолцоог халахаар шийдвэрлэсэн. Одоогийн байдлаар нэг аж ахуйн нэгж дээд тал нь 9 хүн авах боломжтой бөгөөд, шилдэг орон нутгийн засаг захиргаа 5 хүртэл хүнийг нэмэлтээр авах боломжтой болжээ. 2023 оноос эхлэн хөдөө аж ахуй, загас агнуурын чиглэлээр ажиллаж байсан туршлагагүй улирлын чанартай ажилчдыг ажилд авахыг зөвшөөрсөн байна. Мөн БНСУ-ын иргэдтэй гэрлэсэн цагаач иргэдийн гэр бүлийнхнийг улирлын чанартай ажилд урихад дэмжлэг үзүүлж байна. Одоогийн байдлаар гэрлэлтийн цагаач иргэний статусаар амьдарч байгаа 142.042 гадаадын иргэн байна¹¹⁷. Энэ нь хууль бус ажилчдыг багасгахад чухал үр нөлөөтэй байх болно гэж харагдаж байна.

Гадаад оюутнууд улирлын чанартай ажилд эцэг, эхээ урих тогтолцоо. Хөдөө орон нутагт байршилтай магадлан итгэмжлэгдсэн их сургуульд сурч буй оюутнуудын эцэг, эхчүүдийг улирлын чанартай ажилд урих туршилт эхлээд байна. 2023 оны эцсийн байдлаар БНСУ-д суралцаж байгаа гадаадын оюутны тоо нийт 152.094 хүн байна¹¹⁸. Сүүлийн жилүүдэд гадаад оюутны тоо нэмэгдэж байгаа бөгөөд 2022 онд 167,000, 2023 онд 182,000 гадаад оюутан шинээр ирсэн нь бөгөөд 2023 онд өмнөх оноос 9,1% өссөн байна.

Энэ бодлогыг туршилтаар хэрэгжүүлэх хугацаа нь 2024.2.26 ~ 12.31 хүртэл бөгөөд C-4 (90 хоног) эсвэл E-8 (5 сар + 3 сар) гэсэн оршин суух эрх өгөх гэж байна¹¹⁹. Энэ бодлогод хамрагдаж эцэг, эхээ улирлын чанартай ажилд урих гадаад оюутан нь D-2 статусаар хөдөө орон нутгийн

¹¹⁶ 한국지방행정연구원. 2023. 지방자치정책.

¹¹⁷ БНСУ-ын хууль зүйн яам, Цагаачлалын бодлогын газар. (국적,지역) 및 체류자격별 장단기체류외국인)

¹¹⁸ БНСУ-ын хууль зүйн яам, Цагаачлалын бодлогын газар. (국적,지역) 및 체류자격별 장단기체류외국인)

¹¹⁹ 법무부. 2024. 봄철 농번기 농 법무부, 봄철 농번기 농·어촌 현장 지원을 위한 외국인 계절근로자 제도 개선 방안 마련

магадлан итгэмжлэгдсэн их сургуульд 1 жилээс дээш хугацаагаар суралцсан, оршин суух хугацаа нь дор хаяж 2 семестр үлдсэн, БНСУ-ын дотоодын хууль тогтоомжийг дагаж ямар нэгэн зөрчил гаргаагүй, эцэг, эх 55 нас хүрээгүй, эрүүл мэнд болон гэмт хэргийн асуудалгүй иргэн байх шаардлагыг тавьж байна.

Гадаадын оюутнуудыг дэмжиж, хойшид БНСУ-ын иргэн болгох бодлого. БНСУ-д хэлний сургалтанд ирсэн оюутнууд нь дараагийн шатны үндсэн сургалт болон бакалавр, магистр, докторын сургалтыг дүүргэсний дараа ажил хайх (D-10) зорилготой 2 жилийн хугацаатай оршин суух зөвшөөрөл олгодог. Энэ хугацаанд ажлын байраа олж гэрээ хийвэл гэр бүл, хүүхдээ авчирч хамт амьдрах, гэр бүлийн хүн нь ажил хийх боломжтой болсон. Ажлын байран дээр тогтвортой ажиллаж, ялангуяа хөдөө орон нутгийн ажиллах хүчин хомсдолтой үйлдвэрүүдэд ажилласан тохиолдолд тодорхой нөхцлийн дагуу байнга оршин суух эрх олгох, улмаар БНСУ-ын иргэншил авах боломжийг нээж өгч байна¹²⁰.

Үйлчилгээний салбарт гадаадын ажилчдыг ажиллуулах бодлого. 2023 оны сүүлээс эхлэн “Хүргэлтийн үйлчилгээний салбар”-т мэргэжлийн бус (E-9), айлчлан ажиллах (H-2) визтэй гэрээт ажилчдыг ажиллуулахаар шийдвэрлэсэн. Хүргэлтийн үйлчилгээ гэдэгт зөвхөн нисэх онгоцны буудлын ачих буулгах үйлчилгээ орж байгаа бөгөөд зөвшөөрөгдсөн ажлын төрөл салбараас өөр ажил эрхлэх тохиолдолд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл цуцлагдана гэжээ.

Мөн мэргэжлийн бус ажиллах хүчний (E-9) шинээр ирэх гэрээт иргэдийг зочид буудал, амралтын газар, барилга байгууламжийн үйлчилгээний салбарт ажиллуулахаар шийдвэрлээд байна. Үүнд БНСУ-ын аялал жуулчлалын салбар, тухайлбал зочид буудал, амралтын газар, барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, туслах ажилтнаар Сөүл, Бүсань, Ганвонь, Жэжү хотуудын аялал жуулчлалын бүс нутагт ажиллуулна. Зөвхөн аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй компанид барилга байгууламжийн цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсын иргэнийг авч ажиллуулна. Энэхүү журам нь 2024 оны 4 дүгээр сараас хэрэгжиж байгаа бөгөөд E-9 визээр ажиллах эмэгтэй ажилчдын квот нэмэгдэх давуу тал бий болж байна.

БНСУ-ын үйлчилгээний салбар тэр дундаа зочид буудал, хоолны газрын үйлчилгээний салбар нь сүүлийн жилүүдэд ихээр хөгжиж байгаа бөгөөд ажиллах нөхцөл нь хүнд, ажлын цаг урт байдаг тул дотоодын ажиллах хүчин ихээхэн дутагдалтай байгаа юм.

Хойшид гэрийн үйлчлэгч, асрамжийн газрын асрагч, хүргэлтийн бусад салбарт гадаадын ажилчдыг ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэдийг цөөлөх бодлого. Хууль бусаар оршин суудаг гадаадын иргэдийн асуудал нь БНСУ-ын ажиллах хүчний зах зээл дээрх зөрчилдөөнтэй асуудал юм. 2023 оны эцсийн байдлаар БНСУ-д 423,667 гадаадын иргэн хууль бусаар оршин сууж байна¹²¹. Хууль бусаар оршин суух асуудал нь хүний эрх зөрчигдөх, гэмт хэрэг үйлдэгдэх, нийгмийн хэв журмыг зөрчих, хууль бус үйл ажиллагааг дэмжих зэргээр нийгмийн сөрөг үйлдлүүд гарахад ихээр нөлөөлж байна. Хууль зүйн сайд Хан Дун Хүн “Манай Засгийн газрын бодлого бол хууль

¹²⁰ 국제행정법률 기관 안내 자료. 2023

¹²¹ БНСУ-ын хууль зүйн яам, Цагаачлалын бодлогын газар. 2023 оны 12 сарын статистик

ёсоор оршин суухыг уян хатан замаар өргөжүүлж, хууль бусаар оршин суухыг хатуу хориглож, цаашид оршин суух дүрэм журмыг баримтлуулахын төлөө бүхнийг хийнэ” гэж хэлжээ¹²².

Сүүлийн жилүүдэд хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэдэд чиглэсэн арга хэмжээ нилээд эрчимтэй явагдаж байна. Тухайлбал, Өршөөлийн хууль буюу Хууль бусаар оршин суугч гадаад иргэдийн сайн дураар нутаг буцах хөтөлбөртэй зэрэгцэн Хууль бус оршин суугч гадаад иргэдийн албадан гаргах арга хэмжээг Хууль зүйн яам болон холбогдох 5 байгууллага¹²³ хамтран хэрэгжүүлж байна. Дотоодын иргэдийг ажиллуулах боломжтой ажлын байранд гадаад иргэдийг ажиллуулж буй компаниуд, хууль бусаар оршин суугч гадаад иргэдийг байнга давтан ажиллуулдаг бизнес эрхлэгчид, зугаа цэнгээний газарт ажилладаг гадаад иргэд, хууль бус иргэдийг ажилд зуучилдаг брокерийн компани, хууль бусаар хилээр нэвтэрсэн болон гэмт хэрэгт холбогдсон зэрэг хууль бусаар оршин суугч гадаадын иргэдэд хатуу арга хэмжээ авч байна. Энэ нь тус улсад хууль ёсны дагуу оршин суух дүрэм журмын зөрчлийн эсрэг хатуу арга хэмжээ авч хууль ёсны, ур чадвартай ажиллах хүчнийг нэмэгдүүлэх, улирлын чанартай ажилд гадаад ажилчдыг зөвшөөрлийн дагуу ажиллуулах зэргээр гадаад ажиллах хүчний хууль ёсоор хөдөлмөрлөх тогтолцоог хэвийн болгох зорилготой юм.

4.БНСУ дахь монгол ажиллах хүч

БНСУ нь гадаадад байгаа монголчуудын тоогоор нэгдүгээрт ордог улс бөгөөд манай хоёр улсын иргэд нь зүс царай төстэй, түүх, соёлоороо холбоотой билээ. Монголчуудын хувьд БНСУ нь очиж сурч, амьдарч, ажиллахыг хүсдэг улсын нэг юм.

2023 оны 12 сарын сүүлийн байдлаар БНСУ-д оршин сууж байгаа Монгол улсын иргэн нийт 54846 хүн байгаа бөгөөд нийт гадаадын иргэдийн 6.4%-ийг эзэлж байна. Үүнээс БНСУ-ын гадаадаас ажиллах хүч авах тогтолцооны дагуу ирж ажиллаж буй нийт 4621 хүн байгаагаас богино хугацаанд ажил эрхэлсэн 30 (С-4), улирлын чанартай ажил эрхэлсэн 359 (Е-8), мэргэжлийн бус ажил буюу гэрээгээр ирж ажилласан 4232 (Е-9) хүн байна (Хүснэгт 2-оос харна уу).

Хүснэгт 2. БНСУ дахь монгол иргэд, 2023 оны эцэс

Хэмжих нэгж: Хүн

	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	54846	25173	29673
В1 (визээс чөлөөлөгдсөн)	258	148	110
В2 (жуулчин)	569	286	283
С1 (түр зорчих сурвалжлагч)	6	4	2
С3 (богино хугацаанд зорчих)	20232	9448	10784
¹²⁷ Ломбо, Ж., Хаш-Эрдэнэ, Л. (2020). Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea). -УБ., ГХЯ. “Мөнхийн үсэг” ХХК. ISBN: 978-9919-23-484-3., 43.66 х.х;

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсоноос хойш улс төр, нийгэм эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, эрүүл мэнд, шинжлэх ухаан, боловсрол, соёл, байгаль, хүрээлэн буй орчин, аялал жуулчлал зэрэг олон салбарт хамтын ажиллагаа эрчимтэй хөгжин, өргөжиж тэлж байна.

Бидний энэхүү илтгэлийн зорилго нь Монгол Улс, БНСУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхийн тулд хоёр улсын гадаад худалдаа, эдийн засгийг төрөлжүүлэх боломж, арга замыг тодорхойлоход оршино.


Дээрх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

Зорилт 1: Монгол Улс, БНСУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх

Зорилт 2: Хоёр улсын гадаад худалдаа, эдийн засгийг төрөлжүүлэх арга замыг тодорхойлох.

I. МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Далайд гарцгүй, хөгжиж буй Монгол Улсын хувьд гадаад худалдаа нь дотоодын үйлдвэрлэл, хэрэглээг зах зээл, үйлдвэрлэгчтэй холбох замаар эдийн засгийг бүхэлд нь хөдөлгөж буй чухал салбар юм. Монгол Улсын гадаад худалдааны бүтэц нь сүүлийн жилүүдэд нэлээд өөрчлөгдөж, өндөр хөгжилтэй орнууд болон Зүүн хойд Азийн орнууд руу чиглэн, 2022 онд нийт 164 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21.2 тэрбум америк доллар, үүнээс экспорт 12.5 тэрбум америк доллар, импорт 8.7 тэрбум америк долларт хүрчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 5.2 (32.1%) тэрбум америк доллароор, үүнээс экспорт 3.3 (35.7%) тэрбум америк доллароор, импорт 1.9 (27.2%) тэрбум америк доллароор тус тус өссөн байна. (ҮСХ, 2023)¹²⁸ 2021 оны байдлаар манай улсын эдийн засгийн цогц байдлын индекс (Economic Complexity Index - ECI) 1.22 байна (Зураг 1). (Harvard, 2024)¹²⁹



Эх сурвалж: Atlas of Economic Complexity

Зураг 1. Монгол Улсын эдийн засгийн динамик загвар, бүтээгдэхүүний орон зайгаар 2011-2021

¹²⁸ ҮСХ. (2023). Гадаад худалдааны салбарын танилцуулга-2022. www.1212.mn;

¹²⁹ Atlas of Economic Complexity (2024). <https://atlas.cid.harvard.edu/countries/121/growth-dynamics>

Монгол Улс, БНСУ газар зүйн байрлалын хувьд нэг бүс нутагт оршдог, улс төрийн системийн хувьд ардчилсан засаглал, зах зээлийн тогтолцооны хувьд чөлөөт зах зээлийн эдийн засагтай, аль аль нь хөрш зэргэлдээ их гүрнүүдийн стратегийн ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалж, жийргэвч улсын үүрэг гүйцэтгэж байх геополитикийн эмзэг орчинд оршдог.

Хоёр улсын хооронд цэрэг улс төр, аюулгүй байдлын бодит аюул занал, түүхийн болон газар нутгийн аливаа маргаан, гажуудал, шашны болон соёлын үл ойлголцол зэрэг уламжлалт болон уламжлалт бус тогтворгүй байдалтай холбоотой асуудал байхгүй. Тиймээс хоёр тал бие биенээ тусгаар тогтнол, эрх ашигт аюул занал учруулах улс гэж үздэггүй. Эдгээр нийтлэг талууд, ижил төстэй байдал нь хоёр улсын хооронд итгэлцлийг бий болгож, хамтран ажиллахад нь эергээр нөлөөлж ирсэн. Үүнээс гадна бас хоёр улсын аюулгүй байдал, гадаад бодлогод нөлөөлөх ижил төстэй, нийтлэг хэд хэдэн хүчин зүйл ажиглагдаж байна. Нэгдүгээрт, аль аль нь их гүрнүүдийн хүрээлэл дунд оршиж байна, хоёрт, тийм болохоор хүрээлэн байгаа их гүрнүүдийн нөлөөлөл, стратегийн шууд болон дам ашиг сонирхлын объект болж байдаг, гуравт, гадаад бодлого нь тэдгээр их гүрнүүдээс хамаарал ихтэй, тэр хамаарал нь нэг орноор зогсохгүй хэд хэдэн орны эрх ашгийн солбилцол болдог, дөрөвт, ийм нөхцөлд үндэсний аюулгүй байдлынхаа таатай гадаад орчинг бүрдүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн гэсэн орон зай, байр сууриа эзэлж, бататгах адилхан зорилт тавигдаж байна. Хүрээлэл дунд байгаа энэ байдал нь нэг талаар эерэг, нөгөө талаар сөрөг үр дагавартай. Аливаа улсуудын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа голлох байр суурийг эзэлдэг. (Үржин & Эрдэнэчимэг, 2023)¹³⁰

Монгол-Солонгос улсын гадаад худалдааны хамтын ажиллагаа нь 1985 оноос эхэлсэн гэж үзэж болох бөгөөд 1991 он хүртэл маш бага хэмжээний бүтээгдэхүүнийг манай улс экспортолж байсан байна.

Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа 1990 оны “Дипломат харилцаа тогтоох тухай Протокол”, 1991, 1999, 2006, 2011 оны дээд түвшний айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, БНСУ-ын Хамтарсан мэдэгдэл”, 1999 оны “XXI зууны харилцан бие биеэ нөхсөн хамтын ажиллагаа”, 2006 оны “Сайн хөршийн, найрамдалт хамтын ажиллагааны түншлэл”, 2011 оны “Иж бүрэн түншлэл”-ийн зарчим, 2021 онд “Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-д тулгуурлан тууштай хөгжиж байна. (ГХЯ, 2024)¹³¹ Ийнхүү олон удаагийн дээд хэмжээний айлчлал, улс төр-дипломатын аргаар манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Улмаар 2016 оны 7 сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоотой байж ирээдүйн төлөө түншлэх нь” сэдвийн доор зохион байгуулагдсан Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын үеэр (АСЕМ, 2016)¹³² хоёр улс “Иж бүрэн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичиг” байгуулж, “Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай гэрээ”-ний дагуу хамтарсан судалгааг эхлүүлсэнээр хоёр улсын эдийн засгийн

¹³⁰ Үржин, О., Эрдэнэчимэг, Б. (2023). Аюулгүй байдал ба “Гуравдагч хөрш”-ийн бодлого. Монгол Улс, БНСУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэгийн төлөв., -УБ., БХЭШХ., “Удам соёл” ХХК., ISBN: 978-9919-9955-7-7., 21.1 х.х., т.251-281;

¹³¹ ГХЯ. (2021). Монгол Улс, БНСУ-ын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал. Монгол Улсын Гадаад харилцааны яамны цахим сайт. 2021.09.10: <https://mfa.gov.mn/63590>;

¹³² Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар (Permanent Mission of Mongolia to the United Nations)-ын цахим хуудас. (2016). <https://www.un.int/mongolia/news/асем-ын-дээд-түвшний-11-дүгээр-уулзалт-асем-ын-20-жил-уялдаа-холбоотой-байж-ирээдүйн-төлөө-2016.07.17>;

салбарт гадаад худалдаа цар хүрээ өссөн зэрэг томоохон амжилтанд хүрсэн гэж дүгнэж болно (Хүснэгт 1). (Ким Хун Жин, 2020)¹³³

Хүснэгт 1. Монгол Улсын БНСУ-тай хийсэн гадаад худалдаа, сая.ам.долл. (ҮСХ, 2024)¹³⁴

Үзүүлэлт	2005	2010	2015	2018	2019	2020	2021	2022
Нийт бараа эргэлт	2,241	6,109	8,467	12,887	13,747	12,858	16,087	21,243
Экспорт	65.09	30.52	30.52	21.20	27.82	21.42	223.30	277.42
Импорт	63.72	181.78	258.70	262.37	266.97	235.77	308.75	424.65
Худалдааны тэнцэл, нийт	-113	-292	872	1,137	1,492	2,295	2,396	3,834

Тайлбар: 2005 суурь он гэж авч үзлээ.

Эх сурвалж: www.1212.mn

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар БНСУ-аас оруулсан импортын хэмжээ 2013 онд хамгийн оргилдоо буюу 507.36 сая ам.долл.-т хүрч, аажмаар бага зэргийн бууруулалттай байгаад 2018 оноос өсөж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй уялдан эрэлт хэрэгцээ, тухайлбал, хүн амын орлого, аж ахуйн нэгжийн түүхий эд, хувь хүний хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотой гэж үзэж болно. 2022 оны байдлаар БНСУ-ын импортын хэмжээ манай улсын нийт импортын 6%-ийг эзэлж байна. (ГХ, 2022)¹³⁵

Түүнчлэн БНСУ-аас Монгол Улсад оруулж буй шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь импортын хэрэгцээ үүсгэсэн байх талтай. (ГШХО, 2024)¹³⁶

Монгол Улсын экспортын хувьд 2005 оноос хойш нэлээд хэлбэлзэлтэй бөгөөд 2016 онд хамгийн бага буюу 8.47 сая ам.долл.-ын бараа бүтээгдэхүүнийг БНСУ-д экспортолсон байна. Харин экспорт 2018 оноос хойш өсөж, 2023 оны 12 сарын байдлаар Монгол Улсаас гаргаж буй нийт барааны эргэлтийн 1.1 хувь, манай улс үйлдвэрлэж буй барааныхаа 2 хувийг БНСУ-д экспортолдог бол гадаадаас импортолдог барааны 4.5 хувийг БНСУ-аас авч байгаа (МОНЦАМЭ, 2023)¹³⁷ нь Монгол Улсын төр, засгаас авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны үр дүн гэж үзэж байна.

¹³³ Ким Хун Жин. (2020). БНСУ-Монгол Улсын эдийн засгийн харилцааны ололт амжилт, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиг хандлага. -УБ., ГХЯ. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea). “Мөнхийн үсэг” ХХК. ISBN: 978-9919-23-484-3., 43.66 х.х., т.340-357;

¹³⁴ ҮСХ. (2024). Статистикийн нэгдсэн мэдээллийн сан. ИМПОРТ, улсаар, жилээр., ЭКСПОРТ, улсаар, жилээр., ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ, ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, сараар (өссөн дүн), жилээр., <https://www2.1212.mn/>

¹³⁵ Гадаад худалдаа. Импортын бүтэц, орноор, дүнд эзлэх хувь. (2024). ҮСХ. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан. https://www2.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L14

¹³⁶ ГШХО. (2024). ҮСХ. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, хөрөнгө оруулагч улсаар., https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1500_004V4&COUNTRY_select_all=1&COUNTRYSingleSelect=&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=table

¹³⁷ МОНЦАМЭ. (2023). БНСУ, ОХУ-тай Эдийн засгийн түншлэл, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар болжээ. <https://montsame.mn/mn/read/333438>

Хоёр улсын гадаад худалдаа 2013 онд оргилдоо хүрсэнээс хойш нэлээд хэлбэлзэлтэй байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарч, төгрөгийн ханш бууран, гадаад валютын нөөц багассанаас валютын хөрвөх чадвар буурсан, мөн Япон Улстай эдийн засгийн түншлэлийн гэрээ байгуулсанаар эрэлт хэрэгцээний шилжилт үүссэн зэрэг шалтгаантай гэж доктор Ким Хун Жин тодорхойлжээ. Бид БНСУ-ын экспорт, импортын 2016-2020 онуудын хэлбэлзэл /өсөлт, бууралт/ (Statista, 2024)¹³⁸, мөн 2020 оноос дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралаас шалтгаалсан байна.

Тамрамд дурдахад, 2023 оны 12 сарын байдлаар манай улсын 51 мянган иргэн амьдарч байгаагаас 37.7 мянга нь хөдөлмөр эрхэлдэг. Харин БНСУ-ын 1816 иргэн манай улсад ажиллаж байна.

БНСУ-тай хийсэн манай улсын нийт худалдааны эргэлт 1990-2022 онны хооронд 100 дахин нэмэгдсэн хэдий ч өнөөгийн байдлаар талуудын эдийн засгийн хамтын ажиллагаа хүсэн хүлээсэн түвшинд хүрээгүй байна.

Монгол Улсад 1994 оноос эхэлсэн БНСУ-ын хөрөнгө оруулалт өсөж, буурсан хэдий ч 2006 онд анх удаа нэг жилийн байдлаар 10,0 сая ам.дол.-аар давжээ (Хүснэгт 2). (Ким Хун Жин, 2020)¹³⁹

Хүснэгт 2. Монгол Улсын гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт

Үзүүлэлт		1994-2010	2011-2022
Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам.долл.)		1724.52	148,258.80
БНСУ	Экспорт (сая ам.долл.)	1543.36	734.51
	Импорт (сая ам.долл.)	181.16	3837.18
БНСУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам.долл.)		205.71	405.42
Шинээр бүртгүүлсэн хөрөнгө оруулагч (аж ахуйн нэгжиний тоо)		333	283

Эх сурвалж: О.Үржин, Б.Эрдэнэчимэг. Аюулгүй байдал ба “Туравдагч хөрш”-ийн бодлого; www.1212.mn

Судалгаанаас харахад хоёр улсын хоорондох гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, ажиллах хүчний хамтын ажиллагаа, аялал жуулчлал зэрэг нь тасралтгүй өсөж байгаа хэдий ч хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд “эдийн засгийн харилцааны философи” буюу амлалтаа биелүүлэх, итгэлцэл төрүүлэх, харилцан ашигтай байх, урт хугацааны стратеги (урт хугацаанд тогтвортой байх) гэсэн үндсэн дөрвөн зарчмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна. (Энхболд, 2020)¹⁴⁰

¹³⁸ Value of South Korea's imports from ASEAN countries from from 2012 to 2022(in billion U.S. dollars) (2024). Statista. <https://www.statista.com/statistics/658705/south-korea-import-value-from-asean-countries/>

¹³⁹ Ким Хун Жин. (2020). БНСУ-Монгол Улсын эдийн засгийн харилцааны ололт амжилт, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиг хандлага. -УБ., ГХЯ. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea). “Мөнхийн үсэг” ХХК. ISBN: 978-9919-23-484-3., 43.66 х.х., т.340-357;

¹⁴⁰ Энхболд, И. (2020). Зүүн хойд Ази дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал. -УБ., ГХЯ. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea). “Мөнхийн үсэг” ХХК. ISBN: 978-9919-23-484-3., 43.66 х.х., т.358-364;

II. Хоёр улсын гадаад худалдаа, эдийн засгийг төрөлжүүлэх арга замыг тодорхойлох арга зам, боломж

Эрх зүйн орчин: “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.1.5-д ““Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.”; 3.2.5.1-д “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна”, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ.” (МУҮАБҮБ, 2010)¹⁴¹, “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14.2-т “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” (МУГБҮБ, 2011)¹⁴² гэж тус тус тодорхойлсон.

“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон найдвартай түнш орон болж, гадаад худалдааны бодлогоор үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, худалдааны тэргүүлэгч орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эрчимжүүлэх, гадаад худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад худалдааг төрөлжсөн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар экспортын бүтээгдэхүүнийг үнэгүйдлээс сэргийлэх арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байна. (ГТХБ, 2018)¹⁴³

“Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө” зорилт 4.4-ийн хүрээнд бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна” гэж тодорхойлсон. (МУЗГ, 2020)¹⁴⁴

Дээрх дурдсан бодлогын баримт бичгүүдийн үндсэн хэсэг болох эдийн засгийн хөгжлийн бодлогод хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний болон орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх, болон бүтээлч, аж үйлдвэрлэл болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарыг дэмжин хөгжүүлэх талаар голлон заасан байна.

¹⁴¹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>

¹⁴² Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. (2011). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203362&showType=1>;

¹⁴³ Гурван тулгуурт хөгжлийн бодлого. (2018). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолын хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208322&showType=1>;

¹⁴⁴ Монгол Улсын Засгийн газар. (2020). Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого., Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол., 316 хуудас;

- ихэнх тарифын бус хязгаарлалтууд нь Дэлхийн худалдааны байгууллагаар хянагдах боломжгүй, олон улсын гэрээ хэлцлүүдээр зохицуулагддаггүй учир зарим орнуудын Засгийн газар гол хэрэгсэл болгож, чөлөөтэй ашиглаж байна.
- тарифын бус хязгаарлалт шууд барааны үнийг нэмэгдүүлдэггүй учир хэрэглэгчдэд татварын дарамт учруулдаггүй.


Экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс: С.Hidalgo, R.Hausmann нар олон улсын худалдааны 2006-2008 оны тоон мэдээллийг ашиглан хоёр бүтээгдэхүүний мэдлэгийн ялгаатай байдлыг хэмжин хоорондын хамаарлыг шинжилж, **бүтээгдэхүүний орон зай** (Product Space) хэмээх ойлголтыг бий болгож, улмаар 2009 онд эдийн засгийн цогц байдалд тулгуурласан эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал, мөн олон улсын худалдааны тоон мэдээллийг ашиглан эдийн засгийн цогц байдлын индекс (Economic Complexity Index - ECI)-ийг тооцох аргыг тус тус боловсруулсан.

Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ: Бүтээгдэхүүний орон зайн дүрслэлд харуулж буй зангилаа цэгүүд нь бүтээгдэхүүнийг, цэгийн хэмжээ нь дэлхийн худалдаанд эзлэх хувийг илтгэх бөгөөд байршиж буй бүтээгдэхүүнүүдийн зай ойр байх тусам тухайн бүтээгдэхүүнүүдийг нэг улс үйлдвэрлэдэг байх магадлал өндөртэй гэсэн үг¹⁴⁷.


Бүтээгдэхүүн тус бүрийн PCI болон дундаж холбоос (Average Connectedness) нь шугаман хамааралтай байх бөгөөд энэ нь аливаа бүтээгдэхүүнийг илүү боловсруулах тусам бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлдэг.

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний төрөлжилт маш сийрэг бөгөөд зангилааны цэгүүд нь төвөөс алслагдсан буюу боловсруулсан бүтээгдэхүүн тун бага хэмжээгээр экспортолж байна (Зураг 4.а).

БНСУ-ын бүтээгдэхүүний төрөлжилт өндөр байгаа бөгөөд зангилааны цэгүүд нь төв хэсэг рүү төвлөрсөн буюу боловсруулсан бүтээгдэхүүнийг их хэмжээгээр экспортолж байна. Тус улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүд нь машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл болон хөнгөн, химийн үйлдвэрлэл эзэлж байна (Зураг 4.б)¹⁴⁸



а. Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний орон зай



б. БНСУ-ын экспортын бүтээгдэхүүний орон зай

¹⁴⁷ Харвардын их сургуулийн Олон улсын хөгжлийн төв, The Atlas of Economic Complexity. (Center for International Development at Harvard University (2020). The Atlas of Economic Complexity. <http://www.atlas.cid.harvard.edu>. Nov. 11, 2020. <https://atlas.cid.harvard.edu/>

¹⁴⁸ Observatory of Economic Complexity (OEC). (2022). <https://oec.world/en/>

Эх сурвалж: <https://oec.world/en/>

Зураг 4. Монгол Улс, БНСУ-ын экспортын бүтээгдэхүүний орон зай, 2022 оны байдлаар

Монгол Улсын гадаад бодлогын үр ашгийг дээшлүүлэхийн тулд гадаад худалдааны хараат байдлын зэргэмжийг Херфиндаль-Хершманы индекс (ННН)-ээр тодорхойлж (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Херфиндаль-Хершманы индекс

Хараат байдал Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 0-33 хүртэлх хувийг хангах		Заримдаг хараат байдал Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 33-66 хүртэлх хувийг хангах		Хамааралтай байдал Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 66-аас дээш хувийг хангах	
ННН Хараат байдал		ННН Хараат байдал		ННН Хараат байдал	
0-0.11	хагас хараат	0-0.44	бага зэргийн хараат	0-0.77	хагас хараат
0.11-0.22	үлэмж хараам	0.44-0.55	хагас хараат	0.77-0.88	үлэмж хараам
0.22-оос дээш	бүрэн хараат	0.55-0.66	үлэмж хараат	0.88-аас дээш	бүрэн хараат
		0.66-аас дээш	бүрэн хараат		

Гадаад худалдаанд оролцогчдын хувийн жингийн квадратуудын нийлбэрийг олох замаар Херфиндаль-Хершманы индексийг тооцоолж, Монгол Улсын өргөн хэрэглээний зарим барааны хараат байдлын зэргэмжийг тооцооллоо (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Монгол Улсын өргөн хэрэглээний зарим импортын барааны хараат байдлын зэргэмж

№	Бараа, бүтээгдэхүүн	Хараат байдал	Хэмжээ, нэгж	ННН индекс	Хараат байдлын зэргэмж	Тайлбар (Импортод эзлэх хувь)
1	Цахилгаан эрчим хүч	Дотоод эх үүсвэрээс 66-аас их хувь	1,420,229.1 мян.квт	0.6649	Хараат бус	-
2	Наргил самар, бразил самар	Дотоод эх үүсвэрээс 33-аас бага хувь	2,446,728.2 кг	0.1837	Үлэмж хараат	ОХУ, Вьетнам, Энэтхэг тус бүр 20-оос дээш хувьтай
3	Шахмал ногоон цай		1,681,692.9 кг	0.5201	Бүрэн хараат	БНХАУ 60%, Гүрж 39.9%
4	Цагаан будаа		26,564,241.8 кг	0.3524	Бүрэн хараат	Вьетнам, ОХУ тус бүр 40%-тай
5	Элсэн чихэр		50,039,029.7 кг	0.2469	Бүрэн хараат	Тайланд 34.9%, Энэтхэг 28%
6	Автобензин. Октаны хэмжээ 90-ээс дээш (биодизель хольцгүй)		332,074,103.0 кг	0.9551	Бүрэн хараат	ОХУ 97.7%
7	Дизель түлш (зуны)		327,963,154.2 кг	0.9220		ОХУ 95.9%
8	Онгоцны түлш	24,775,627.0 кг	1.0	ОХУ 100%		
9	Түлшний мазут	2,588,539.0 кг	1.0		ОХУ 100%	
10	Нэхмэлийн мяндас бэлдэх, ээрэх, ороох машин	Дотоод эх үүсвэрээс 33-аас бага хувь	166 ш	0.7320	Бүрэн хараат	БНХАУ 84.6%
11	Сүлжмэлийн машин		189 ш	1.9382		БНХАУ 96.8%
12	Арьс ширэн түүхий эд бэлтгэх, гутал хийх, засварлах машин		209 ш	0.9716		БНХАУ 98.56%
13	Эрдэс бүтээгдэхүүнийг шигших, ялгах,		35,004 ш	0.7111		БНХАУ 83.72%

	угаах, бутлах, нунтаглах машины эд анги				
14	Трактор	877 ш	0.9047		БНХАУ 95.0 хувь
15	Нийтийн тээврийн моторт хэрэгсэл	965 ш	0.5349	Бүрэн хараат	Импортод БНСУ 71.0%

Хүснэгт 5-аас харахад Монгол Улсын импортын зарим бүтээгдэхүүн дотоод эх үүсвэрээс 33-аас доош хувьтай байгаа бөгөөд 13 нь “бүрэн хараат”, харин цахилгаан эрчим хүч хараат бус байна. Импортод нэг улсын эзлэх хувь өндөр, дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа нь хараат байдалд орох үндсэн нөхцөл болж байна.

Улс орнууд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, түншлэлийн харилцаа тогтоох, олон улсын байгууллага болон бүс нутгийн интеграцад нэгдэх зэргээр гадаад худалдааг хөнгөвчлөх, хамгаалах үйл ажиллагааг явуулж байна.

Гадаад худалдааг дэмжих, хөнгөвчлөх чиглэлээр: Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт 2017 онд нэгдэн орсон нь далайд гарцгүй, худалдааны өртөг, ялангуяа дамжин өнгөрөх тээврийн зардал өндөртэй улс орнуудын хувьд хил, гаалийн үйлчилгээг сайжруулах, дамжин өнгөрөх барааг түргэн шуурхай нэвтрүүлэх, түүнтэй холбоотой үл ялгаварлах зарчмыг баримтлах, чөлөөтэй дамжин өнгөрөх зарчмыг дэмжих, худалдааны зардлыг бууруулахад өндөр ач холбогдолтой.

Монгол Улс Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээрт нэгдэн орох ажлыг эхлүүлээд байна. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон энэхүү Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээрийг хамтад нь хэрэгжүүлснээр Монгол Улсад худалдааны зардал 30 хувиар буурна гэж тооцож байгаа.

Судалгаагаар Монгол Улс НҮБ-ын гишүүн 193 улсын дотор экспортын барааны төвлөрлийн индексээр 55, импортын барааны төвлөрлийн индексээр 33, экспортын зах зээлийн төвлөрлийн үзүүлэлтээр 9, импортын зах зээлийн төвлөрлийн үзүүлэлтээр 29 дүгээр байрт тус тус жагссан нь Монгол Улс гадаад худалдааны гол түнш улсууд, мөн гол нэрийн бүтээгдэхүүнээс хараат байдалд байгааг харуулж байна.

Монгол Улс 1994 онд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсноор бусад 164 гишүүн улстай тэгш эрхтэй худалдаа хийх, гадаад зах зээлд хөнгөлөлттэй буюу үндэсний нэн тааламжтай болон үндэсний нөхцөл эдлэх, олон талт худалдааны тогтолцоонд хамтын шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж бүрдсэн. Монгол Улс гадаад худалдааны бодлогодоо худалдааны олон талт хэлэлцээрээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд үл ялгаварлах, олон улсын худалдааг либералчлах, хөгжил болон өрсөлдөөнийг дэмжих зарчмыг баримталж байна. Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны эрх зүйн орчин нь нэг талаас гишүүн улсад хатуу үүрэг хүлээлгэх боловч үндэсний хэмжээнд зах зээлээ хамгаалах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, хөгжиж буй орнуудад нэн тулгамдсан эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдлыг хангах, төлбөрийн тэнцлийн хэт алдагдлыг бууруулах боломжийг олгодог.

Шинээр чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас БНСУ-тай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааг явуулсан. Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2020 онд нэгдсэн. Ийнхүү уг хэлэлцээрийн

7 дахь гишүүн болсон нь манай улсад анхны бүс нутгийн худалдааны хэлэлцээр болсон бөгөөд 2021 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. Энэ хэлэлцээрийн хүрээнд БНХАУ, Энэтхэг, БНСУ зэрэг зургаан улстай нийт 10677 нэр төрлийн бараанд 5-100 хувийн тарифын хөнгөлөлт эдлэнэ. Тухайлбал, БНХАУ-ын нүүрсний импортын татвар 2 дахин буурсан нь Монгол Улсын экспортлогчдод томоохон боломж олгосон.

Ташрамд дурдахад өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол Улсын гадаад худалдааны бодлогын чиг үүрэг хариуцсан бүтэц зургаан удаагийн өөрчлөлтөд орсон нь бодлогын залгамж чанар, уялдаа холбоо, хүний нөөцийн мэргэшсэн байдалд таагүй нөлөө үзүүлсэн. Түүнчлэн дотоодын зах зээл, үйлдвэрлэлийг хамгаалж, хөгжүүлэх зорилгоор тарифын болон тарифын бус зохицуулалтыг оновчтой хэрэгжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийн үнэмлэхүй болон харьцангуй давуу тал дээр тулгуурласан экспортын үйлдвэрлэлийг дэмжих, экспортлогч ААН-г хөгжүүлэх бүтэц, санхүүжилтийн механизмыг бий болгох, мөн гадаад зах зээлд таатай нөхцөл, орчныг бүрдүүлэх чиглэлээр нэгдсэн уялдаатай, оновчтой зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

1. Монгол Улсад гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн орчин, гадаад худалдааны бодлогын үндэс бүрдсэн хэдий ч бодлогын зохицуулалт, хэрэгжүүлэх тогтолцоог хангах асуудлуудад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

2. Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд боловсруулах эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүддээ Монголын байгалийн баялаг, хямд ажиллах хүчийг Өмнөд Солонгосын технологийн хөгжилтэй хослуулсан хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэрлэлийн төслүүдийг хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжих, хэрэгжүүлэх, цаашлаад Монголыг шинэ технологи бүхий аж үйлдвэрлэлийн бүс, Зүүн Өмнөд Азийн орнуудын Евроази руу гарах эдийн засгийн түшиц цэг болгон хөгжүүлбэл зүйтэй байна.

3. Гадаад худалдааны бодлогын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж хөгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тарифыг бий болгох, шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох таатай нөхцөлүүдийг урьдчилан бүрдүүлэх, үүний тулд БНСУ-тай чөлөөт худалдааны бүс байгуулах асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Ном зүй

Harvard. (2024, 3 02). Retrieved from Atlas of Economic Complexity: <https://atlas.cid.harvard.edu/countries/121/growth-dynamics>

2. Statista. (2024, 03 10). Value of South Korea's imports from ASEAN countries from from 2012 to 2022(in billion U.S. dollars). Retrieved from Statista: <https://www.statista.com/statistics/658705/south-korea-import-value-from-asean-countries/>

3. UNCTAD. (2019). Key Statistics and Trends in Trade Policy 2019 - Retaliatory Tariffs between the United States and China. 23 Mar 2020. ISBN 978-92-1-112973-1: UNCTAD/DITC/TAB/2019/9.

4. АСЕМ. (2016, 07 16). АСЕМ-ЫН ДЭЭД ТҮВШНИЙ 11 ДҮГЭЭР УУЛЗАЛТ “АСЕМ-ЫН 20 ЖИЛ: УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙЖ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ТҮНШЛЭХ НЬ”. Retrieved from Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар (Permanent Mission of Mongolia to the United Nations)-ын

цахим хуудас. (2016).: <https://www.un.int/mongolia/news/асем-ын-дээд-түвшний-11-дүгээр-уулзалт-“асем-ын-20-жил-уялдаа-холбоотой-байж-ирэ>

5. ГТХБ. (2018, 02 06). Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолын хавсралт. Гурван тулгуурт хөгжлийн бодлого. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208322&showType=1>
6. ГХ. (2022, 12 31). Гадаад худалдаа. Импортын бүтэц, орноор, дүнд эзлэх хувь. Retrieved from ҮСХ. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан.: https://www2.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L14
7. ГХЯ. (2024, 03 10). Монгол Улс, БНСУ-ын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал. Retrieved from Монгол Улсын Гадаад харилцааны яам: <https://mfa.gov.mn/63590>
8. ГШХО. (2024, 3 02). Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, хөрөнгө оруулагч улсаар. Retrieved from ҮСХ. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан.: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1500_004V4&COUNTRY_select_all=1&COUNTRYSingleSelect=&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=table
9. Ким Хун Жин. (2020). БНСУ-Монгол Улсын эдийн засгийн харилцааны ололт амжилт, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиг хандлага. In Ж. Ломбо, & Л. Хаш-Эрдэнэ, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea (pp. 340-357). Улаанбаатар, ГХЯ.: "Мөнхийн үсэг" ХХК. ISBN: 978-9919-23-484-368 43.66 х.х.
10. Ломбо, Ж., & Хаш-Эрдэнэ, Л. (2020). Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea). Улаанбаатар: ГХЯ. “Мөнхийн үсэг” ХХК. ISBN: 978-9919-23-484-3., 43.66 х.х.;
11. МОНЦАМЭ. (2023, 12 13). БНСУ, ОХУ-тай Эдийн засгийн түншлэл, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар болжээ. Retrieved from Монголын үндэсний мэдээллийн агентлаг: <https://montsame.mn/mn/read/333438>
12. МУГБҮБ. (2011, 02 10). Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203362&showType=1>
13. МУЗГ. (2020). Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Улаанбаатар: ЗГХЭГ.
14. МУҮАБҮБ. (2010). Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>
15. Үржин, О., & Эрдэнэчимэг, Б. (2023). Монгол Улс, БНСУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв. In О. Үржин, & Б. Эрдэнэчимэг, Аюулгүй байдал ба “Туравдагч хөрш”-ийн бодлого (pp. 251-281). Улаанбаатар., БХЭШХ: “Удам соёл” ХХК., ISBN: 978-9919-9955-7-7., 21.1 х.х.
16. ҮСХ. (2023). Гадаад худалдааны салбарын танилцуулга-2022. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо. www.1212.mn.
17. ҮСХ. (2024, 03 02). Статистикийн нэгдсэн мэдээллийн сан. Retrieved from 1212.mn: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1400_010V3&IMPORT_Country_select_all=0&IMPORT_CountrySingleSelect=_12102_1&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=table; https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1400_006V3&COUNTRY_select_all=0&

Энхболд, И. (2020). Зүүн хойд Ази дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал. In Ж. Ломбо, & Л. Хаш-Эрдэнэ, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил (30 years of Relations Between Mongolia and Republic of Korea) (pp. 358-364). Улаанбаатар., ГХЯ: "Мөнхийн үсэг" ХХК. ISBN: 978-9919-23-484-368 43.66 х.х.

The influence of demographic and economic factors on housing purchase in Mongolia

Орон сууц худалдан авалтад хүн ам зүй-эдийн засгийн хүчин зүйл нөлөөлөх нь

U.Enkhtuyagerel(M.A)
(International University of Ulaanbaatar)
enkhtuyagerel.u@ulaanbaatar.edu.mn

Хураангуй:

Орон сууц худалдан авах шийдвэр гаргалтад хүн ам зүй-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох нь шинжлэх ухааны ач холбогдолтой. Хүн ам зүйн үндсэн хүчин зүйл болох нас, өрхийн амьдралын мөчлөг, гэр бүлийн байдал, амьдралын хэв маяг нь орон сууцны эрэлтийн төлөв, хандлагыг тодорхойлдог нь тохиромжтой байршил, боломжийн үнэ зэрэг зохих үзүүлэлт болдог. Орон сууцны хүртээмж нь орон сууцанд амьдрах хүсэл, эрмэлзэл, худалдан авах бололцоо бүхий худалдан авагчийн зарим сегментийн анхаарлыг татах боломжтой юм. Энэхүү судалгаагаар хүн ам зүйн хүчин зүйлийн гэр бүлийн амьдралын мөчлөг, хүүхдийн тоо, хүүхдийн насны бүлэглэл, сууцны насжилт, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо болон өрхийн зарлага, мөнгөн орлого зэрэг хүчин зүйлүүдээр судаллаа. Орон сууц худалдан авалтад орлого, зарлага нь гэр бүлийн амьдралын мөчлөг бүрд ялгаатай нөлөө үзүүлж байгаа нь судалгаагаар нотлогдсон байна.

Түлхүүр үг: Гэр бүлийн амьдралын мөчлөг, хүүхдийн нас, хүүхдийн тоо, өрхийн орлого, зарлага

Оршил:

Орон сууцны зах зээлийн хөгжил нь улс орны санхүүгийн зах зээл, эдийн засгийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулдаг. Орон сууцны хангамж, чанар болон түүний санхүүжилт нь тухайн улсын хөгжлийн түвшинг илэрхийлдэг хүчин зүйл бөгөөд дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагыг даган энэхүү салбарын хөгжил ч мөн шинэчлэгдэн боловсронгуй болж хөгжсөөр ирлээ. Монгол улсын засгийн газар хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан, ард иргэдийнхээ аюулгүй амьдрах нөхцөл бололцоог сайжруулах үүднээс урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа -2050” боловсруулж хүний хэрэгцээнд нийцсэн чанартай, тохилог орон сууцны хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх үе гэж үзээд өрх, гэр бүлийн эрэлтэд нийцтэй, худалдан авах чадварт тохирсон, чанартай тохилог орон сууцаар хангах гэж зорилго тавьсан.

Орон сууц нь удаан хугацааны туршид ашиглах хүний амьдралын аюулгүй байдлын анхдагч хэрэгцээ төдийгүй, хүн төрөлхтний амьдралын түүхэн үеүдэд тухайн нийгмийн эрэлт, шаардлагын дагуу боловсронгуй болж хөгжсөөр иржээ.

Санхүү, эдийн засгийн нөхцөл байдал нь орон сууцны зах зээлд нөлөөлж байна. Хувь хүн болон нийгмийн хязгаарлалтын үндсэн дээр хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг

хангахуйц орон сууцыг зах зээлд нийлүүлэх нь хэрэглэгч, худалдан авагчийн амьжиргааг дээшлүүлэх төдийгүй, хот суурин газрын бохирдлыг багасгах, цаг уурын дулааралд эергээр нөлөөлөх зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны онцгой ач холбогдолтой юм.

Судалгааны ажлын үндэслэл, зорилго, арга зүй:

Орон сууцны зах зээлийн дүр зургийг гаргахын тулд хамгийн чухал нөлөө үзүүлэх хүн ам, орон сууцны нийлүүлэлт, эрэлт, түүнчлэн гэр бүлийн орлого, гэр бүлийн амьдралын хэв маяг, амьдралын мөчлөг, орон сууцны зардлын судалгаа хийх явдал юм.

Судалгааны зорилго: Хэрэглэгчийн орон сууц худалдан авах шийдвэрт хүн ам зүй-эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөллийг судлан тодорхойлоход оршино.

Судалгааны зорилт:

- Хэрэглэгчийн худалдан авах шийдвэр гаргах онол арга зүйн хүрээний асуудлыг тодорхойлох
- Орон сууцанд амьдарч буй хэрэглэгчийн амьдралын мөчлөгийн үе шатыг хэрэглэгчийн зан төлөвийн онол арга зүй болон хүн ам зүйн судалгаанд тулгуурлан боловсруулах
- Орон сууцны худалдан авалтад үзүүлэх эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөллийг судлан тайлбарлах

Судалгааны мэдээллийг регресс болон корреляцийн шинжилгээ /стандарт/, олон хүчин зүйлийн корреляцийн шинжилгээгээр хийлээ. 2017-2023 оны Монгол банкны ипотекийн зээлийн судалгааны задаргаа мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийсэн. Судалгааны Кэйзер (KMO)=0.86 утгатай байгаа нь түүвэр хангалттай болохыг, Кронбах альфа (Cronbach's alpha)=0.89 утгатай байгаа нь асуултууд найдвартай болохыг тус тус илэрхийлж байна. Ач холбогдлын түвшин 0,05; 0.01 буюу 95 болон 99 хувийн магадлалтайгаар E Views-12 программ дээр үнэлж гаргав.

Судлагдсан байдал:

Эрдэмтэн Wheaton (1990), Cronin (1982), Koklic болон Vida (2001), Rashid (2012), Hood (1999) нар орон сууцны зах зээлийг хүн ам зүйн хүчин зүйлтэй холбон судалгаа хийжээ. Эрдэмтэн Wheaton (1990) судалгаандаа орон сууцны хүн ам зүйн томоохон өөрчлөлтүүдийг судлан орон сууц худалдан авахыг өрхийн санхүүтэй холбогдуулан тайлбарлажээ.

Эрдэмтэн Wheaton 1990, Rashidi 2012, Rossi 1955, Galvez болон Kleit нар 2011 онд “өрхийн хүн ам зүйн хүчин зүйлийн өөрчлөлт нь орон сууцны худалдан авах шийдвэр, сонголтод гол нөлөөлөгч хүчин зүйлс гэж үзээд өрхийн орон сууц худалдан авах асуудалд хүйс, нас, гэр бүлийн байдал, мэргэжил, гэрийн эзний боловсролын түвшин, ам бүлийн тоо, өрхийн бүтэц, өрхийн орлого, зарлагын түвшин, орон сууцны зах зээлийн тухай мэдлэг, орон сууцны харьяалагдах бүс орно” гэж үзсэн байна. (Adude, 2014)

Эрдэмтэн Mateja Kos Koklic болон Irena Vida нар нь “Strategic Household Purchase Consumer House Buying Behavior” өгүүлэлдээ хэрэглэгч өөрийн туршлага, хувийн байдал, орчны хүчин зүйл, мэдрэмж, ухамсарт хүчин зүйл, эрэлт, хэрэгцээ зэрэг зорилгодоо үндэслэж шийдвэр гаргадаг гэж үзжээ. (Koklic & Vida, 2009)

Эрдэмтэн Sabagh (1969), Ritchey (1976), Priemus (1984), Musterd (1989), Smid болон Priemus (1994), Mulder (1986) нар Гэр бүлийн амьдралын мөчлөг, гэр бүлийн байдал, орлого, амьдралын хэв маяг, нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлийг үндэслэн орон сууцны эрэлт хэрэгцээг урьдчилан таамаглах боломжтой гэдгийг нотолжээ. Дээрх хандлагын хүрээнд эрдэмтэн Росси (1955) орон сууцны амьдралын мөчлөгийн загварыг боловсруулжээ. Энэ загвар нь айл өрхийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох буюу цөм гэр бүл үүсэх¹⁴⁹ өргөтгөх¹⁵⁰, буурах¹⁵¹, татан буулгах¹⁵² үе шатуудад амьдралын хэв маяг өөр өөр байна гэж үзжээ. (Danko, March 1993, pp. 580–94) Тэрээр хэрэглэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хандах хандлага нь гэр бүлийн мөчлөгөөс ихээхэн хамаарах бөгөөд зан төлөвт хүчтэй нөлөө үзүүлдэг. Өрхийн ам бүлийн тоо, бүтцийн өөрчлөлт нь орон сууцны сонголт, хэрэгцээнд үндэслэдэг гэжээ. Гэр бүлийн унтлагын өрөөний тоо, орон сууцны чанар гэр бүлийн хэрэгцээг хангах боловч амьдралын мөчлөгийн шинэ үе шат руу шилжих шилжилтэд үл нийцэлд хүргэж болох юм гэдгийг гарган иржээ.

Эрдэмтэн Del L. Hawkins David L. Mothersbaugh нар “Хэрэглэгчийн зан төлөв” номдоо эрдэмтэн Wilkes-ийн “A New Full-Nest Classification Approach” бүтээлээс иш татсан байдаг. Тус бүтээлд гэр бүлийн амьдралын мөчлөгийг нарийвчлан судалж, залуу гэр бүл, дунд насны гэр бүл, ахмад насны гэр бүл гэж 3 бүлэгт хуваан авч үзээд дотор нь 11 ангилжээ. (Wilkes & Lee, January 2002)

Судлаач Mossel болон Valk нар (2008) орон сууц худалдан авагчдыг дээд зэргийн чанараар хангах, сэтгэл хангалуун байлгах, худалдан авсны дараах үйлчилгээний чанар, орон сууцны нөхцөлийг сайжруулах, худалдан авах сэтгэл ханамжийн түвшин шалгах боломжтой гэж үзжээ.

Эрдэмтэн Valerle Kupke (2008) Орон сууц худалдан авалтад хүүхдийн тоо, гэрлэлт, шинээр ажилд орох, тушаал дэвших, нас, өрхийн орлого зэрэг нөлөөлдөг гэж үзжээ.

Clark (2003) Ажил эрхлэлтийн байдлаас шалтгаалан өрхийн эзэмшиж байгаа орон сууц, сууцны чанар, үнэ, нөхцөлөөр нь ялгаатай байдаг гэдгийг нотолсон байна. Эдгээр бүтээлүүд нь орон сууц худалдан авалтыг хэрэглэгчийн хүн ам зүйн хүчин зүйлтэй холбон судлах нь чухал гэдгийг нотолж байна.

Н А Morrow-Jones –ийн бүтээлд АНУ-ын орон сууцны амьдралын мөчлөг, орон сууц эзэмшлийн хэв маягийн ойлголтыг судалж, залуу насны хүмүүс эхлээд түрээсийн байранд амьдарч байгаад дараа нь өөрийн эзэмшлийн орон гэртэй болдог талаар дүгнэжээ. 1974-1983 оны АНУ-ын орон сууцны судалгааны мэдээлэлд нас, орон сууцны шилжилт хөдөлгөөн, орон сууцны эдэлгээ гэх мэт олон нөхцөлөөр судалсан байна. Орон сууцыг түрээслэх,

¹⁴⁹ Хамтын амьдрал/ гэрлэлт

¹⁵⁰ Хүүхэд төрөх

¹⁵¹ Хүүхэд эцэг, эхээс өрх тусгаарлах

¹⁵² Эхнэр/ нөхөр хэн нэгэн нас барах

худалдан авахад амьдралын мөчлөгийн хүчин зүйлс, эдийн засгийн байдал онцгой ач холбогдолтой юм. (Morrow-Jones, 23 January 1987) Эрдэмтэн Omagwa job Ombongi /2014/ “Demographics, housing search, asymmetric information and housing decisions amongst apartment households in nairobi county, kenya” нэг сэдэвт судалгааны ажилдаа орон сууц сонгох болон орон сууц худалдан авалтад хүн ам зүйн үзүүлэлтүүдээс хөрш сонгох, орон сууцны байшингийн байршил сонголт, орчны нөхцөл байдалтай холбоотой гаргаж аливаа орон сууцны шийдвэр нь статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж болно гэж дүгнэжээ (Ombongi, 2014)

Монголын эрдэмтэн Д.Ган-Очир (2007) онд орон сууцны үнэнд нөлөөлдөг хүчин зүйлсийн үнэлгээнд хэрэглэгчийн орон сууцны байршил, ая тухтай байдал, барилгын төлөв байдал буюу үүнд барилгын чанар, барьсан компанийн нэр хүнд нь гэх мэт хүчин зүйлс нөлөөлж байна гэж дүгнэсэн байна. Тэрээр хэрэглэгч эхлээд өөрийн орлого болон нөөц бололцоондоо тулгуурлан орон сууцыг худалдан авдаг гэж үзжээ.(Ган-Очир, 2007 он) Эдгээр судлаачдын бүтээлийг үзэхэд орон сууц худалдан авалтад хувь хүний хүчин зүйл чухал нөлөөтэй бөгөөд түүнийг судлах нь зайлшгүй чухал гэдгийг нотолж байна.

Хүснэгт.1

Эрдэмтэд хүн ам зүйн хүчин зүйлийг судалсан байдал

Судлаач эрдэмтэд	Нөлөөлөх хүчин зүйлс, үзүүлэлтээр	Судалгааны тайлбар
Эрдэмтэн Wheaton 1990, Rashidi 2012, Rossi 1955, Galvez болон Kleit 2011	<ul style="list-style-type: none"> • Хүйс • Нас • Гэр бүлийн байдал • Мэргэжил • Гэрийн эзний боловсролын түвшин, • Ам бүлийн тоо • Өрхийн бүтэц, • Өрхийн орлого, зарлагын түвшин • Орон сууцны зах зээлийн тухай мэдлэг • Орон сууцны харьяалагдах бүс 	Өрхийн хүн ам зүйн хүчин зүйлийн өөрчлөлт нь орон сууцны худалдан авах шийдвэр, сонголтод гол нөлөө үзүүлэгч мөн гэж үзжээ.
Эрдэмтэн Sabagh (1969), Ritchey (1976), Priemus (1984), Musterd (1989)	<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн амьдралын мөчлөг • Гэр бүлийн байдал • Орлого • Амьдралын хэв маяг • Нийгэм-хүн ам зүйн шинж чанар 	Орон сууцны эрэлт хэрэгцээг урьдчилан таамаглах явдал юм гэж эрдэмтэд үзжээ.
Peter H. Rossi and Elandor Weber	<ul style="list-style-type: none"> • Эзэмшлийн төрөл • Орон сууцны төрөл • Нас • Хүүхдийн насны бүлэг • Боловсрол • Гэр бүлийн амьдралын мөчлөг • Хадгаламж • Зээл • Сууцны насжилт, • Чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөдөг зэрэг үзүүлэлтээр судалжээ. 	Росси (1955) онд орон сууцны амьдралын мөчлөгийн загварыг боловсруулжээ
John Doling /2008/	<ul style="list-style-type: none"> • Нас • Амьдралын мөчлөг, 	Амьдралын мөчлөгөөр ахмад насны гэр бүлүүдийн тэтгэврийн тогтолцоог сайжруулах шаардлагатайг нотолсон

	<ul style="list-style-type: none"> • Өмчлөлийн хэлбэр, • Төрөлтийн хувь хэмжээ, • Тэтгэврийн насыг хамааруулж үзжээ. 	байна. Ахмад насны хувийн орон сууцанд амьдардаг гэр бүлийг хямд орон сууцанд шилжин амьдрах боломжийг судлах, хямд үнэтэй орон сууцанд амьдардаг ахмад насны гэр бүлийг түрээсийн орон сууцаар хангах боломжийг судалсан байна.
Omagwa job Ombongi 2014	<ul style="list-style-type: none"> • Өрхийн зарлага • Эзэмшлийн төрөл • Гэр бүлийн амьдралын мөчлөг • Боловсрол • Ам бүлийн тоо • Гэрлэлтийн байдал • Орон сууцны зах зээлийн туршлага • Мэргэжил 	Судалгааны хүн ам зүйн үзүүлэлтүүд нь хөрш сонгох, байршил сонгох, орчны нөхцөл байдалтай холбогдуулан орон сууцны худалдан авах шийдвэр гаргалт нь статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж байгааг нотлон харуулжээ.
Clara H. Mulder /2006/	<ul style="list-style-type: none"> • Хүн амын тоо • Өрхийн тоо 	Хүн амын тоо, орон сууц худалдан авалтын хоорондын харилцан уялдааг судалж, хүн амын тоо, өрхийн тоо нь орон сууцны эрэлтийг тодорхойлох боломжтойг нотолжээ.

Эх үүсвэр: Судлаачийн боловсруулснаар


Эрдэмтэн Philip Kotler худалдан авагчийн шийдвэрт амьдралын мөчлөгийн үе шат, нас, хувь хүний онцлог шинж чанар, ажил мэргэжил болон эдийн засгийн нөхцөл байдал, хувь хүний өөрийн үзэл баримтлал, амьдралын хэв маяг зэрэг нь чухал нөлөө үзүүлдэг гэж дүгнэжээ. (Philip Kotler, 2012)

Судалгааны үр дүн:

Монгол улсын барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдэж, түүн дотор орон сууцны барилга, хөрөнгө оруулалтын нэлээд хувийг эзэлж байна. Орон сууцны зах зээлийн хөгжил нь улс орны санхүүгийн зах зээл, эдийн засгийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулдаг бөгөөд орон сууцны хангамж, чанар болон түүний санхүүжилт нь тухайн улсын хөгжлийн түвшин илэрхийлдэг чухал хүчин зүйлийн нэг нь байдаг ба дэлхийн нийтийн хөгжлийн хандлагыг даган энэхүү салбарын хөгжил мөн шинэчлэгдэн боловсронгуй болж хөгжсөөр байна.

Зураг.1

Орон сууцны барилга, сууцны тоогоор, ашиглалтад оруулсан талбай мян. м.кв (2004-2022 оны байдлаар)



Эх үүсвэр: МУҮСХ 2004-2022 оны эмхэтгэл

2013 оны 2-р улирлаас орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор Монгол банк болон Барилга, хот байгуулалтын яам хамтран найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг арилжааны банкнуудаар дамжуулан олгож эхэлсэн. Хөтөлбөрийн үр дүнд бага дунд орлоготой иргэдэд орон сууц худалдан авах боломж нэмэгджээ.

2004 оноос 2022 оны хооронд 247511 өрхийн орон сууц ашиглалтад орж, 14250,3 мян. м² талбай ашиглалтад оржээ. 2014, 2015 онуудад орон сууц хамгийн их буюу жилд 23800 гаруй орон сууц баригдаж хотын өнгө үзэмжийг чимж байсан байна.

2023 оны эцсийн байдлаар ипотекийн 114814 зээлдэгчийн 7.643.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2

Өрхийн орлогоос хамаарсан сууцны талбайн ангилал


Өрхийн орлогын ангилал	Сууцны талбайн хэмжээ (м ²), өрөөний тоо					
	1	2	3	4	5	6
Өндөр орлоготой				88	96	120-оос дээш
Дунд орлоготой	40	50	60	70	87	
Энгийн орлоготой	30	36	44			

Эх үүсвэр: ЗТБХБСайдын 2010 оны 12-р сарын 23-ны 418 тоот тушаал

Тус судалгааг судлаач орон сууц худалдан авалтыг 40 м² бага талбайтай, 41-60 м² талбайтай, 61-80м², 81-100м², 101-120м², 120-оос дээш м² талбайтай орон сууцанд амьдардаг гэж 6 сегментээр хуваан авч үзлээ.

Зураг.2

Нийт зээлдэгчийн талбайн хэмжээ



Эх үүсвэр: <https://stat.mongolbank.mn/finance>

2017 оны байдлаар 40м² бага талбайтай орон сууц 33 хувийг эзэлж байсан бол 2018 онд өмнөх оны мөн үеэс 1.3 пункт, 2019 онд 1.6 пункт, 2020 онд 1.8 пункт, 2021 онд 3.5 пункт, 2022 онд 2.1 пункт, 2023 онд 1.1 пунктээр өмнөх оны мөн үеэсээ буурсан үзүүлэлттэй байгаа нь ипотекийн зээлдэгч нар нь 40-өөс дээш метр квадрат талбайтай орон сууцанд орж байна гэж үзэж болох юм. 41-60 м² талбайтай орон сууцанд 2023 онд 44.1 хувийг эзлэж байгаа нь 2017оны үетэй харьцуулахад 3,8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд 61-80 м² талбайтай орон сууцанд нийт зээлдэгчийн 26.3 хувийг эзэлж байгаа бол 81-120 м² талбайтай орон сууцанд нийт зээлдэгчийн 7.9 хувийг эзэлж байна.



Эх үүсвэр: МУҮСХ 2004-2022 оны эмхэтгэл

2004 онд орон сууцны нэг өрхөд ноогдох дундаж хэмжээ 63.9 м.кв талбай ногдож байсан бол арван жилийн дараа буюу 2014 онд нэг өрхөд ноогдох талбайн хэмжээ 67.3 м.кв буюу 2004 оны мөн үетэй харьцуулахад 3.4 м. кв талбайгаар өссөн үзүүлэлттэй байна. 2022 онд нэг өрхөд ноогдох дундаж хэмжээ 70.6 м.кв талбай ноогдож өмнөх 2014 оны мөн үеэс 6.7 м.кв талбайгаар өсжээ. 2019 оноос оноос нэг өрхөд ноогдох талбайн хэмжээ нэмэгдсэн байна. 2021 онд нэг өрхөд ноогдох талбайн хэмжээ 71,5м² болсон боловч 2022 онд 0,9 м² талбайгаар буурчээ. Монгол улсад амьдралын түвшин, амьдралын чанарын асуудал чухлаар тавигдах шаардлагатай байгааг харуулж байна.

Эрдэмтэд хүн ам зүй-эдийн засгийн хүчин зүйл нь орон сууц худалдан авах шийдвэр, сонголтод нөлөөлөгч гол хүчин зүйл гэж үзжээ. Эрдэмтдийн судалгаагаар хамгийн их давтамжтайгаар нас, ам бүлийн тоо, ажил эрхлэлт, сууцны насжилт, мөнгөн орлого, ам бүлийн тоо зэрэг хүчин зүйлүүдийг хамааруулан судалж байна.

2024 оны 2 сарын байдлаар ипотекийн зээл авсан 115627 өрх. зээлдэгчийн нийт 7813,4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны үеэс 18,8 хувиар өссөн. Нийт зээлдэгчийн 18-25 нас 1.37 хувь, 26-35 нас 34.17 хувь, 36-45 нас 42.03 хувь, 45-55 нас 18.37 хувь, 56-65 нас 3.79 хувь, 66-дээш нас 0,27 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18-25 насны зээлдэгч 0.22, 26-35 нас 087, 36-45 нас 0,09 пунктээр өссөн бол , 45-55 нас 0.78, 56-65 нас 0,65, 65-аас дээш нас 0.02 пунктээр буурчээ. Энэ судалгаанаас харахад 45-аас дээш насныханд орон сууцны ипотекийн зээл гарах нь багассан байна гэж үзэж болох юм.

Өрхийн орлого нь орон сууц худалдан авалтад нөлөөлнө гэж үзэж шугаман регрессийн загвараар бодоход дараах үр дүн гарлаа.

Хүснэгт.3

Орон сууц худалдан авалтад өрхийн орлогын нөлөөлөл

А. Y- орон сууц худалдан авалт, In- орлого

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	13.52074	0.105913	127.6588	0.0000

IN	5.79E-07	3.94E-08	14.72354	0.0000
R-squared	0.904080	Mean dependent var	15.07793	
Adjusted R-squared	0.899909	S.D. dependent var	0.089500	
S.E. of regression	0.028315	Akaike info criterion	-4.214219	
Sum squared resid	0.018440	Schwarz criterion	-4.116709	
Log likelihood	54.67773	Hannan-Quinn criter.	-4.187174	
F-statistic	216.7827	Durbin-Watson stat	1.032664	
Prob(F-statistic)	0.000000			

Үнэлэгдсэн регрессийн тэгшитгэл

Estimation Command:

=====
LS Y C IN

Estimation Equation:

=====
Y = C(1) + C(2)*IN

Substituted Coefficients:

=====
Y = 13.520740856 + 5.79413731398e-07*IN

Орон сууц худалдан авах чадвар нь орлоготой хамааралтай гэдгийг шалган үзээд орон сууц худалдан авалтад орлогын нөлөөлөх нөлөө 89 хувьтай байгаа нь төлөөлөх чадвар өндөр байна. Судлаач энэ тэгшитгэлийг тайлбарлавал орлого 1 хувиар өсөхөд орон сууц худалдан авалт 5.79 пунктээр өснө гэсэн үр дүнг илтгэж байна.

Хүснэгт.4

Орон сууц худалдан авалт өрхийн тэргүүний настай хамааралтай

В. у- орон сууц худалдан авалт, age- нас, age1= 18-25, age2= 26-35, age3- 36-45, age4=46-55, age5=56-65, age6= 66 дээш

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	13.24584	0.306038	43.28167	0.0000
AGE1	-7.33E-05	5.39E-05	-1.361256	0.1894
AGE2	2.55E-05	5.12E-06	4.992104	0.0001
AGE3	4.85E-05	1.83E-05	2.648957	0.0158
AGE4	-6.87E-05	5.95E-05	-1.153340	0.2631
AGE5	8.98E-05	5.23E-05	1.718873	0.1019
AGE6	0.000154	4.27E-05	3.601884	0.0019
R-squared	0.969955	Mean dependent var	14.79985	
Adjusted R-squared	0.960467	S.D. dependent var	0.055018	
S.E. of regression	0.010939	Akaike info criterion	-5.968138	
Sum squared resid	0.002274	Schwarz criterion	-5.629420	
Log likelihood	84.58580	Hannan-Quinn criter.	-5.870599	
F-statistic	102.2316	Durbin-Watson stat	1.325535	
Prob(F-statistic)	0.000000			

Орон сууц худалдан авах чадвар нь өрхийн тэргүүний настай хамааралтай гэдгийг шалган үзэхэд өрхийн тэргүүний насны нөлөө 96 хувьтай байгаа нь төлөөлөх чадвар өндөр байна. Судлаач энэ тэгшитгэлийг тайлбарлавал орлого 1 хувиар өсөхөд 26-35 насны өрхийн тэргүүнтэй гэр бүлийн орон сууц худалдан авалт 2.55 пункт, 36-45 насны өрхийн тэргүүнтэй гэр бүлийн орон сууц худалдан авалт 4.85 пункт, 56-65 насны өрхийн тэргүүнтэй гэр бүл

8.98 пунктээр нэмэгдэх боломжтой байна. Харин 18-25 насны өрхийн тэргүүнтэй гэр бүл 7.33 пунктээр буурахаар бодолтоос харагдаж байна.

Хүснэгт.5

Орон сууц худалдан авалтад ажил эрхлэлт хамааралтай

C. у- орон сууц худалдан авалт, W- ажил эрхлэлт, W1= цалин хөлстэй, W2= Ажил олгогч, W3- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, W4=Нөхөрлөл хоршоонд, W5=мал аж ахуй эрхлэгч, W6= Бусад

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	13.09243	0.204190	64.11883	0.0000
W1	1.41E-05	1.11E-05	1.271600	0.2197
W2	-6.80E-05	8.37E-05	-0.812056	0.4274
W3	0.000109	5.52E-05	1.978898	0.0633
W4	0.000145	0.000526	0.275887	0.7858
W5	-0.000505	0.003597	-0.140487	0.8898
W6	-0.000109	9.76E-05	-1.114628	0.2797
R-squared	0.973905	Mean dependent var		14.80271
Adjusted R-squared	0.965207	S.D. dependent var		0.054139
S.E. of regression	0.010098	Akaike info criterion		-6.121379
Sum squared resid	0.001836	Schwarz criterion		-5.780094
Log likelihood	83.51724	Hannan-Quinn criter.		-6.026721
F-statistic	111.9656	Durbin-Watson stat		1.651211
Prob(F-statistic)	0.000000			

Орон сууц худалдан авах чадвар нь ажил эрхлэлтэй хамааралтай гэдгийг шалган үзэхэд ямар ажил эрхэлж байгаагаас шалтгаалж орон сууц худалдан авдаг гэсэн нөлөө 96 хувьтай байгаа нь төлөөлөх чадвар өндөр байна. Судлаач энэ тэгшитгэлийг тайлбарлавал орлого 1 хувиар өсөхөд цалин хөлсөөр ажилладаг ажиллагч нь орон сууц худалдан авалт 1.4 пунктээр өсөх боломжтой байна. Харин ажил олгогч нь орлого 1 хувиар нэмэгдэхэд 6.8 пунктээр буурах үзүүлэлт гарсан нь ажил олгогчид байр худалдан авах хэрэгцээ байхгүй, орлого өсөх тусам дараагийн хэрэгцээ бизнесээ өргөтгөх тал руугаа явах нь тооцооллоос харагдаж байна. Хувиараа хөдөлмөр,эрхлэгч болон нөхөрлөл хоршоонд ажилладаг хүмүүст орлого нэмэгдсэн ч орон сууц худалдан авах боломжгүй хэвээр байна.

Хүснэгт.6

Орон сууц худалдан авалтад ам бүлийн тооны хамаарал

D. у- орон сууц худалдан авалт, F- ам бүлийн тоо, F1= ганц бие, F2= 2-3 ам бүлтэй, F3- 4-5 ам бүлтэй, F4=6 гаас дээш

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	14.15784	0.182911	77.40307	0.0000
F1	6.21E-06	5.52E-06	1.126364	0.2733
F2	-1.44E-05	6.06E-06	-2.378841	0.0274
F3	3.25E-05	1.35E-05	2.413560	0.0255
F4	-5.82E-06	7.74E-05	-0.075176	0.9408

R-squared	0.986971	Mean dependent var	14.80271
Adjusted R-squared	0.984365	S.D. dependent var	0.054139
S.E. of regression	0.006769	Akaike info criterion	-6.975954
Sum squared resid	0.000916	Schwarz criterion	-6.732179
Log likelihood	92.19943	Hannan-Quinn criter.	-6.908342
F-statistic	378.7664	Durbin-Watson stat	2.111408
Prob(F-statistic)	0.000000		

Орон сууц худалдан авах чадвар нь өрхийн ам бүлийн тоотой хамааралтай гэдгийг шалган үзэхэд ямар ам бүлийн тооноос шалтгаалж өрхийн орон сууц худалдан авах нөлөө 98 хувьтай байгаа нь төлөөлөх чадвар өндөр байна. Судлаач энэ тэгшитгэлийг тайлбарлавал ганц бие өрхийн орлого 1 хувиар өсөхөд орон сууц худалдан авалт 6,2 пункт, 4-5 ам бүлтэй өрх орон сууц худалдан авах чадвар нь 3,2 пунктээр өсөх боломжтой байна. Харин 2-3 ам бүлтэй өрхийн хувьд орлого 1 хувиар нэмэгдэхэд 1.44 пункт, зургаан ам бүлээс дээш гишүүнтэй өрхийн орон сууц худалдан авалт 5.82 пунктээр буурах үзүүлэлт гарсан.

Дүгнэлт

Хэрэглэгчийн зан төлөвийн онол, арга зүй, судлаачдын бүтээл, монгол банкны ипотекийн зээлийн судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Гадаадын эрдэмтэд судалгаагаар хамгийн их давтамжтайгаар гэр бүлийн амьдралын мөчлөг, хүүхдийн тоо, хүүхдийн насны бүлэглэл, сууцны насжилт, хэрэглээ, мөнгөн орлого, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо зэрэг хүчин зүйлүүдийг хэрэглэгчийн орон сууц худалдан авалтад нөлөөлөл нь өндөр байгааг судалгаагаар баталсан байдаг. Энэхүү судалгаанд судлаач Монгол улсын хэрэглэгчийн орон сууц худалдан авалтад хүн ам зүй –эдийн засгийн нөлөөллийг өрхийн орлого, ам бүлийн тоо, ажил эрхлэлт, настай холбон судаллаа.
2. Судалгааны дүнгээс үзэхэд орон сууц худалдан авалтад нас, ам бүлийн тоо, ажил эрхлэлт, орлогын хүчин зүйлүүд нөлөөлж байна. Нөлөөлөх хүчин зүйл нь ялгаатай бөгөөд орон сууц худалдан авалтад орлого, нас, ажил эрхлэлт, ам бүлийн тоо хүчтэй нөлөөтэй байгаа нь судалгаанаас харагдаж байна.
3. Орон сууц худалдан авах чадвар нь орлоготой хамаарлын нөлөөлөх чадвар өндөр байна. Орлого 1 хувиар өсөхөд орон сууц худалдан авалт 5.79 пунктээр өсөх боломжтой байна.

Гэр бүлийн орон сууц худалдан авах боломжийг хүн ам зүйн хүчин зүйлийн нас, ажил эрхлэлт, ам бүлийн тоогоор судлах боломжтойг судалгаагаар нотоллоо.

Ном зүй

1.

Adude, O. O. (2014). The influence of Demographics on Owner-Occupied Housing Decisions; A Case of Apartment Households in Nairobi County, Kenya. http://www.scienpress.com/upload/BEJ/Vol%204_1_2.pdf.

2. Danko, C. M. (March 1993, pp. 580–94). A Conceptual and Empirical Comparison of Alternative Household Life Cycle Models . Journal of Consumer Research.
3. Danko, C. M. (March 1993). A Conceptual and Empirical Comparison of Alternative Household Life Cycle Models. Journal of Consumer Research, 27-42.
4. Koklic, M. K., & Vida, I. (2009). A Strategic Household Purchase Consumer House Buying Behavior. http://www.fm-kp.si/zalozba/ISSN/1581-6311/7_075-096.pdf.
5. Morrow-Jones, H. A. (23 January 1987). ‘The housing life-cycle and transition from renting to owning a home in the United States; multistate analysis. <http://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.465.8932&rep=rep1&type=pdf>.
6. Ombongi, O. j. (2014). Demographics, housing search, asymmetric information and housing decisions amongst apartment households in nairobi county, Kenya. http://erepository.uonbi.ac.ke/bitstream/handle/11295/77983/Omagwa_Demographics,%20housing%20search,%.
7. Philip Kotler, K. L. (2012). Marketing management. Northwestern: 14 ed. page 434.
8. Wilkes, L.-C.-4., & Lee, a. C. (January 2002). A New Full-Nest Classification Approach. Psychology & Marketing.
9. байдал, М. г. (2010 он 28 тал). Өнөөгийн гэр бүлийн бүтэц, хэв маяг. Улаанбаатар.
10. Ган-Очир, Д. (2007 он). Хедоник регрессийг ашиглан орон сууцны үнэнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илэрүүлэх нь: Улаанбаатар хотын жишээн дээр
11. ЗТБХБСайдын. (2010 оны 12-р сарын 23-ны). 418 тоот тушаал.
12. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Ф. с. (2010 он). Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал . Улаанбаатар.
13. Хөтөлбөр, З. г. (2050). Засгийн газрын мөрийн хөтөлбөр.
14. Монгол банкны статистик 2017-2024

The influence of South Korean tourists on the tourism industry of Mongolia

БНСУ-ын жуулчдын Монголын аялал жуулчлалын салбарт үзүүлж буй нөлөө

B.Munguntuul, A.Munkh-Erdene(M.A)
(International University of Ulaanbaatar)

Summary

Based on secondary data such as the number, structure and growth of international and South Korean tourists who traveled to Mongolia from 2013 to 2023, the forecast of the number of tourists coming to Mongolia until 2033 was made using the statistical time series analysis (ARIMA) model. predicted the tourism market demand and attempted to estimate the economic impact of Mongolia's tourism industry.

The results of this study are the future prospects of Mongolia's tourism industry policy, international tourists' appreciation and attitude towards our country, management of tourism organizations and other factors remain current. Research results showed that if the policy, planning and conditions of our country's tourism sector continue, we will be able to receive 2.517.340 tourists a year by 2033.

In addition, based on the results of this research and research data, it is possible to expand the research work such as forecasting the number of tourists in South Korea by each region, determining the perspective, and further calculating the economic benefits and impacts.

Түлхүүр үг: *ARIMA загвар, динамик шинжилгээ, зах зээлийн эрэлт, аялал жуулчлалын нөлөөлөл*

Судалгааны ажлын үндэслэл

1990-ээд онд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа эрчимжиж, төр засгийн зүгээс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тодорхой бодлого баримталж ирсэн. Хэдийгээр “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” болон бодлогын бусад баримт бичгүүдэд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно¹⁵³ хэмээн заасан байдаг ч хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй, үр дүнд суурилсан хянах механизм бүрдээгүй, тус салбарт төсөвлөсөн хөрөнгө оруулалт бага зэрэг шийдвэрлэх олон асуудлууд байсаар байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараагаас аялал жуулчлалын салбарт дахин сэргэлт явагдаж, 2022, 2023 оуудад цар тахлын өмнөх үеийн хэмжээнд олон улсын аялал жуулчлал хүрч байна. 2023 онд Монгол улсын засгийн газраас жуулчдад зориулсан тусгай төлөвлөгөө гаргаж, нийт 69 арга хэмжээ батлуулж, үүнээс 23

¹⁵³ Монгол Улсын Улсын Их Хурал. *Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*. 2008. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолын хавсралт. Улаанбаатар хот.

хөтөлбөрийг дэмжиж ажилласан байна. Тэр дундаа БНХАУ, БНСУ, ОХУ, Япон улсын жуулчдад чиглэсэн тусгайлсан хөтөлбөр гаргаж аялал жуулчлалын эрх зүйн орчныг бүрдүүлэх, Монгол улсыг дэлхийд таниулах гадаад сурталчилгаа, маркетингийн цогц арга хэмжээг хэрэгжүүлсэнээр манай орныг сонирхох жуулчдын тоо, хэрэглэгчдийн хандалт нэмэгдэж байна.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсад 2033 он хүртэл аялах БНСУ-ын жуулчдын тоог хугацаан цувааны загвар /Time series analysis/ буюу ARIMA загвараар тооцон, аялал жуулчлалын зах зээлийн эрэлт, эдийн засагт оруулах нөлөөг таамаглах явдал юм. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж шийдвэрлэнэ. Үүнд:

1. Олон улсын болон Монгол улсад 2013-2023 онуудад аялсан жуулчдын тооны бүтэц, өсөлт зэргийг хоёрдогч мэдээлэл ашиглан судлаж, дүн шинжилгээ хийх
2. Монгол Улсад 2013-2023 онуудад аялсан жуулчдын мэдээллийг ашиглан, хугацаан цувааны шинжилгээ буюу ARIMA загвараар 2025 он хүртлэх жуулчдын тооны прогнозыг хийж, эрэлтийг таамаглах, судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэлт санал боловсруулах зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй

Уг судалгааны ажлыг үндсэн хоёр хэсэгтэйгээр, дараах судалгааны аргуудыг ашиглан хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Олон улсын жуулчдын тооны бүтэц, өсөлтийн судалгаа болон Монгол улсад 2013-2023 онуудад аялсан жуулчдын тооны бүтэц, өсөлтийн динамик шинжилгээг хоёрдогч мэдээллийг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, таамаглах, бүлэглэх, харьцуулах (Жадамба.Ж Чимэдлхам.Ц, 2011) зэрэг нийгмийн шинжлэх ухааны аргуудыг ашиглан гүйцэтгэсэн.
2. Монгол улсад 2033 он хүртэл жуулчлах жуулчдын тооны прогнозыг “өнгөрсөнд ажиглагдсан зүй тогтол ирээдүйд мөн ажиглагдана” гэсэн таамаглалд үндэслэн, статистикийн “Хугацаан цувааны шинжилгээ”-ний арга буюу ARIMA /Autoregressive Integrated Moving Average/ загварыг ашиглан тооцоолж, аялал жуулчлалын зах зээлийн эрэлтийг таамаглаж, дүн шинжилгээ хийсэн.

Оршил

Солонгос жуулчдын онцлог

БНСУ-ын жуулчдын бусад улсын жуулчдаас ялгарах хэд хэдэн онцлог шинж чанар байдаг. Эдгээр нийтлэг шинж чанаруудаас дурдвал:

- *Бүлгээр аялах сонирхол:* Солонгосын жуулчид гэр бүл, найз нөхөд эсвэл зохион байгуулалттай аялалын бүлгүүдтэйгээ хамт бүлгээр аялахыг илүүд үздэг. Бүлгийн аялал нь Солонгосчуудын эв нэгдэл, нийгмийн соёлын үнэт зүйлстэй нийцдэг учраас бүлгээр аялахыг илүүд үздэг.

- *Багцтай аялалыг илүүд үздэг:* Солонгосын олон жуулчид аялал жуулчлалын агентлагуудаас санал болгодог багц аялалыг сонгодог бөгөөд үүнд ихэвчлэн унаа, байр, хоол, хөтөчтэй аялал жуулчлалын үйл ажиллагаа багтдаг. Багцалсан аялал нь аялал жуулчлалын алдартай газруудад, ялангуяа анх удаа аялж буй хүмүүст ая тухтай, боломжийн үнээр хүрэх боломжийг олгодог.
- *Худалдааны сонирхол:* Дэлгүүр хэсэх нь Солонгосын аялал жуулчлалын чухал хэсэг бөгөөд олон солонгос жуулчид алдартай худалдааны дүүрэг, татваргүй дэлгүүр, тансаг дэлгүүрүүдээр дэлгүүр хэсэх боломжийг эрэлхийлдэг. Солонгосын жуулчид аялах үедээ загварын эд зүйлс, гоо сайхны бараа, цахилгаан бараа, бэлэг дурсгалын зүйл худалдан авах дуртай гэдгээрээ алдартай.
- *Хоолны эрэл хайгуул:* Солонгосын жуулчид аялах явцдаа нутгийн хоол, хоолны туршлага судлах дуртай байдаг. Хоолны аялал жуулчлал нь Солонгосын аялагчдын дунд өсөн нэмэгдэж буй чиг хандлага болж, жинхэнэ нутгийн хоол, гудамжны хоолны худалдаачид, хоолны соёлыг шимтэн үздэг.
- *Аялалын төлөвлөлтөд технологи ашигладаг:* Солонгосын жуулчид ерөнхийдөө технологийн мэдлэгтэй байдаг бөгөөд аялал төлөвлөх, навигаци хийх, харилцаа холбоо тогтоох, аяллын туршлагаа хуваалцахдаа дижитал технологи, гар утасны аппликейшн дээр тулгуурладаг. Тэд ухаалаг гар утас, сошиал медиа платформ, аялалын аппликейшн ашиглан очих газраа судалж, байр захиалж, аяллаа бодит цаг хугацаанд нь баримтжуулдаг.
- *Соёлын туршлага солилцох:* Солонгосын жуулчид түүхэн дурсгалт газрууд, музей, урлагийн галерей, уламжлалт үзүүлбэр зэрэг соёлын туршлага, өвийн үзмэрүүдийг үнэлдэг. Тэд ихэвчлэн очсон газруудынхаа түүх, урлаг, уламжлалыг сонирхож, соёлтой танилцах боломжийг идэвхтэй эрэлхийлдэг.
- *Аюулгүй байдлыг эрхэмлэдэг:* Солонгосын жуулчид аялалаа төлөвлөхдөө, ялангуяа танил бус эсвэл гадаад орнуудад зочлохдоо аюулгүй байдлыг эрхэмлэдэг. Тэд гэмт хэргийн гаралт бага, найдвартай тээврийн систем, аялал жуулчлалын дэд бүтэц сайн хөгжсөн газруудыг илүү үнэлдэг.
- *Гэр бүлд чиглэсэн:* Солонгосын жуулчдын дунд гэр бүлийн аялал түгээмэл бөгөөд эцэг эх, хүүхдүүд, гэр бүлийн гишүүдийг хамарсан аялал байдаг. Хүүхэд эсвэл өндөр настай хамаатан садантайгаа аялахдаа гэр бүлд ээлтэй газрууд, байр, үйл ажиллагаануудыг тэд илүүд үздэг.
- *Гэрэл зураг ба селфи:* Солонгосын жуулчид гэрэл зураг, селфи ашиглан аялсан дурсамжаа үлдээх дуртай. Тэд Instagram, Facebook, KakaoTalk зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрийн туршлагаа баримтжуулж, дижитал бэлэг дурсгалын зүйлс бүтээж, бусдыг аялах сэдэл төрүүлэх мэдээлэл түгээдэг.

Эдгээр шинж чанаруудыг ойлгох нь аялал жуулчлалын салбарын оролцогч талууд болон жуулчдад бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетингийн стратегиа солонгос жуулчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн тохируулахад тусалж, улмаар тэдний аяллын ерөнхий туршлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

Монгол Улсад аялал жуулчлалын салбар тасралтгүй хөгжиж, олон улсын зах зээлд санал болгож буй бүтээгдэхүүнээ сурталчлахын хэрээр ирэх жилүүдэд Солонгосын жуулчдын тоо улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн БНСУ, Монгол хоёр улсын хооронд шууд нислэгтэй, визийн хөнгөлөлттэй нөхцөлтэй болсон нь Солонгосын жуулчдад илүү хүртээмжтэй, ая тухтай аялах боломжтой болсон.

Үндсэн хэсэг

Олон улсын авто замын болон төмөр замын тээврийн хөгжилтэй холбоотойгоор 1930-аад оноос Европын улс орнуудад жуулчлах хүмүүсийн тоо нэмэгдсэнээр, аялал жуулчлал тухайн үеийн нийгмийн онцгой үйл явдал болж байгааг судлаачид анзаарч эхэлжээ. Энэ үеэс уг үйл явцыг шинжлэх ухааны зүгээс тайлбарлах оролдлогууд хийгдэж эхэлсэн нь аялал жуулчлал судлал (tourismlogy) үүсэх эхлэлийг тавьжээ. (*Dann, Nash, Pearce, 1988*). Аялал жуулчлал бол бусад шинжлэх ухааны салбаруудтай харьцуулбал харьцангуй залуу шинжлэх ухаан гэж үздэг¹⁵⁴. Энэ утгаараа аялал жуулчлал судлалын үндсэн үзэл баримтлалууд нь одоог болтол судлагдаж, судалгааны түвшинд олон ажлууд хийгдсээр байна. 1970-аад оноос нийгмийн шинжлэх ухаанд аялал жуулчлалын салбарын асуудлуудыг илүү өргөн хүрээг хамран системтэйгээр судлах болсон байна. (*Dann, G, Nash, D, Pearce, P, 1988*)

Аялал жуулчлалын эрэлтийг таамаглах чанарын болон тоон олон аргууд байдаг. Гэхдээ ямар аргыг ашиглаж байгаагаас үл хамааран аялал жуулчлалын эрэлтийн таамаглалын хэрэгцээтэй байдал нь бодит жуулчдын урсгалын хэмжээнээс хамаарч тодорхойлогддог. *Frechtling, D. C* (1996) аялал жуулчлалын эрэлтийг таамаглах хугацаан цуваан таван хэв маяг байдаг гэж үзсэн. Хугацаан цувааны энгийн бус арга буюу нэг хувьсагчтай таамаглалын арга нь хувьсагч дутмаг байдаг учир богино болон дунд хугацааны таамаглалд хамгийн тохиромжтой байдаг. Нэг хувьсагчаар эрэлтийг таамаглах үндсэн аргуудад Holt-Winters, ARIMA, SARIMA загварууд, олон хувьсагчаар таамаглах аргад VAR, GMM, ARCH GARCH гэх мэт загваруудыг ашигладаг.

Аялал жуулчлалын эрэлтийн таамаглалын талаарх дэлгэрэнгүй судалгааг *Song, H and Li, G* нар танилцуулж байсан бөгөөд 2000 оноос хойш хэвлэгдсэн аялал жуулчлалын эрэлтийн загвар болон таамаглалын талаарх нийт 121 дотоодын болон олон улсын судалгааны ажлуудыг нэгтгэн дүгнэлт хийсэн юм. Нийт судалгааны 72 нь аялал жуулчлалын эрэлтийн загварыг хугацаан цувааны аргыг ашиглан тодорхойлсон байсан бөгөөд 30-аас дээш тооны судалгаа нь эконометрикс болон хугацаан цувааны аргыг нэгтгэн аялал жуулчлалын эрэлтийн загварыг тодорхойлжээ. Ихэнх судалгаанууд улиралын чанартай чиг хандлагууд болон хэв маягуудад онцгой анхаарал хандуулсан бөгөөд эдгээр чиг хандлагууд дээр тулгуурлан хугацаан цувааны ирээдүйн үнэ цэнийг урьдчилан тооцоолохыг зорьсон. *Burger, S. J. S* (2001) зарим судлаачдын хамтаар аялал жуулчлалын бүтцийн загваруудыг тодорхойлоход мэдээлэл хомс судлаачдад зориулж, таамаглалын загварыг тодорхойлох заавар зөвлөмжийг боловсруулсан бөгөөд үүнд регрессийн арга, генетик регрессийн арга, naive method, moving average, ARIMA гэх мэт загваруудыг дурьджээ. *Diviskera* (2003) нь хэрэглэгчийн сонголт хийх онол дээр тулгуурлан олон улсын аялал жуулчлалын эрэлтийн

¹⁵⁴ Навчаа, Т (2009), "Аялал жуулчлал судлал", Улаанбаатар хот.

загварыг боловсруулсан бөгөөд энэ нь жуулчдын сонголт олон янз (preference) байдаг гэдгийг онцлон тодорхойлсон. *Baldigara (2013)* нь олон улсын аялал жуулчлалын эрэлтийг таамаглах хугацаан цувааны таван хэв маягийг харьцуулан судалсан байдаг.¹⁵⁵ Харин гадаадын жуулчдын тухайн улсад үзүүлэх нөлөөг эдийн засаг, нийгэм, байгаль орчны янз бүрийн үзүүлэлтүүдийг ашиглан тооцдог. Гадаадын жуулчдын нөлөөллийг хэмжихэд ашигладаг зарим нийтлэг арга, хэмжүүрүүдэд:

Эдийн засгийн нөлөөлөл: Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ нь гадаадын жуулчдын улс орны эдийн засагт оруулах хувь нэмрийг тоон байдлаар тодорхойлох зорилготой. Эдийн засгийн гол үзүүлэлтүүд нь:

- Аялал жуулчлалын зардал: Гадаадын жуулчдын орон нутаг, хоол, унаа, худалдаа, үзвэр үйлчилгээ болон аялал жуулчлалтай холбоотой бусад үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардал.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д оруулах хувь нэмэр: Аялал жуулчлалын улсын ДНБ-д оруулах шууд, шууд бус оруулсан хувь нэмэр. Шууд хувь нэмэр нь жуулчдын зарцуулалтыг багтаадаг бол шууд бус хувь нэмэр нь аялал жуулчлалтай холбоотой салбаруудын эдийн засгийн бусад салбаруудад үзүүлэх үр нөлөөг илэрхийлдэг.
- Ажил эрхлэлтийг бий болгох: Аялал жуулчлалын салбараас шууд болон шууд бус байдлаар бий болгосон ажлын байрны тоо, үүнд зочид буудал, зоогийн газар, тээвэр, тур оператор, жижиглэнгийн худалдааны дэлгүүр болон аялал жуулчлалтай холбоотой бусад салбарт бий болсон ажлын байрны тоо.
- Татварын орлого: Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), борлуулалтын албан татвар, зочид буудлын татвар, нисэх онгоцны буудлын хураамж болон жуулчид, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд ногдуулах бусад татвар хураамж зэрэг нь аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаанаас бүрдсэн татварын орлого болно.

Олон улсын жуулчдын тооны динамик шинжилгээ, цаашдын чиг хандлага

Өдгөө зах зээлийн хүрээгээрээ дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэлийн нэгд зүй ёсоор тооцогдож буй¹⁵⁶ аялал жуулчлалын салбарт, дэлхийн 7 хүн тутмын нэг хэрэглэгч нь болж, тэдгээрт үйлчлэхээр 11 хүн тутмын нэг нь ажиллаж, 560 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж, нийт худалдаа эргэлтийн 12 хувийг дангаараа бий болгож, дотоодын нийт бүтээгдэхүүний 11 хувийг бүрдүүлж байна.¹⁵⁷

Олон улсын аялал жуулчлал сүүлийн 50 жилд 30 дахин өссөн бөгөөд өнгөрсөн жилд 1,186 тэрбум хүн жуулчилж, 2022 оноос 4,6% өссөн дүнтэй байна. Одоогоор дэлхийн хэмжээнд аялал жуулчлалд 653 тэрбум ам доллар зарцуулж байгаа ба 2025 он гэхэд өдөрт 5 тэрбум ам доллар зарцуулж, дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 12 хувийг тус салбар бүрдүүлэх төлөвтэй байна.

¹⁵⁵ Julian Condratov, Pavel Stancu. (2012). The using of ARIMA models for forecasting the supply and demand indicators from tourism sector. *The USV annals of Economic and Public Administration. Vol12., Issue 2(16)*

¹⁵⁶ World Trade Organization "World Trade Statistical Review 2016"

¹⁵⁷ UNWTO, Tourism Highlight 2022

ДАЖБ-аас аялал жуулчлалын цаашдын чиг хандлагад нийгэм, улс төр, эдийн засаг, хүрээлэн буй орчин, техник технологийн хүчин зүйлсийн нөлөөлөх нөлөөллийг тооцон, олон улсын жуулчдын тооны өсөлтийг 2030 он хүртэл бүс нутаг тус бүрээр гаргасан.


Хүснэгт 1. Олон улсын жуулчдын тооны 2030 он хүртэлх таамаглал

Бүс нутаг	Жуулчдын тоо (сая жуулчин)					Жилийн дундаж өсөлт(%)				
	Бодит тоо		Таамаглал			Бодит тоо		Таамаглал		
	1980	1995	2010	2020	2030	1980-1995	1995-2010	2010-2020	2020-2030	
Дэлхий	277	528	940	1360	1809	4.4	3.9	3.3	3.8	2.9
Хөгжингүй орнууд	194	334	498	643	772	3.7	2.7	2.2	2.6	1.8
Хөгжиж буй орнууд	83	193	442	717	1037	5.8	5.7	4.4	4.9	3.8
ДАЖБ-ын ангилалаар										
Африк	7.2	18.9	50.3	85	134	6.7	6.7	5	5.4	4.6
Америк	62.3	109	149.7	199	248	3.8	2.1	2.6	2.9	2.2
Ази Номхон далай	22.8	82	204	355	535	8.9	6.3	4.9	.7	4.2
Европ	177.3	304.1	475.3	620	744	3.7	3	2.3	2.7	1.8
Ойрхи Дорнод	7.1	13.7	60.9	101	149	4.5	10.5	4.6	5.2	4

Эх сурвалж: UNWTO, Tourism Highlights 2018 edition.

Олон улсын аялал жуулчлалын бүс нутгийн 2030 он хүртэлх зах зээлд эзлэх хувийн таамаглалыг 2015 онтой харьцуулан харуулбал дараах байдалтай байна.


Зураг 1. Олон улсын жуулчдын тооны харьцуулалт /Бүс нутгаар, хувиар/



Эх сурвалж: UNWTO, Tourism Highlights 2016 edition.

Дээрх судалгаанаас олон улсын аялал жуулчлалын чиг хандлага буюу жуулчдын эрэлт хэрхэн өөрчлөгдөж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, Европын бүс нутаг зорин ирэх жуулчдын тоогоор тэргүүлсэн хэвээр байх боловч 2020-2030 оны хугацаанд жилийн дундаж өсөлт нь 1.8% болж буурах хандлагатай байна. Харин Ази Номхон далайн бүс нутгийг зорих жуулчдын тооны өсөлт болон жилийн дундаж өсөлтийн хувь 4.2% болж, зах зээлд эзлэх хувь 30% болохоор байна. Энэ нь аялал жуулчлалын Зүүн Азийн дэд бүс нутагт хамаарах манай улсын хувьд тааламжтай нөхцөл болох юм.

Зураг 2. Олон улсын аялал жуулчлалын өсөлт /2015, 2030 он, хувиар/



Эх сурвалж: UNWTO, *Tourism Highlights 2016 edition*.

ДАЖБ-ын гаргасан “UNWTO World tourism barometer-2022” судалгаанаас үзвэл 2030 онд Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн жуулчны тооны өсөлт, дэлхийн дунджаас 2 дахин их байна.

Түүнчлэн дэлхийн аялал жуулчлалын хөгжилд гарч буй томоохон өөрчлөлтүүд, нийгмийн дэвшил, иргэдийн амьдралын хэв маягийн өөрчлөлт зэргээс шалтгаалан, жуулчдын хэрэгцээ, хандлагад өөрчлөлт гарч, уламжлалт зах зээлээс алслагдсан, тусгай сонирхолын зах зээл буюу нээгдээгүй газар оронд очих гэсэн хүсэл, хэрэгцээ нь манай орныг зорих жуулчдын тоонд эерэгээр нөлөөлөх боломжтой байна.

Монгол улсад аялсан жуулчдын тооны динамик шинжилгээ

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн цаг үеэс эхлэн манай улсыг сонирхох гадаадын жуулчдын тоо нэмэгдэж, тус салбарын статистик тоон мэдээллийг бүртгэж эхлэх болсон. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2010 онд батлан гаргасан “Аялал жуулчлалын статистик тооцох аргачлал”-ын дагуу Хил Хамгаалах Ерөнхий газраас амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил хэргийн шугамаар хил нэвтрэн орж буй гадаадын иргэдийг жуулчин гэсэн ангилалд бүртгэж тоог нэгтгэн гаргадаг.

2023 оны 12-р байдлаар Монгол Улсын хилээр 651231 гадаадын иргэн нэвтэрсэнээс 594013 иргэн аялал жуулчлалын зорилгоор ирж, тэдгээрийг жуулчин гэсэн ангилалд бүртгэсэн байна.¹⁵⁸

Зураг 3. Монгол Улсад ирсэн жуулчдын тоо /2013-2023 оноор, мянган хүнээр/


¹⁵⁸ <http://1212.mn/statHtml/statHtml.do>



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

Монгол улсад ирж байгаа жуулчдын жагсаалтын эхний байранд Азиас ирж байгаа жуулчдын тоо орж байгаа боловч, амралтын зориулалт бүхий аялал жуулчлалаас орж байгаа орлогын хувьд хамгийн чухал зах зээл нь Европ байна. Европын орнуудаас /тухайлбал Герман, Франц, Англи, Нидерланд, Итали, Швед/ ирж байгаа жуулчид нийт жуулчдийн зургаа орчим хувийг эзлэж, Хойд Америкийн /АНУ, Канад/ жуулчид гурав орчим хувийг, Австралиас ирж байгаа жуулчид нэг хувийг эзлэж байна.

Зураг 4. 2023 онд Монгол Улсад ирсэн жуулчдын тоо /Голлох орноор, хувиар/



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монголд ирэх Солонгосын жуулчдын тоо тогтмол нэмэгдэж, жилийн дундаж өсөлт 10 орчим хувьтай байна. БНСУ-ын жуулчдын Монголд ирэх тоо жил ирэх тусам тасралтгүй нэмэгдэж байгаа нь Өмнөд Солонгосын иргэдийн аялал жуулчлалын төрөл бүрийн газруудаар аялах сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна. Солонгосын жуулчдын сонирхлыг татахад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

- Түүх соёлын их өв: Монгол улс Солонгосын жуулчдад өвөрмөц соёл, түүхийн туршлагыг санал болгодог. Нүүдэлчдийн баялаг өв уламжлал, буддын шашны сүм

хийдүүд, уламжлалт амьдралын хэв маяг нь соёлын жинхэнэ туршлага олж авахыг эрэлхийлж буй солонгос жуулчдад их нийцдэг.

- *Адал явдалт аялал жуулчлал:* Монголын өргөн уудам, онгон дагшин байгалийн үзэсгэлэнт газрууд, тэр дундаа говь, тал хээр, уулс, нүүдэлчдийн суурьшлын бүсүүд нь адал явдал эрэлхийлэгч Солонгосын жуулчдыг татдаг. Морь унах, тэмээгээр зугаалах, явган аялал хийх, кемп хийх зэрэг үйл ажиллагаа нь адал явдал хайж буй хүмүүсийн сонирхлыг татдаг.
- *Нүүдэлчдийн амьдралын хэв маяг, уламжлалт гар урлал:* Солонгосын жуулчид Монголын нүүдэлчин ахуй соёл, уламжлалт гар урлал, гар урлалын бүтээгдэхүүнүүдийг сонирхдог. Тэд нүүдэлчин айлд зочлох, тэдний ахуй амьдралтай нь танилцах, ноолууран бүтээгдэхүүн, эсгий эдлэл зэрэг гар урлалын бүтээгдэхүүн худалдан авах зэрэг нь түгээмэл байдаг.
- *Түүхэн дурсгалт газрууд, археологийн олдворууд:* Монголын түүхэн дурсгалт газрууд, археологийн олдворууд, тэр дундаа эртний хотууд, оршуулгын газар, хадны сүг зураг зэрэг нь түүх, археологи сонирхдог Солонгос жуулчдыг татдаг.
- *Соёлын солилцоо, наадам:* Соёлын солилцоо, уламжлалт баяр наадамд оролцох нь Солонгосын жуулчдад Монголын соёлыг шимтэн үзэх боломжийг олгодог. Баяр наадам, цагаан сар, бүргэдийн баяр зэрэг арга хэмжээнүүд Өмнөд Солонгосоос ирсэн жуулчдын сонирхолыг ихээхэн татдаг.
- *Зэрлэг амьтан ба байгаль хамгаалах:* Монгол орны олон янзын экосистем нь зэрлэг ан амьтдыг хамгаалах, байгалийн гэрэл зураг авах сонирхолтой Солонгосын жуулчдыг Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн дархан цаазат газруудаар аялах сонирхолыг нэмэгдүүлдэг.
- *Гэрэл зураг, зураг авалтын боломжууд:* Монголын үзэсгэлэнт газар нутаг, нүүдэлчдийн соёл, байгалийн өвөрмөц онцлог нь гэрэл зураг, зураг авалтад маш сайхан боломжийг олгодог. Гэрэл зураг, кино урлаг сонирхдог Солонгосын жуулчид Монголын байгалийн сайхныг гэрэл зургийн хальснаа буулгахыг зорьдог.

Ерөнхийдөө Монголын байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын өв, нүүдлийн соёл, Монголчуудын зан заншил, ахуй соёлын элементүүд нь адал явдалт, өвөрмөц, мартагдашгүй аялалыг эрэлхийлдэг Солонгосын жуулчдын сонирхлыг татахуйц газар болгож байна.

Зураг 5. Монгол Улсад ирсэн БНСУ-ын жуулчдын тоо /2013-2023 оноор, мянган хүнээр/



Монголыг зорин ирэх жуулчдын тоог хугацаан цувааны загвар /Time series analysis/ буюу ARIMA загвараар тооцож, эрэлтийг таамаглах нь

Монгол улсад 2013-2023 оны хооронд аялсан жуулчдын мэдээллийг ашиглан 2033 он хүртлэх ирээдүйн прогнозыг хийхдээ “Өнгөрсөнд ажиглагдсан зүй тогтол, ирээдүйд мөн ажиглагдана” гэсэн таамаглал дээр үндэслэн, статистикийн хугацаан цувааны шинжилгээний арга буюу /Time series analysis/ ARIMA загварыг ашиглалаа. Уг аргыг ашиглан гарах жуулчдын тооны прогноз нь 2013-2023 он хүртлэх Монгол улсын аялал жуулчлалын салбарын бодлого, олон улсын жуулчдын манай улсыг үнэлэх үнэлэмж болон хандлага, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын менежмент болон бусад хүчин зүйлс одоогийн хэвээр байх тохиолдол дахь ирээдүйн төлөв гэсэн үг юм.

ARIMA /Autoregressive Integrated Moving Average-Авторегрессийн ба шилжих дунджийн интегралчлагдсан процесс/ загварыг судлаач *G.M.Jenkins, G.P.Box* нар 1978 онд “Time series analysis” буюу “Хугацааны цувааны шинжилгээ: Прогноз ба хяналт” гэсэн бүтээлдээ анх нийтэлсэнээс хэрэглэх болсон бөгөөд энэ арга нь хугацааны цувааны магадлалт буюу стохастик шинжид тулгуурладаг арга юм. (Singh, 2013)

Уг загварыг цуваа стационар буюу тогтвортой шинжтэй үед хэрэглэдэг бөгөөд ялгаварт операторуудын тусламжтайгаар хугацааны стационар биш цувааг стационар цуваанд шилжүүлдэг.

Манай улсад 2013-2023 оны хооронд дэлхийн 96 орноос давхардсан тоогоор 8303530 жуулчин ирсэн бөгөөд эдгээр жуулчдыг бүс нутаг болон нийт жуулчдад эзлэх хувийн жинг харгалзан дараах бүлэгт хуваан динамик шинжилгээг хийв.

Хүснэгт 2. Жуулчдын тооны тодорхойлогч статистикууд

Улс	Судалгаанд ашиглах нэр	Программын нэр
БНХАУ	БНХАУ	RG1
ОХУ	ОХУ	RG2
БНСУ	БНСУ	RG3
Япон	Япон	RG4
АНУ, Австрали, Шинэ Зеланд	АНУ, Австрали	RG5
Европын бүс нутгийн улсууд	Европ	RG6
Бусад	Бусад	RG7
Дээрх бүх орнууд	Нийт	TOTAL

Дээрх 8 голлох орноор жуулчдын тооны тодорхойлогч статистикуудыг (Julian Condratov, Pavel Stancui, 2012) авч үзвэл дараах байдалтай тодорхойлогдож байна.

Хүснэгт 3. Жуулчдын тооны тодорхойлогч статистикууд

Статистик	RG1 БНХАУ	RG2 ОХУ	RG3 БНСУ	RG4 Япон	RG5 АНУ, Австрали	RG6 Европ	RG7 Бусад	TOTAL
Дундаж	126807.19	67918.00	24418.24	12969.43	12874.81	35610.19	7357.95	287955.81
Медиан	139283.00	66415.00	26602.00	12952.00	10316.00	37604.00	6564.00	298482.00
Хамгийн их утга	243468.00	121547.00	45476.00	18282.00	23.882.00	81671.00	18026.00	475917.00

Хамгийн бага утга	30478.00	8502.00	911.00	5725.00	4604.00	8996.00	3085.00	70217.00
Стандарт хазайлт	68829.53	30505.47	18112.30	3438.62	6439.01	22875.98	3475.38	142882.43
Тэгш хэмийн коэф	-0.01	-0.23	-0.06	-0.17	0.30	0.54	1.54	-0.10
Шовойлтын коэф	1.52	2.66	1.25	2.38	1.56	2.22	5.45	1.45
Jarque-Bera-ийн стаг утга	1.91	0.28	2.70	0.43	2.13	1.57	13.56	2.14
Jarque-Bera-ийн магадлалт утга	0.39	0.87	0.26	0.81	0.34	0.46	0.00	0.34

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

Жуулчдын тооны статистикийг тооцсон дараа дээрх 8 хугацаан цувааг тогтвортой (стационар) эсэхийг шинжилнэ. Цуваа тогтвортой эсэхийг ADF (Augmented Dickey Fuller test) тестээр шинжилнэ.

Хүснэгт 4. ADF тестийн магадлалын утга

Хугацаан цуваа	Түвшин, тогтмол гишүүн	Түвшин, тогтмол гишүүн	Нэгдүгээр эрэмбийн ялгавар эрэмбийн гишүүнтэй тогтмол
RG1	0.6052	0.7263	0.0017**
RG2	0.5714	0.0273**	-
RG3	0.8473	0.9000	0.0592*
RG4	0.2061	0.0356**	-
RG5	0.5247	0.9652	0.0315**
RG6	0.9951	0.0299**	-
RG7	0.1596	0.0544*	-
TOTAL	0.7362	0.7453	0.0031**

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

Энд *-90%-ийн итгэх түвшинд цуваа тогтвортой, **-95%-ийн итгэх түвшинд тогтвортой хэмээн ойлгоно. Цувааны тогтвортой эсэхийг шинжилсэн ADF тестийн үр дүнгээс харвал, RG5 буюу АНУ болон Австрали, RG1 буюу БНХАУ, RG2 буюу БНСУ, TOTAL буюу нийт гэсэн цувааны хувьд ялгавар авах замаар тогтвортой болж байгаа учраас эдгээр цувааг хугацаан цуваагаар загварчлахад хоцролтын утга нөлөөлөх боломжгүй. Мөн эдгээр цувааны хувьд автокорреляци байхгүй байна. Иймээс эдгээрийн хувьд хугацаанаас хамаарсан тренд байх боломжтой.

Үлдсэн 4 цувааны хувьд түвшин дээрээ тогтвортой трендтэй байгаа учраас тренд болон хоцролтын утгуудаас хамааран загварчлагдах боломжтой.

Дээрх шинжилгээнд үндэслэн цуваа тус бүрийг тохирох тэгшитгэлээр загварчилж, үлдэгдлийн болон прогнозын графикийг гаргаж болох боловч, судалгааны зорилгод нийцүүлэн TOTAL буюу нийт жуулчдын гэсэн цувааг загварчлая.

TOTAL буюу нийт жуулчдын цувааны хувьд тогтвортой биш бөгөөд ач холбогдол бүхий автокоррелиаци буюу хамаарал ажиглагдаагүй тул дараах шугаман трендтэй тэгшитгэл хамгийн сайн тайлбарлах чадвартай байна.

$$total_t = 73262.24 + 21469.26t + \varepsilon_t$$

Хүснэгт 5. Цувааны үнэлэгдсэн тэгшитгэл

	Коэффициент	Стандарт алдаа	t-статистик	Магадлалын утга
<i>Const</i>	73263.24	22333.10	3.28	0.0039
<i>T</i>	21469.26	1910.37	11.24	0.0000
<i>R</i> ²	0.86			24.68

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

Эндээс TOTAL цувааны буюу нийт жуулчдын тоог 2033 он хүртэл тооцоолбол дараах байдалтай байна.

Хүснэгт 6. TOTAL цувааны үнэлэгдсэн тэгшитгэлийн үр дүн

Хугацаа	Жуулчдын тоо
2024	723.841
2025	812.477
2026	911.214
2027	1.012.345
2028	1.321.466
2029	1.577.256
2030	1.789.544
2031	1.980.203
2032	2.374.111
2033	2.517.340

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

Дээрх тооцооллоор 2033 он гэхэд манай улс жилд 2.517.340 жуулчин хүлээн авах төлөв ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, одоогийн байгаа байдлаас 4 дахин их жуулчин хүлээн авах тооцоолол нь "...2025 он гэхэд жуулчдын тоог 2 саяд хүргэнэ" гэсэн "Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилт хэрэгжих боломжгүйг харуулж байна.

Аялал жуулчлалын зах зээлийн эрэлтийг таамаглахдаа боломжит зах зээл (potencial market) буюу манай улсын аялалын бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах чадвар бүхий жуулчдын тоогоор авч үзсэн. 2019 онд "Монгол Банк", "Аялал Жуулчлалын Үндэсний Төв"-тэй хамтран хийсэн "Монгол Улсад аялаж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа"-аас үзэхэд, нийт жуулчдын 79 хувь захиалгат багц жуулчлалаар, 21 хувь нь хувиараа буюу бие даан аялдаг байна. Мөн жуулчид аялалын нийт зардлынхаа 74 хувийг бэлэн мөнгөөр, 26 хувийг төлбөрийн картаар гүйцэтгэдэг ажээ. Жуулчдын хувьд ирсэн улс орноосоо хамаарч зардлууд нь харилцан ялгаатай байгаа бөгөөд дунджаар 7-10 хоногт 2174 ам. доллар зарцуулж байгаа нь мөн судалгааны дүнгээр тодорхойлогджээ.

Монгол улсын аялал жуулчлалын салбарын орлогыг хоёр үндсэн аргачлалаар тооцдог. Нэгдүгээр аргачлал болох хуучнаар "Үндэсний статистикийн газар"-ын аргачлал. Уг аргачлалаар аялал жуулчлалын салбарын орлогыг тооцохдоо улсын бүртгэлд бүртгэлтэй холбогдох байгууллагуудад тайлан тооцоогоо тогтмол ирүүлдэг тур оператор, тур агентын нэмэгдэл өртгөөр тодорхойлдог. Гэвч энэхүү аргачлал нь бодит байдлаас нилээд зөрүүтэй тооцоолдог тул Дэд бүтцийн сайдын 2002 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 55 тоот

тушаалын хавсралтаар баталсан "Аялал жуулчлалын салбарын орлого тооцоолох аргачлал"-аар тооцоолж байна.

Энэхүү аргачлалаар тооцохдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлал хийж буй жуулчдын тоог аялалд зарцуулсан дундаж хугацаа, хоногт зарцуулсан мөнгөний дундаж хэмжээний үржвэрийн нийлбэр дүнгээр тооцдог байна.

Дээрх аргачлалаар 2025 он хүртлэх жуулчдаас олох орлогыг тооцвол:

Хүснэгт 7. 2025 он хүртлэх жуулчдаас олох орлого/ ам доллар/

Хугацаа	Жуулчдын тоо	Жуулчдаас олох орлого
2024	723.841	1,573,630.33
2025	812.477	1,766,325.00
2026	911.214	1,980,979.24
2027	1.012.345	2,200,838.03
2028	1.321.466	2,872,867.08
2029	1.577.256	3,428,954.54
2030	1.789.544	3,890,468.66
2031	1.980.203	4,304,961.32
2032	2.374.111	5,161,317.31
2033	2.517.340	5,472,618.90

Дээрх аргачлалаар тооцсон тус салбарын орлого харьцангуй нэмэгдсэн тооцоо гэж үзэж болох талтай. Учир нь уг тооцоонд ашигладаг жуулчдын тоо нь Хил Хамгаалах Ерөнхий Газарт бүртгэгдсэн гадаадын иргэдийн нийт тоо байдаг тул аялал жуулчлалын бус чиглэлээр ирсэн иргэдийн зарцуулсан мөнгө давхар тооцогдох магадлалтай. Түүнчлэн аялал жуулчлалын салбарын статистик, үүн дотроо бодит жуулчдын тоо, аялал жуулчлалаас олох орлого, ДНБ-д эзлэх хувь зэргийг засгийн газар болон салбарын эх сурвалжуудад янз бүрээр зөрүүтэй тусгасан байдаг нь аялал жуулчлалын салбараас эдийн засагт оруулж буй бодит хувь нэмрийг зөв тооцоолох, эрэлтийг таамаглах, зардал өгөөжийг тооцоолох, эдийн засгийн нөлөөллийг зөв тооцоход хүндрэлтэй, тооцсон ч бодит байдлаас зөрүүтэй мэдээлэл гарах магадлалтай байна. Үүний тулд бодит жуулчдын тоог нэмэгдүүлэх, "Бадарчин жуулчин" буюу хувиараа аялах жуулчдын тоог хязгаарлах, аялал жуулчлалын 10 багц үзүүлэлтийг тооцдог олон улсын бүртгэлийн системийг /TSA буюу Tourism Satellite Account бүртгэлийн нэгдсэн систем/ нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Дүгнэлт, санал

Энэхүү судалгааны ажлаар олон улсын болон Монгол улсад 2013-2023 онуудад аялсан жуулчдын тооны бүтэц, жуулчлах шалтгаан, өсөлтийн харьцаа зэргийг судлан, дүн шинжилгээ хийж, хугацаан цувааны шинжилгээ буюу ARIMA загвараар 2025 он хүртлэх жуулчдын тооны прогнозыг гаргаж, аялал жуулчлалын зах зээлийн эрэлтийг таамаглалаа. Судалгааны үр дүнгээр дараах үндсэн дүгнэлт гарсан. Үүнд:

- Олон улсын хэмжээнд хүн амын өсөлт, хөгжиж буй орнуудын жуулчлах боломжтой дундаж давхрагын хүн амын өсөлт, техник технологийн хөгжлийн хурдац, визийн нөхцөл шаардлагуудын уян хатан байдал зэргээс олон хүчин зүйлсээс шалтгаалж жуулчдын тоо өсөх хандлагатай байхыг ДАЖБ болон бусад холбогдох байгууллагуудын

судалгаа харуулж байна. Ялангуяа Ази, Номхон далайн бүс нутгийн жуулчдын тооны өсөлт дэлхийн дунджаас 2 дахин их байна гэсэн таамаглал нь аялал жуулчлалын тусгай сонирхолын зорин очих газарт хамаарах манай улсын хувьд таатай боломж гэдэг нь харагдаж байна.

- Олон улсын аялал жуулчлалын тооны өсөлтийн прогнозоор 2030 он гэхэд БНХАУ хүлээн авах, илгээх жуулчны тоогоор дэлхийд тэргүүлж, 2050 он гэхэд БНСУ хоёрдугаар байранд орох төлөвтэй байгааг харгалзан газар нутгийн хувьд дөт, шууд нислэгтэй, зах зээлд нь тодорхой хэмжээгээр танигдсан зэрэг давуу талаа ашиглах, тэдгээр зах зээлийн жуулчдыг татах бодлого баримтлах зэрэг болно.
- Монгол улсын аялал жуулчлалын салбарын бодлого, олон улсын жуулчдын манай улсыг үнэлэх үнэлэмж болон хандлага, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын менежмент болон бусад хүчин зүйлс одоогийн хэвээр байх тохиолдолд 2033 гэхэд 2517.340 жуулчин ирэх тооцоо гарсан нь “Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”-т заасан 2025 он гэхэд жуулчдын тоог 2 саяд хүргэнэ гэх зорилт биелэх боломжгүйг харуулж байна.

Монголд ирэх Солонгос жуулчдын тоог нэмэгдүүлэхийн тулд зорилтот маркетингийн стратеги хэрэгжүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, солонгос жуулчдын сонирхлыг татахуйц өвөрмөц туршлага бий болгох нь чухал юм. Үүнд:

- Сурталчилгааны кампанит ажил: Монголыг аялал жуулчлалын газар гэж таниулах зорилгоор Өмнөд Солонгост зорилтот маркетингийн кампанит ажил эхлүүлэх. Дижитал маркетингийн сувгууд, сошиал медиа платформууд, аялал жуулчлалын нөлөөлөгчдийг ашиглан Монголын өвөрмөц газрууд, соёлын туршлага, адал явдалт боломжуудыг солонгос аялагчдад харуулах.
- Соёлын солилцоо: Монгол, Өмнөд Солонгосын соёлын солилцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, бие биенийхээ соёлыг харилцан ойлголцох, сонирхоход дэмжлэг үзүүлэх. Монголын язгуур урлаг, хөгжим, хоол, ахуй амьдралын хэв маягийг харуулсан соёлын арга хэмжээ, наадам, үзэсгэлэн, солилцооны хөтөлбөрүүдийг зохион байгуулах.
- Аялал жуулчлалын багц: Солонгосын жуулчдын сонирхол, сонирхолд нийцсэн тусгай аялалын багцуудыг боловсруулах. Монгол орны байгалийн үзэсгэлэнт газар, нүүдэлчдийн өв уламжлал, өвөрмөц соёлын уламжлалыг харуулсан адал явдалт аялал, соёлтой танилцах, эко аялал жуулчлалын санаачлага, гэрэл зургийн үзэсгэлэнг санал болгох.
- Агаарын холболт: Шууд нислэг, нэмэлт чиглэл, сурталчилгааны нислэгийн тийзийг санал болгох замаар Өмнөд Солонгос, Монгол хоёрын агаарын харилцааг нэмэгдүүлэхийн тулд агаарын тээврийн компаниудтай хамтран ажиллах.
- Зочлох үйлчилгээ: Солонгосын жуулчдын хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэн зочлох үйлчилгээ, байрыг сайжруулах.
- Дижитал маркетинг: Аялал жуулчлалын төлөвлөлтийн явцад солонгос жуулчдад чиглэсэн хайлтын системийг оновчтой болгох (SEO), (PPC) зар сурталчилгаа,

агуулгын маркетинг зэрэг дижитал маркетингийн стратегийг ашиглах, Солонгосын жуулчдыг татахын тулд Монголын онгон дагшин байгаль, нүүдэлчин соёл иргэншил, замаас хол давсан туршлага гэх мэт өвөрмөц борлуулалтын цэгүүдийг онцлон тэмдэглэх.

- Аюулгүй байдал: Аюулгүй байдлын зохих арга хэмжээг хэрэгжүүлэх, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, солонгос хэлээр аялах зөвлөмж, мэдээллийг түгээх замаар Солонгосын жуулчдын аюулгүй байдлыг хангах. Солонгос аялагчдын дунд итгэлцэл, итгэлцлийг бий болгох нь давтан зочлох, амнаас ам дамжих эерэг мэдээллийг түгээхэд чухал ач холбогдолтой.
- Тогтвортой аялал жуулчлалын туршлага: Монгол орны байгаль, соёлын өвийг хойч үедээ хадгалж үлдэхийн тулд тогтвортой аялал жуулчлалын туршлага, хариуцлагатай аялал жуулчлалын санаачлагыг онцлох. Солонгосын жуулчдын үнэт зүйл, ашиг сонирхолд нийцсэн байгальд ээлтэй аялал жуулчлалын үйл ажиллагаа, олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлалын төсөл, байгаль хамгаалах хүчин чармайлтыг сурталчлах.

Эдгээр стратеги, санаачилгыг хэрэгжүүлснээр Монгол Улсад ирэх Солонгос жуулчдын тоог үр дүнтэй нэмэгдүүлж, улмаар аялал жуулчлалын зах зээлээ төрөлжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, Монгол, Өмнөд Солонгосын соёлын солилцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломжтой юм.

Ашигласан материал

- Галиймаа.Н. 2013. *Олон улсын аялал жуулчлал*. Жиком пресс ХХК. Улаанбаатар хот
- Philip Kotler, John T.Bowen & James C. Makens. 2011. *Marketing for Hospitality and Tourism*. 5th edition. Prentice hall. Pearson education.
- The Mongolian Tourism Association & The Competitiveness Initiative. (2022). *International tourism survey*. Ulaanbaatar.
- БОАЖЯ, Дэлхийн банк., 2010. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхэтгэл. Улаанбаатар хот.
- Гансүх.Д, Гантөмөр.Д, Цэрэн.Г, Милингтон.К, Орсоо.О, Ватмоуг.В & Вингстен.Ж. 2012. *Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлийн эдийн засгийн ач холбогдол*. Хэлэлцүүлгийн баримт бичиг. Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой хөгжлийн департамент. Дэлхийн банк. Вашингтон хот.
- ДЭЗФ. (2019). *Дэлхийн өрсөлдөх чадварын илтгэлүүд*.
- Монгол Улсын Улсын Их Хурал. 2023. *Аялал жуулчлалын тухай Монгол Улсын хууль*. Улаанбаатар хот.
- Монгол Улсын Засгийн Газар. 2015. *Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр*. Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоолын хавсралт. Улаанбаатар хот.
- Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. 2010. *Аялал жуулчлалын статистик тооцох аргачлал*. ҮСХ-ны даргын 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/9 тоот тушаалын хавсралт. Улаанбаатар хот.

- Монгол Улс. 2019. *Аялал жуулчлалыг өргөжүүлэх, эдийн засгийн цаашидын хөгжлийг хангахын тулд байгалийн болон соёлын өв хөрөнгийн менежментийг бэхжүүлэх.* Улаанбаатар хот.
- Монгол банк. Аялал жуулчлалын үндэсний төв. 2019. *Монгол Улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа.* Улаанбаатар хот.